



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН**

**18 ТАЛААРХ
дахь илтгэл**

Улаанбаатар хот
2019 он



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН
ТАЛААРХ 18 ДАХЬ ИЛТГЭЛ**

Улаанбаатар хот
2019 он

ННА: 94
ДАА: 080
М-692

Цаасны хэмжээ: 145x205 мм

Хэвлэлийн хуудас: 18.0 х.х

Хэвлэсэн тоо: 1500 ширхэг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Тусгаар тогтнолын талбай Засгийн газрын XI байр, 5 давхар

Цахим хуудас: www.nhrcm.gov.mn

Цахим шуудан: info@nhrcm.gov.mn

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-99978-964-9-0

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ.....		9
1.1	Хүний эрхийн боловсролын талаарх олон улсын бодлогын хүрээ, санаачилга.....	13
1.2	Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын бодлого, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал.....	15
1.3	Албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол.....	22
1.4	Албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол.....	39
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН АСУУДАЛ.....		61
2.1	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах төрийн үүрэг.....	62
2.2	Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал.....	70
2.2.1	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл авч буй байдал, мэдлэг, хандлага.....	71
2.2.2	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдал.....	77
2.2.3	Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгсэл, түүний хэрэглээ.....	83
2.2.4	Жирэмслэлт, үр хөндөлт.....	88
2.2.5	Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал.....	95
ГУРАВДУГААР БҮЛЭГ. АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....		107

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....139**

4.1 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг
бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж
шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилт 140

4.2 Монгол Улс дахь эрүү шүүлтийн өнөөгийн
нөхцөл байдал 148

4.3 Эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг
нөхөн төлүүлэх нь 162

4.4 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт 166

**ТАВДУГААР БҮЛЭГ. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН
АЛБА ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ 171**

5.1 Хөдөлмөрийн аятай, таатай нөхцөлөөр хангагдах эрх173

5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал.....177

5.3 Эрүүл мэндээ хамгаалуулах эрх.....183

5.4 Ажлын цаг, цалин хөлс.....188

5.5 Дүрэмт хувцасны хангалт192

5.6 Сурч боловсрох эрх.....196

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРИЙН
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ
БАЙДАЛ.....199**

6.1 Монгол Улсын Их Хурал.....200

6.2 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс.....203

6.3 Төрийн албаны зөвлөл208

6.4 Үндэсний статистикийн хороо.....212

6.5 Монгол Улсын Засгийн газар.....215

6.6 Нутгийн захиргааны байгууллага.....221

6.7 Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд.....229

ХАВСРАЛТ

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх
16 дахь илтгэлтэй холбогдуулан гаргасан Улсын Их Хурлын
Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт235

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААР ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР
ӨГЧ БҮЙ САНАЛ.....283**

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 18 ДАХЬ ИЛТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Комисс нь тухайн жилийн хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг тодорхойлж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн барьдаг билээ.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг “Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын талаарх бодлого, түүний хэрэгжилт”, “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал”, “Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”, “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал” гэсэн үндсэн 6 сэдвийн хүрээнд боловсруулав.

Энэ удаагийн ээлжит илтгэлийг Комиссын 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцсэний дагуу Комиссын стратеги төлөвлөгөө, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хийсэн хяналт шалгалт, судалгаа, иргэдээс Комисст гаргасан өргөдөл, гомдол, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, иргэний нийгмийн болон бусад байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, дүн шинжилгээ, Засгийн газар, яам, агентлаг болон бусад байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар 25 санал хүргүүлж байна.

Нэгдүгээр бүлэг. Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын талаарх бодлого, түүний хэрэгжилт

Хүний эрхийн боловсролын агуулга нь Монгол Улсад сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол, мөн насан туршийн боловсролын үндэсний сургалтын бодлого, хөтөлбөрт хэрхэн туссан байгаад дүн шинжилгээ хийлээ. Түүнчлэн хүний эрхийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын тайлан, мэдээллийн эх сурвалжид үндэслэн албан болон албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын бодлого, түүний хэрэгжилтийн байдлыг тодорхойлон гаргаж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсрууллаа.

Хоёрдугаар бүлэг. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг хангах нь төрийн үүрэг тул тулгамдаж буй асуудлыг тоо баримт, судалгааны үндэслэлтэйгээр баримтжуулж, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагч, олон нийтийн анхааралд хүргэх шаардлагын үүднээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн санал, дэмжлэгтэйгээр аймгуудад хийсэн хяналт шалгалт, судалгааны үр дүнг энэхүү бүлэгт тусгав.

Гуравдугаар бүлэг. Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал

Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдлын талаар ХЭҮК, Шихихутуг их сургуультай хамтран хийсэн судалгааны тайлан, уг асуудлаар Комисст ирүүлсэн гомдлыг шалган шийдвэрлэсэн дүн шинжилгээ болон энэ чиглэлээр

мэргэшсэн төрийн бус байгууллагын хийсэн харьцуулсан судалгаа, дүн шинжилгээний тайлан зэрэгт үндэслэн энэ бүлгийг бэлтгэв.

Дөрөвдүгээр бүлэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Энэ бүлэгт Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл болон Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Засгийн газарт өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт болон эрүү шүүлтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар тусгалаа. Мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага болон эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан байгууллага байхгүйн улмаас эрүү шүүлттэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаа талаар тусгасан болно.

Тавдугаар бүлэг. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт

Онцгой байдлын байгууллагад ажиллаж буй алба хаагчдын ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, эрүүл мэндээ хамгаалуулах, амрах, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн аятай таатай нөхцөлөөр хангуулах зэрэг эрхийн хэрэгжилтийн талаар аймгууд дахь Онцгой байдлын газар болон Үндэсний аврах бригадыг хамруулан зохион байгуулсан хяналт шалгалт, судалгааны ажлын дүн, тус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, алба хаагчидтай хийсэн ярилцлагыг үндэслэн тус бүлгийг боловсруулав.

Зургадугаар бүлэг. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд тусгасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын хоёр жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, олж авсан ололт амжилт, ахиц дэвшил, зөрчил, дутагдлыг судалсны үндэслэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг энэхүү бүлэгт дүгнэв.

I

БҮЛЭГ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

“Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн нийтлэг хэм хэмжээ, зарчим, үнэт зүйлс, хамгаалалтын механизмыг багтаасан мэдлэг, ойлголт бөгөөд боловсролын бүх түвшинд, бүх насны хүмүүст хамааралтай хүний эрхийг хөхиүлэн дэмжих, сахин хамгаалах мэдлэг, чадвар, хандлага, зан үйлийг төлөвшүүлэх насан туршийн үйл явц юм.¹

Иймд олон улсын хамтын нийгэмлэг нь аливаа улсын иргэд, нийгмийн гишүүд олон ургалч үзэл, хандлагаар асуудалд хандаж, бие даан шийдвэр гаргах чадвартай, ардчилсан нийгмийн үнэт зүйлс, үндэстнүүдийн соёл, уламжлалын ялгаатай байдалд хүлээцтэй ханддаг, зан байдал, ёс суртахууны хувьд эерэг хандлагатай байх хүний эрхийн соёлыг бий болгох зорилго бүхий хүний эрхийн боловсролыг чухалчлан үзэж байна.

Хүн бүрийн эрх, эрх чөлөөг бодитой эдлүүлэхийн тулд боловсрол, сургалт, суралцахуйн бүх хэлбэр, мэдээлэл, харилцааны технологи, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, урлагийн төрлөөр дамжуулан хүний эрхийн мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих олон тооны санал санаачилга өрнөж байна.

Комисс нь Монгол Улсын хүний эрхийн боловсролд холбогдох бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2007, 2008, 2015 оны илтгэлүүдэд тусгаж, албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах тухай 9 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн байдаг. Гэвч төрөөс хүний эрхийн боловсролын

¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2012 оны 2 дугаар сарын 19-ний өдөр A/Rev/66/137 дугаар тогтоолоор баталсан Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхагнал.

талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх, их, дээд сургуулийн магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд тусгах, хүний эрхийн боловсролын талаар иргэний нийгмийн болон боловсролын байгууллагуудын үүсгэл санаачилгыг дэмжих, оролцогч талуудын хамтын ажиллагааг тогтмолжуулах зэрэг асуудлаар гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд бодитой ахиц дэвшил гараагүй хэвээр байна.

Иймд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн баталсан Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн "Хүний эрхийн боловсрол-2020"² олон улсын иргэний нийгмийн эвслээс боловсруулсан хүний эрхийн боловсрол, сургалтын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийн дагуу Монгол Улсын боловсролын салбарын 20 гаруй хууль, дүрэм журам, хөтөлбөрт шинжилгээ хийн, хүний эрхийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, олон улсын 30 гаруй байгууллагын тайлан, мэдээллийн эх сурвалжид үндэслэн албан болон албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын бодлого, түүний хэрэгжилтийн байдлыг тодорхойлон энэ бүлгийг боловсруулав.

² "Хүний эрхийн боловсрол-2020" олон улсын иргэний нийгмийн эвсэл нь 2013 оны 12 дугаар сард байгуулагдсан бөгөөд эвслийн үндсэн гишүүд нь "Эмнести интернэшнл", "Хүний эрхийн боловсролын холбоо", "Сока Гаккай интернэшнл" болно. Эвсэл нь хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих, чадавхжуулахын тулд улс орнуудын Засгийн газарт дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг.
http://www.hre2020.org/sites/default/files/Human%20Rights%20Education%20Indicator%20Framework_0.pdf

1.1 Хүний эрхийн боловсролын талаарх олон улсын бодлогын хүрээ, санаачилга

Хүний эрхийн боловсролын агуулга, зарчмын талаар олон улсын эрх зүйн хэд хэдэн баримт бичигт³ тодорхойлсон бөгөөд үүнээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2012 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/REV/66/137 дугаар тогтоолоор баталсан “Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал” нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжихэд хүний эрхийн боловсрол, сургалт чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрч, олон улсын хэм хэмжээг тогтоож өгсөн байна.

Тунхаглалын 2, 3 дугаар зүйлд тодорхойлсноор хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, бүх нийтээр хүндэтгэхийг дэмжихэд чиглэсэн боловсрол, сургалт, мэдээлэл, суралцахуйн бүх үйл ажиллагааг ойлгоно. Энэ нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхүйц мэдлэг ойлголт, чадвартай болж, өөрийн зан үйл, хандлагаа төлөвшүүлэх, улмаар хүний эрхийн соёл бий болгох, хөхиүлэн дэмжихэд хүн бүр хувь нэмрээ оруулахад чиглэнэ.

Хүний эрхийн боловсролын хүрээнд олон улсын хамтын нийгэмлэгээс гаргасан томоохон санаачилгын нэг нь 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 59/113

³ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйл, Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 7 дугаар зүйл, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 10 дугаар зүйл, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 10 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 10 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 4, 8 дугаар зүйл, Венийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр хэсгийн 33–34 дүгээр бүлэг, 2 дугаар хэсгийн 78–82 дугаар бүлэгт заасан байна.

дугаар шийдвэрээр баталсан Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр юм.

Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн нэгдүгээр үе шат⁴ (2005–2009 он) бага, дунд боловсролын тогтолцоонд чиглэж, ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн боловсрол олгохыг дэмжих, эрхэд суурилсан чанартай боловсролд цогц байдлаар хандахад эрмэлзсэн байдаг. Уг хөтөлбөрийн нэн тэргүүний зорилт нь 2005–2007 онд багтаан улс орнууд ерөнхий боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгож буй үйл ажиллагаандаа үнэлгээ хийх, хүний эрхийн боловсролын талаар хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх явдал байсан тул Комисс уг үнэлгээг үндэсний хэмжээнд хийж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2007 оны илтгэлд тусгаж байв.

Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн хоёрдугаар үе шат⁵ (2010–2014 он) нь гишүүн орнууд өмнөх үе шатны зорилтоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн хамт дээд боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол буюу төрийн албан хаагч, хууль сахиулагч, цэргийн албан хаагчдад зориулсан хүний эрхийн сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн байв. Хөтөлбөрийн гуравдугаар үе шат⁶ (2015–2019 он) нь нэг, хоёрдугаар

⁴ 2005 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн (A/59/525/Rev.10) шийдвэр <http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N05/253/74/PDF/N0525374.pdf?OpenElement>

⁵ 2010 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн (A/HRC/15/28) шийдвэр. <http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G10/151/48/PDF/G1015148.pdf?OpenElement>

⁶ 2013 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн (A/HRC/27/28) шийдвэр. <https://www.ohchr.org/en/issues/education/training/wphre/thirdphase/pages/thirdphaseindex.aspx>

шатны ололт амжилтаа бататган сайжруулахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, сэтгүүлчдэд зориулсан хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжихэд чиглэж байна.

Дэлхий нийтийн хөгжлийн суурь баримт бичиг “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”⁷-ийн 17 зорилго, 169 зорилтын нийт 90 орчим хувь нь боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрлөх эрх, жендэрийн тэгш байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах зэрэг хүний эрхийн асуудалд хамаардаг. Тус хөтөлбөрийн зорилго 4-т хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан туршийн сурч боловсрох боломжийг бүрдүүлэх талаар тодорхойлж, мөн зорилтын 7-д “2030 он гэхэд бүх суралцагчид тогтвортой хөгжлийн болон тогтвортой амьдралын зан үйл, хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайванч болон хүчирхийллийн бус соёл, дэлхийн иргэншил болон соёлын олон янз байдал, тогтвортой хөгжилд соёлын оруулах хувь нэмэр зэрэг тогтвортой хөгжлийг түргэсгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх нөхцөлийг хангах” гэж заасан нь зөвхөн ур чадварыг онцлохгүйгээр үнэт зүйлс, цогц чадамжийг хамтатган тодорхойлж өгснөөрөө онцлог байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн комиссын 2017 оны 48 дугаар чуулганаар Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.⁸ Үүнээс чанартай боловсролыг дэмжих 4 дэх зорилгын 4.7 дахь дэд зорилтын 4.7.1-ийн шалгуур үзүүлэлтийг “(i) Дэлхийн

⁷ 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн (A/70/L.1) тогтоол.

⁸ 2017 оны 3 дугаар сарын 7-10-ны өдрүүдэд болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн комиссын 48 дугаар чуулганы (E/CN.3/2017/2) шийдвэр
<https://unstats.un.org/unsd/statcom/48th-session/documents/2017-2-IAEG-SDGs-E.pdf>

иргэний боловсрол, жендэрийн тэгш байдал, хүний эрхийн асуудлыг хамруулсан (ii) тогтвортой хөгжлийн боловсролыг (a) үндэсний боловсролын бодлого, (b) сургалтын хөтөлбөр, (c) багш нарын боловсрол болон (d) суралцагчийн үнэлгээнд тусгасан байдал”-аар тодорхойлохоор заажээ.

Иймээс Тогтвортой хөгжлийн 4.7 дахь дэд зорилтыг хэрэгжүүлэх, үүгээр дамжуулан тогтвортой хөгжилд хүн бүрийн хувь нэмрийг оруулах, хүн бүр оролцох боломжийг бүх түвшинд бүрдүүлэхэд хүний эрхийн боловсрол, сургалтын үүрэг, ач холбогдлыг чухалчлан үзэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

1.2 Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын бодлого, түүний хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

Монгол Улсын боловсролын агуулга, зарчим, сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай зэрэг хуулиар тус тус зохицуулж байна. Эдгээр хууль тогтоомжид тодорхойлсноор боловсрол нь аливаа ялгаварлан гадуурхалтгүй, тэгш боломж нөхцөлийг бүрдүүлсэн, бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй байх, боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй зэрэг боловсролын үндсэн зарчмуудад тулгуурлан ард иргэдийг бие даан сурч, ажиллаж, амьдрахад зохих оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдрын ур чадварыг эзэмшүүлэх зорилготой юм.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад боловсролын тогтолцоо⁹ нь албан ба албан бус боловсролын нэгдэл

⁹ Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1

байх бөгөөд сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролоос бүрдэж байна. Үүнээс “албан боловсрол” гэж боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг, “албан бус боловсрол” гэж боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагааг, “насан туршийн боловсрол” гэж бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагаа хэмээн тус тус тодорхойлжээ.¹⁰

Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталж, хөтөлбөрийн 1.1.2.6-д “Хүний эрхийн боловсролын төлөв байдал, хэрэгцээ шаардлага, хамрах хүрээг судалсны үндсэн дээр хүн ам, төрийн албан хаагчид, удирдах ажилтан, бүх шатны сургуулийн сурагч, оюутны хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлж, энэ асуудлаар үндэсний мэргэжилтэн, сургагчдыг бэлтгэх дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Гэвч хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлэх, хүний эрхийн боловсролын дэд хөтөлбөр батлах талаар ямар нэгэн санаачилга гаргаж, тодорхой арга хэмжээ авалгүй өнөөдрийг хүрчээ.

Засгийн газрын 2010 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор баталсан “Боловсрол” үндэсний хөтөлбөрт Монгол Улсын боловсролын салбарын 2021 он хүртэл хэрэгжүүлэх стратегийн 6 зорилтыг¹¹

¹⁰ Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1.6, 3.1.7, 3.1.20

¹¹ 1.Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх;

дэвшүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг тодорхойлсон ч хүний эрхийн боловсролын агуулгыг тусгаагүй байна. Хүний эрхийн боловсролын агуулга нь тухайлан “хүний эрх” гэсэн хэлц үгээр илрэх албагүй бөгөөд бодлогын зорилтууд, хэрэгжүүлэх арга хэрэгсэл, шалгуур, хүрэх үр дүн нь хүний эрхэд суурилсан байх нь хүний эрхийн хэм хэмжээг нийгмийн харилцаанд ялангуяа боловсролын тогтолцоонд төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Улсын Их Хурлын 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014–2024 он)”-ыг баталж, уг баримт бичгийн 2.1.4-т төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ “Хүний эрх, эрх чөлөө, нэр төр, эрдмийн эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлс, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлыг хүндэтгэх” зарчмыг баримтлахаар тодорхойлжээ. Гэвч уг бодлого дахь боловсролын зорилго, зорилт, хөгжлийн стратеги болон агуулга, стандарт, сургалтын технологи, чанарын үнэлгээ, бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт зэрэгт хүний эрхийн боловсролыг тусгаагүй, тавьсан зорилгыг хэрэгжүүлэх арга зам нь хүний эрхэд суурилагүй байна.

2.Бүх түвшний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

3.Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин, урамшуулал, нийгмийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

4.Боловсролын тогтолцоог боловсронгуй болгон олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүрэг, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх;

5.Иргэд боловсролоо сайжруулж, ажил мэргэжлээрээ хөрвөн суралцаж байх бодит боломж олгосон боловсролын нээлттэй агуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгох;

6.Сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг шинэчлэн мөрдөх.

Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.7 дахь зорилтын дагуу Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14–ний өдрийн 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ. Тус хөтөлбөрийн 1 дэх зорилт “Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно”, мөн хөтөлбөрийн 6.4.5–д “бүх шатны боловсролын байгууллага, гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагаар дамжуулан хүүхэд, залуучуудад эрх зүйн болон хүний эрхийн боловсрол олгох, эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх”, 6.4.6–д “бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай судалгаа хийх” талаар тус тус зааж, хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээх, иргэд олон нийтийг чадавхжуулах, хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр сургалт, сурталчилгааны агуулгыг тусгасан нь сайшаалтай болсныг тэмдэглэж байна.

Дээр дурдсанчлан, Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрууд үндэсний стратеги боловсруулах, түүний хэрэгжилт, хяналт, үнэлгээг зохицуулах үүрэг бүхий бүтцийг байгуулах, уг бүтэц нь холбогдох яамд, үндэсний бусад оролцогч талууд, тухайлбал, хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахыг тодорхой заажээ. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрт зааснаар гишүүн орнууд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагынхаа дэргэд хүний эрхийн боловсрол, сургалтыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий нэгж байгуулах үүрэг хүлээжээ.

Гэвч Монгол Улсад одоог хүртэл энэ хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах бүтэц, нэгж байхгүй бөгөөд хэрэгжилтийн

талаарх тайлан, мэдээллийг хүргүүлээгүй байна. Тухайлбал, 2006 оны 1 дүгээр сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын ерөнхий захирал нар хамтран Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орнуудын боловсролын сайд нарт хандан, Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, улмаар хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагад мэдээлэл, тайлан илгээх чиг үүрэг бүхий үндэсний зохицуулах бүтэц байгуулахыг уриалжээ.

Гэвч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газраас 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн албан захидалд¹² “Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдад хандаж Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны үйл ажиллагааны тайланг илгээхийг хүссэн боловч хариу ирүүлэхгүй байх тул танайд хандлаа. Монгол Улс хүний эрхийн боловсролыг бага, дунд сургуулийн тогтолцоонд нэвтрүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч байгаа талаар 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газарт ирүүлэх шаардлагатай байгааг анхаарч, улсынхаа боловсролын яаманд уламжилна уу” гэсний дагуу Комиссоос 2008 оны 3 дугаар сарын 25-ны

¹² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газраас Комисст ирүүлсэн 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн албан захидал болон Комиссоос Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайдад 2008 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн 86 дугаар албан бичиг.

өдрийн 86 дугаар албан бичгээр тухайн үеийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдад хандсан болно.

Гэвч Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн нэг, хоёрдугаар үе шатны хэрэгжилтийн үндэсний тайлангаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газарт хүргүүлсэн улс орнуудын жагсаалтад Монгол Улс ороогүй байгаа нь¹³ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээсэн үүргээ биелүүлэлгүй, хойрго хандаж ирснийг баталж байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газраас Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн гуравдугаар үеийн дунд шатны үнэлгээг 2017 онд хийхдээ гишүүн орнууд үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд гарсан ахицыг үнэлж, холбогдох мэдээллийг илгээхийг хөтөлбөрт заасан хэдий ч Монгол Улс энэхүү дунд шатны үнэлгээг хийж, тайлан хүргүүлсэн талаарх мэдээлэл байхгүй байна.

Тус хөтөлбөрийн гуравдугаар үе шат 2019 оноор дуусгавар болж, 2020 оны эхний улиралд улс орон бүр хүний эрхийн боловсролын үйл ажиллагаагаа үнэлж дүгнэн үндэсний үнэлгээний тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газарт илгээх, Хүний эрхийн дээд комиссарын газар нэгтгэсэн тайланг Хүний эрхийн Зөвлөлд 2020 онд багтаан өгөх товтой юм. Иймд Монгол Улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орны хувьд Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн гуравдугаар үе шатны тайлан мэдээллээ хугацаанд нь хүргүүлэх шаардлагатай байна.

¹³ <https://www.ohchr.org/EN/Issues/Education/Training/WPHRE/FirstPhase/Pages/EvaluationWPHRE.aspx>;
<https://www.ohchr.org/EN/Issues/Education/Training/WPHRE/SecondPhase/Pages/SecondphaseEvaluation.aspx>

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2008–2015 онд боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн, хэрэгжиж байгаа 17 үндэсний хөтөлбөртөө үнэлгээ хийж, “Боловсрол” үндэсний хөтөлбөрт тодорхойлсон 10 зорилт, 102 арга хэмжээний хэрэгжилт 97.3 хувьтай¹⁴ гэж үзсэн нь бодит байдалд нийцэж байгаа эсэх нь анхаарал татаж байна. Харин Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2017 онд “Боловсрол” үндэсний хөтөлбөрт үнэлгээ хийжээ. Үнэлгээний дүнгээс үзэхэд боловсролын салбарын хөтөлбөр, стандартууд төсвийн хамт батлагддаггүй, эрх мэдэл нь дээд, дунд шатанд төвлөрч, сурах орчны шаардлага, стандартыг салбарын болон орон нутгийн төсвийн төсөөллийг боловсруулж батлуулахад харгалзан үздэггүй зэргээс тус хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна. Мөн төрийн байгууллагын албан тушаалтнууд холбогдох эрх зүйн баримт бичгээ сайн судлаагүй, мэдээлэл өгөхөд бэлэн биш байсныг анхаарах шаардлагатай байна.¹⁵

Цаашид боловсролын салбарын бодлого, төлөвлөлтийг “Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр” болон “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”-ийн зорилго, зорилтод нийцүүлж уялдуулах, ялангуяа шинээр боловсруулж буй Боловсролын салбарын мастер төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролыг үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх, мөн багш нарын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх давтан сургалт болон

¹⁴ <https://mecss.gov.mn/media/uploads/bacf8c28-ab7d-4ed9-88fe-c5368f3824ec.pdf> цахим хуудас, 2017 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр.

¹⁵ <http://www.irgen-tur.mn/sites/default/files/documents/Education%20Standard.pdf>

“Боловсролын үндэсний хөтөлбөрүүд, сургуулийн үйлчилгээний орчны стандартын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан” “Тунгаамал төв” төрийн бус байгууллага, УБ, 2017 он.

ажил, албан тушаал дэвшихэд харгалзах шалгуур үзүүлэлт болгох зэрэг зохицуулалт хийж, санаачилга гарган ажиллах хэрэгтэй байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д дэвшүүлсэн 4 зорилт нь боловсролтой шууд хамааралтай байна.¹⁶ Иймд эдгээр зорилтыг хангахын тулд хүний эрхийн боловсрол, сургалтаар дамжуулан хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж, бодлогын баримт бичиг, түүний хөтөлбөр, төлөвлөгөө, хяналт үнэлгээ зэрэгт хүний эрхийн боловсролыг нарийвчлан тусган оруулах нь зүйтэй юм.

1.3 Албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглалын 8 дугаар зүйлийн 1-д “Улсууд нь зохих түвшинд стратеги, бодлогыг хөгжүүлэх, тохиромжтой бол хүний эрхийн боловсрол, сургалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг сургуулийн болон сургалтын хичээлийн хөтөлбөрт нийлүүлэх замаар боловсруулах буюу хөхиүлэн дэмжинэ. Ингэхийн тулд Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг

¹⁶ Зорилт 1. Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ.

Зорилт 2. Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.

Зорилт 3. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.

Зорилт 4. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно.

үндэсний болон орон нутгийн тусгай хэрэгцээ, тэргүүлэх чиглэл болгоход анхаарал тавих ёстой” гэжээ.

Ийнхүү бүх шатны сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн, шинэчлэн сайжруулахыг олон улсын хамтын нийгэмлэгээс зөвлөж буй тул Монгол Улсын албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын агуулга нь үндэсний сургалтын бодлого, хөтөлбөрт хэрхэн туссан талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар эзэмшүүлэх зорилготой юм.¹⁷

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулгыг хэрэгжүүлэх 4 зорилтоос дараах зорилт нь хүний эрхийн агуулгад илүү нийцэж байна.¹⁸ Үүнд:

- хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах.

Сургуулийн өмнөх боловсрол, сургалтын байгууллагууд Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр,¹⁹ суралцахуйн 6 чиглэлийн²⁰ дагуу үзэл баримтлалаа

¹⁷ Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1

¹⁸ Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1

¹⁹ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/301 дүгээр тушаал.

²⁰ “Хөдөлгөөн, эрүүл мэнд”, “Зан чанар, харилцаа”, “Хэл яриа”, “Байгаль, нийгмийн орчин”, “Математикийн энгийн төсөөлөл”, “Хөгжим, дүрслэх урлаг”.

боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байна. Сургуулийн өмнөх боловсролын агуулгад хүний эрхийн боловсролыг тусгайлан заагаагүй бөгөөд харин зан чанар, харилцааны дараах чадварыг хүүхдэд эзэмшүүлдэг байна. Үүнд:

- Өөрийгөө мэдрэх, ойлгох;
- Орчны өөрчлөлтөд дасах;
- Сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой илэрхийлэх;
- Бусдыг мэдэрч ойлгох;
- Насанд хүрэгчидтэй харилцах;
- Үеийн хүүхдүүдтэй харилцах;
- Бусад хүүхэдтэй тоглох, хамтрах;
- Хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах;
- Дүрэм журмыг ойлгох, мөрдөх.

Энэ нь Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зааварчилгаатай нийцсэн хөтөлбөр төлөвлөлт²¹ боловч уг хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тодорхой мэдээлэл байхгүй байна. Бага наснаас нь эхлэн зөв харилцаа, хүний эрхийн мэдлэг, хандлагатай болгох нь хариуцлагатай, хууль ёс, хүний эрхийг хүндэтгэдэг иргэн болон төлөвших үндэс суурь болох учиртай юм. Иймд сургуулийн өмнөх боловсролын багш хүүхэд бүрийн онцлог, хөгжлийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүн бүрт хүндэтгэлтэй хандаж, ялгаварлан гадуурхахгүй, тэдний зан харилцааны төлөвшилд анхаарч ажиллах нь чухал билээ. Гэвч цэцэрлэгийн насны хүүхдийн эрх зөрчигдөж байгаа талаар Комисст гомдол ирсээр байна.

²¹ Eds. Nancy Flowers, Human Rights Here and Now, January 1, 1999.
<http://hrlibrary.umn.edu/edumat/hreduseries/hereandnow/Default.htm>

Тохиолдол 1

...аймгийн ...сумын цэцэрлэгийн дунд бүлэгт суралцдаг 3 настай хүү ангидаа халуун цайгаа асгаснаас болж багш нь түүнийг “хажуудах хүүхдээ түлэх шахлаа, сахилгагүй, гайтай хүүхэд, өөр ангид өгдөг ч болоосой” хэмээн загнажээ. Эмээ нь хүүг цэцэрлэгээс авах гэж иртэл хүү айдаст автсан, гэмшсэн байдалтай байжээ.

Улмаар эцэг эхийн хурал дээр хүү цай асгасан талаар яригдаж, “танай хүү угаас сахилгагүй, хүмүүжилгүй, та нар хүүхдээ байнга өмөөрдөг, танай хүүхэд цай асгасан нь миний буруу биш, та нар хэлдэг газар нь хэлээрэй” гэх мэтээр багш, эцэг эх, хүүхдийн хоорондын зөрчил болон гүнзгийржээ. Хэдийгээр халуун цайнд хүүхэд түлэгдээгүй боловч ангийн багш нь тухайн хүүг ад шоо үзэн муухай харилцаж байгаа нь хүүгийн гэр бүлд дарамттай төдийгүй хүүхэд дахин цэцэрлэгтээ явах сонирхолгүй болсон байна. Энэ асуудлаар цэцэрлэгийн эрхлэгчид гомдол гаргасан боловч өргөдлийн хариуг өгөхгүй удаж, шийдвэрлэхгүй байна.

Комисст ирүүлсэн гомдлоос, 2018 он

Иймд сургуулийн өмнөх боловсролын салбарт хүний эрхийн боловсролын үр нөлөөтэй үйл ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд цэцэрлэгийн багш нар хүний эрхийн мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагаар үйл ажиллагаа төлөвлөх, хүүхэд бүрт хүрч ажиллах, өөртөө болон хүүхдэд хөгжих, суралцах боломжийг бүрдүүлэх, хүний эрхийн боловсролын хэрэглэгдэхүүн, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, хүний эрхэд холбогдох цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйн үнэлгээг хийх шаардлагатай байна.

Ерөнхий боловсрол

Бага боловсрол нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсрол нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсрол нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх зорилготой юм.²²

Бага боловсролын агуулга нь нийт 8 зорилт дэвшүүлснээс дараах 3 зорилт нь хүний эрхийн боловсролын агуулга, зарчимд илүүтэй нийцэж байна.²³ Үүнд:

- гоо зүй, хүмүүнлэг, үндэсний дэвшилт ёс заншил, соёлын өв уламжлал, эрүүл ахуйн зохих шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэх;
- өөрийн болон бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, үнэнч шударга, хамтач байдлыг эрхэмлэх үзэл төлөвшүүлэх;
- зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох.

Суурь боловсролын агуулга нь нийт 5 зорилт дэвшүүлснээс дараах 3 зорилт нь хүний эрхийн боловсролын агуулга, зарчимд илүүтэй нийцэж байна.²⁴ Үүнд:

²² Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1

²³ Бага, дунд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1

²⁴ Бага, дунд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1

- гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх;
- эрүүл аж төрөх ёс, гэр бүлийн амьдралын анхан шатны ойлголт, соёлын төсөөлөл эзэмшүүлэх;
- хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох.

Бүрэн дунд боловсролын агуулгад нийт 4 зорилт дэвшүүлснээс дараах зорилт нь хүний эрхийн боловсролын агуулга, зарчимд илүүтэй нийцэж байна.²⁵ Үүнд:

- бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Үүнтэй холбогдуулан “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”²⁶, “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”²⁷, “Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр”²⁸-ийг тус тус баталсан байна. Эдгээр сургалтын цөм хөтөлбөрт бага боловсролын түвшинд “Хүн ба нийгэм”, суурь боловсролын түвшинд “Нийгмийн ухаан”, бүрэн дунд боловсролын түвшинд “Нийгмийн ухаан” зэрэг сургалтын хөтөлбөрт хүний эрхийн агуулга туссан байна.

²⁵ Бага, дунд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1

²⁶ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн А/240 дүгээр тушаал.

²⁷ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2016 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/302 дугаар тушаал.

²⁸ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/277 дугаар тушаал.

Сургалтын хөтөлбөрийн агуулга, төлөвлөгөөний дагуу хүний эрхийн боловсрол олгож буй цаг, эзлэх хувийг доорх хүснэгтээс харж болно. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон сургалт дэмжих үйл ажиллагааг сурагчдын хүсэл сонирхол, хэрэгцээнд тулгуурлан сургууль бүр өөрийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж байна.²⁹

Хүснэгт 1. Сургалтын хөтөлбөрийн агуулга, төлөвлөгөөний дагуу хүний эрхийн боловсрол олгож буй цаг, эзлэх хувь

Бага боловсрол		Нийгэм судлал		Иргэний боловсрол	Түүх	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
Хүн ба орчин	Хүн ба нийгэм	Заавал судлах	Сонгон судлах			
I-III анги:	IV-V анги:	VI-IX анги:	X-XII анги:	I-IX анги:	VI-XII анги:	I-IX анги:
6 цаг	8 цаг	18 цаг	27 цаг	9 цаг	9 цаг	9 цаг
17 хувь	22 хувь	25 хувь	19 хувь	12 хувь	25 хувь	25 хувь

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн “Сургалтын төлөвлөгөө батлах тухай” А/61 дүгээр тушаалаар ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд заавал судлах, сонгон судлах хичээлийг тодорхойлоход “Иргэний боловсрол” хичээл хасагдаж, “Нийгэм судлал” хичээлийг сонгон судлахаар болжээ. Мөн сайдын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/453 дугаар тушаалаар баталсан ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа”-ны цаг хасагдсан байна.

Үүнээс харахад ерөнхий боловсролын сургалтын тогтолцоонд “Хүний эрх” гэсэн бие даасан хичээл байхгүй, зөвхөн нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн “Эрх зүй”

²⁹ Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын мэдээлэл, 2018 он.

сэдвийн хүрээний судлагдахуун болгож бага, суурь болон бүрэн дунд боловсролын ангиудад судлуулахаар тусгажээ. Ялангуяа бүрэн дунд боловсролоор суралцагчдад мэдлэг, чадвар олгохдоо эрх зүйн, эсвэл иргэний боловсролтой байвал зохино гэж боловсролын агуулгыг явцуу хүрээнд тодорхойлсон нь учир дутагдалтай юм. “Иргэний боловсрол” хичээлийн агуулгад хүний эрх, ардчилал, оролцооны талаар оруулсан ч сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн байнга өөрчлөгдөж байгаагаас суралцагчдад цогц мэдлэг олгох, багш нар мэргэжлийн ур чадвар, арга зүйгээ сайжруулах зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Багш нар болон суралцагчид хүний эрхийн хангалттай мэдлэг, ойлголт, хүний эрхийг хүндэтгэх хандлага, төлөвшилтэй болж чадахгүй байгаагаас өсвөр насны хүүхдүүд бие махбодын шийтгэл, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт зэрэгт өртсөн тухай нийгмийг очроосон хэрэг, зөрчил гарсаар байна.

Тохиолдол 2

Хэнтий аймгийн “Бор өндөр” цогцолбор сургуулийн 11 дүгээр ангийн суралцагч Б багшдаа цохиулсны улмаас Гэмтэл согог судлалын үндэсний төвд ирсэн ба элэг нь бяцарч, идээлсэн гэх оноштойгоор тус төвд хагалгаанд орсон.

Суралцагч Б нь хичээлд хоцорч ирсэн, тамхи татсан гэх шалтгаар багш нь толгой руу нь цохиход манай хүүхэд толгойгоо хамгаалсан, энэ үед доороос нь элэгдэхэд хүүхдийн маань элэг бяцарсан тул Цагдаагийн байгууллагад хандсан.

"Өнөөдөр" сонины
2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн нийтлэл

Тохиолдол 3

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалсан нэгэн судалгааны ажлын хүрээнд ...дүүргийн ерөнхий боловсролын ...-р сургуулийн захирал зохих газраас зөвшөөрөл өгөөгүй байхад дур мэдэн сургуулийн эмч болон дотоод хяналтын менежер нартаа зөвшөөрөл өгч "Монгол хүүхдийн биеийн хэмжээний стандарт боловсруулах төсөл"-ийн судалгааны багийг сургуульд нэвтрүүлэн, эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр 46 хүүхдийг нэг дор нүцгэлэн зургийг нь авч, үе тэнгийнхэн болон бусад хүүхдийн өмнө айж ичих, сандрах байдалд оруулсан байна.

Хүүхдүүдийн насанд хүрээгүй, биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн байна.

Комисст ирүүлсэн гомдлоос, 2018 он

Комисс нь 2016 онд Гүүд Нэйборс байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран "Хүүхдийн эрх ба хамгаалал" судалгааг Улаанбаатар хотын 7 дүүрэг, 8 аймгийн нийт 4,264 хүүхэд, 2,743 эцэг эх, хамтарсан багийн 152 гишүүнийг хамруулан хийхэд Монгол Улс дахь хүүхдийн эрхийн хамгийн нийтлэг зөрчил нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдал байв. Иймээс хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн хүүхэд, насанд хүрэгчид, үүрэг хүлээгчдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр бодлогын санал зөвлөмжийг гарган Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ тусгасан юм.³⁰ Гэвч хүүхдийн эрх, хамгааллын асуудал Монгол Улсын хувьд тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

³⁰ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл, 2017 он.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрөөс 2017 онд хүүхдийн эрх, үе тэнгийнхний дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт, сургууль болон гудамж талбай хийгээд цахим орчны аюулгүй байдал, тэдний ирээдүйн талаарх төсөөлөл зэрэг өөрт нь хамааралтай асуудлаар хүүхдүүд санал бодлоо илэрхийлэх боломжтой эсэхийг “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаагаар танджээ. Судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн ерөнхий боловсролын 12 сургууль, тусгай хэрэгцээт хүүхдүүд суралцдаг 2 сургуулийн 6, 8, 10 дугаар ангиудын 11–16 насны 1,236 суралцагч хамрагдсан байна. Судалгааны дүнгээр үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд хүүхдүүдийн багагүй хувь нь өртөж байна. Тухайлбал, 40.7 хувь нь бусад хүүхдийг зодуулж дээрэлхүүлж байхыг харсан гэсэн бол 84.2 хувь нь дарамтлуулж шоовдорлуулсан ч хэнд хандахаа мэддэггүй гэжээ. Түүнчлэн хүүхдүүдийн 15.4 хувь нь бусдад дээрэлхүүлж, доромжлуулах вий гэж санаа зовдог гэжээ.³¹

Өнөөгийн дэлхий нийтийн чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлалгүйгээр боловсролд тэгш хамруулахыг зорьдог билээ. Монгол Улсын төрийн бодлого ч эдгээр хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулах зарчим баримталдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд хүүхдээ ердийн сургуульд суралцуулах сонирхолтой байдаг хэдий ч сургуулийн удирдлага, багш нарын сөрөг хандлага, харилцаа болон үе тэнгийнхэн нь шоолох, нэр хоч өгөх, ялгаварлан гадуурхах зэргээс тухайн хүүхэд тусгай сургуульд суралцахыг сонгох аргагүй байдалд хүргэдэг байна.

³¹ Хүүхдийн Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр “Өсвөр насны хүүхдийн дуу хоолой” судалгааны тайлан, Монгол Улс, 2017 он.

Энэ нь ерөнхий боловсролын сургалт нь суралцагчдад ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх зэргээр хүний эрхийн зөрчил, хүчирхийллээс сэргийлэхэд чиглэсэн мэдлэг ойлголт өгч, зөв дадал хэвшил, хандлага төлөвшүүлж чадахгүй байгаагийн илрэл юм.

Тохиолдол 4

Манайх хүүхдээ хувийн сургуульд хоёр долоо хоног явуулж үзсэн. Тэр үед хүү маань 10 настай, 4 дүгээр ангид орсон юм. Сургуулийн захиргаа дэмжиж, ямар нэгэн асуудалгүй хүлээгээд авсан. Хүүхдийнхээ онцлог байдлыг бусад хүүхдэд тайлбарлаж хэлье гэтэл “Тэгэх шаардлагагүй” гэлээ.

Гурав хоногийн дараа багш нь “Ер нь та нар хүүхдээ тусгай сургуульд өгөх ёстой юм биш үү, Танай хүүхэд хэт хөдөлгөөнтэй тул дэргэдэх хүүхдэдээ саад болж байна” гэв. Бид “Та нар дахиад ажиглаад үзээч, гурав хоногт ийм дүгнэлт хийж болохгүй байх” гэж гуйв. Хүү маань ч хичээлдээ явна гэж уйлав.

Хүү хичээлдээ явж байсан ч хэд хоногоос багш нь “танай хүү хөдөлгөөнтэй учир хамгийн ард ганцааранг нь суулгасан” гэлээ. Мөн нэг өдөр ангийнхаа хүүхдүүдэд өгөөрэй гээд өгч явуулсан шоколадны цуглуулгыг тэр чигт нь буцаад авчирсан. Яагаад өгсөнгүй вэ гэтэл “Надаас хэн ч аваагүй” гэж хэлсэн юм.

Ангийн багш нь аутизмтай хүүхэдтэй ажиллах арга барил, туршлагагүй учраас манай хүүхдийг ялган хамгийн ард аваачиж суулгаж, хүүхдүүд ч багшийнхаа энэ хандлагаас сэдэл авч “энэ хүүхэд биднээс өөр, түүнтэй харилцаж болохгүй, шоколад авч болохгүй” гэсэн бодол төрсөн юм шиг байгаа юм. Тэгээд хүүгээ сэтгэл санааны дарамтад орж, ядрах юм байна гээд өөр сургуульд сургахаар сургуулиас нь гаргасан...

Монголын Аутизмын холбооны удирдах зөвлөлийн гишүүн
А-гийн арилцлагаас. 2017 оны 11 дүгээр сарын 14,
www.newspress.mn цахим хуудас
<https://newspress.mn/v1/p/news/945>

Иймээс ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг ерөнхий мэдлэгийн суурь хичээл болгон үзэх стандарт боловсруулж батлах, түүнчлэн хүний эрхийн сургагч багш, нийгмийн ажилтнуудыг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, суралцагч, багш нарт зориулсан хүний эрхийн сурах бичиг, сургалтын гарын авлага, арга зүйн заавар, зөвлөмж зэргийг боловсруулах шаардлагатай байна. Мөн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хүний эрхийн боловсрол олгох дасгал, аргачлалуудыг нэмж оруулан, баталсан төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэхэд чиглэсэн заавар зөвлөмж өгөх, сургалт, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэргээр арга зүйн болон төсвийн дэмжлэг үзүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Мөн ерөнхий боловсролын сургуулиудын суралцагчдын хувийн нууцыг хамгаалах, эрхийг хүндэтгэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр багш, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах, хариуцлагыг сайжруулах, нийгэм, олон нийтийн хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үр дүнтэй санал санаачилга, аян өрнүүлэх нь зүйтэй байна.

Дээд боловсрол

Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн хоёрдугаар үе шатанд дээд боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын бодлого, түүний дотор багшлах боловсон хүчинд зориулсан хүний эрхийн сургалтын цогц бодлого боловсруулж батлах талаар дараах асуудлыг төлөвлөж хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд:

- Сургагч багш нарыг бэлтгэх, давтан сургах;
- Багш бэлтгэх сургалтын бүх шатанд оюутнууд, багшлах боловсон хүчний эрх, үүрэг, оролцооны талаарх мэдээлэл өгөх;

- Хүний эрхийн боловсролын чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудыг магадлан итгэмжлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх;
- Боловсролын салбарын ажилтнуудын мэргэшил, мэргэжлийн өсөлт хөгжил, байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл зэрэгт хүний эрхийн боловсролыг нэг шалгуур болгох;
- Хүний эрхийн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг үнэлэх шалгуур, стандартыг боловсруулах зэрэг болно.

“Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-д тавигдах нийтлэг шаардлагад”³² бакалаврын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь 120 багц цагаас доошгүй байх бөгөөд нийт багцын 30 хувиас илүүгүй нь ерөнхий суурь, 25-аас илүүгүй хувь нь мэргэжлийн суурь, 45 хувиас доошгүй нь мэргэжлийн чиглэлээр байхаар төлөвлөж, оюутанд агуулгын сонголт хийх боломжтой байхаар заажээ. Ерөнхий суурь хичээлийн чиглэлүүдийн 8 агуулгаас 3 багц цагаар үзэх “Иргэний боловсрол”-ын агуулгад хүний үндсэн эрхийн асуудлыг судлахаар тусгажээ.

“Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт”³³-ыг шинэчлэн баталж, үүнд дөрвөн төрлийн хичээл багтаажээ.

³² Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 дүгээр тушаал.

³³ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/285 дугаар тушаал.

Хүснэгт 2. Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлүүд

Хичээлийн нэр	Эзэмших чадвар	Багц цаг
Монголын түүх, соёл, ёс заншил (иргэний боловсрол)	Монголын түүхийн үндсэн сурвалж бичгүүдийг (3-аас цөөнгүй) тоймлон дүгнэж, хөгжилд нөлөөлсөн дотоод, гадаад хүчин зүйлсийн талаар шүүмжит дүгнэлт хийх, түүнийгээ нотлон мэтгэлцэх чадвартай болно.	3
Монгол хэл бичиг, найруулга зүй (яриа бичгийн ур чадвар)	Эх хэлээрээ логик дэс дараалалтай, үндэслэлтэй, товч тодорхой, үнэн зөв амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадвартай болно. Эрдэм шинжилгээний бичвэр үйлдэх, түүнд дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ.	3
Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй (хүмүүнлэгийн ухаан)	Хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшинэ.	3
Сэтгэлгээний түүх, соёл (хүмүүнлэгийн ухаан)	Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, философийн үндсэн урсгалууд, тэдгээрийн оюун сэтгэлгээнд үзүүлэх нөлөөг танин мэдэж, цаашид оюунлаг дүгнэлт хийх философи сэтгэлгээний үндсийг эзэмшинэ.	3

Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлийн заавал судлах хичээлийн жагсаалтад гурван багц цагийн “Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй (хүмүүнлэгийн ухаан)” хичээлийг оруулсан бөгөөд энэхүү хичээлээр хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ

хөгжүүлэх, хувийн зохион байгуулалттай болох, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшүүлэхээр тооцжээ.

Дээрх хичээлийг ерөнхий суурь чиглэлийн заавал судлах хичээл болгосноор бакалаврын боловсрол эзэмшиж буй хүн бүр хүний эрх, эрх чөлөөний тухай ерөнхий ойлголт авах боломжтой байгаа нь дэвшилтэт алхам юм. Гэхдээ энэ нь хүний эрхийн тухай анхан шатны ойлголт өгөх төдий байгаа тул Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрт тодорхойлсоны дагуу хуульч, эрх зүйч, багш, нийгмийн ажилтан, эмч, эмнэлгийн ажилтан, цэргийн алба хаагч, сэтгүүлч зэрэг мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийн агуулгыг гүнзгийрүүлэн судлах боломжийг бүрдүүлж шинэчлэх нь зүйтэй байна.

Одоогоор хууль зүйн 11 их, дээд сургуульд “Хүний эрх” хичээл заавал судалж байгаа гэх хэдий ч бодит байдалд хүний эрх хичээлийг сонгон суралцах хэлбэрээр үзэж байна. Бусад их, дээд сургуулийн хувьд мэргэжлийн аль нэг хичээлийн цагт хүний эрхийг судалдаг гэх боловч тухайн ажил, мэргэжилтэй холбоотой хүний эрхийн асуудлыг дэлгэрүүлэн заадаг нь ховор байна. Түүнээс гадна хүний эрхийг зөвхөн хуульч, эрх зүйчид мэдвэл зохино гэсэн хандлага их, дээд сургуулийн удирдлага, багш, оюутнуудын дунд нийтлэг байна.³⁴

Иймээс их, дээд сургуулийн засаглал, менежмент, багш, оюутны амьдралтай холбоотой бодлого, дүрэм журмыг хүний эрхийн зарчимд нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, сургуулийн орчинд хүний эрхийн

³⁴ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, 2015 он.

соёлыг төлөвшүүлэх, хүний эрхийн зарчмуудыг багшлах боловсон хүчний урамшуулал, тушаал дэвших, сахилгын арга хэмжээний шалгуур болгох, түүнчлэн хүний эрхийн асуудлыг дээд боловсролын сургалтын байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагад тусгаж шийдвэрлэх нь зүйтэй юм.

Мөн дээд боловсролын сургалтын байгууллага нь дэргэдээ хүний эрхийн сургалт, судалгаа явуулах нөхцөлөөр хангах чиг үүрэг бүхий хүний эрхийн сургалт, мэдээллийн төв байгуулж хөгжүүлэхэд анхаарвал зохино. Түүнчлэн, төрөл бүрийн мэргэжлийн салбарт хүний эрхийн чиглэлээр магистр, докторын сургалтын хөтөлбөр, салбар хоорондын сургалтын хөтөлбөр бий болгох асуудлыг төрийн захиргааны төв байгууллага судалж шийдвэрлэх шаардлагатай байна.

Мэргэжлийн боловсрол

Мэргэжлийн боловсрол, сургалтаар иргэнд авьяас сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд нь тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх зорилготой.³⁵ Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь суралцагчид ажил, мэргэжлийн үндэсний ангиллаар тодорхойлсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ.³⁶

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь бүрэн дунд боловсрол сургалтын хөтөлбөрийн хүрээнд 9 дүгээр анги төгсөөд ирсэн суралцагчдад 2.5 жилийн ангид 10, 11

³⁵ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1

³⁶ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1

дүгээр ангийн сурах бичгийн агуулгыг ашиглан “Амьдрах ухаан”, “Эрүүл мэнд”, Нийгмийн тухай мэдлэг олгох хичээлд хүний эрхийн агуулгыг тусгаж заадаг байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын хүний эрхийн хичээлийн цагийн багтаамж, сэдвүүд бага тул зөвхөн онолын мэдлэг эзэмшүүлж байна. Мөн хүний эрхийн чиглэлээр зохион байгуулж буй хичээлээс гадуурх үйл ажиллагааг нэг хэвийн сургалт, сурталчилгааны хүрээнд явуулж байна. Цөөн тохиолдолд төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран тодорхой сэдвээр хүний эрхийн сургалтыг зохион байгуулдаг байна.³⁷

Иймээс Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид ихэвчлэн дараагийн шатны сургалтад хамрагдахгүйгээр шууд ажлын талбарт гардаг тул энэ төрлийн сургалтын суурь хичээлийн агуулгад “Хүний эрх” хичээлийг бие даасан хичээл болгон оруулах шаардлагатай байна.

Насан туршийн боловсрол

Насан туршийн боловсролын үндсэн 6 чиглэлээс³⁸ “Иргэний боловсрол” болон “Гэр бүлийн боловсрол” олгох сургалтын хөтөлбөрт хүний эрхийн талаарх агуулга тусгагдсан байна. Насан туршийн боловсролын төв, нэгжүүд хүний эрхийн сургалтуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг гэх хэдий ч энэ нь тогтмол, тасралтгүй хэрэгждэг сургалтын хөтөлбөр болоогүй байна. Түүнчлэн сургалт зохион байгуулах төсөв

³⁷ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2018 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 11/2733 дугаар албан бичиг.

³⁸ “Амьдрах ухааны боловсрол”, “Гэр бүлийн боловсрол”, “Иргэний боловсрол”, “Ёс суртахуун төлөвшлийн боловсрол”, “Гоо зүй мэдрэмжийн боловсрол”, “Шинжлэх ухааны боловсрол”.

хөрөнгө хангалттай биш тул сургалтыг тогтмол зохион байгуулж чадахгүй байна.³⁹

Цаашид насан туршийн боловсролын хөтөлбөр дэх хүний эрхийн сургалтыг явуулахад хүүхэд, залуусын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон гарын авлага, ном, тараах материал, зурагт хуудас, телевиз, радиогийн сурталчилгаа, нэвтрүүлэг, зайны сургалтууд нэн чухал байна. Түүнчлэн насан туршийн боловсролын төв, нэгжүүдийн багш нарыг хүний эрхийн асуудлаар мэргэшүүлэх, чадавхжуулах, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, орон тоог нь нэмэгдүүлэх асуудал тулгамдаж байна.

1.4 Албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын 3 дугаар зүйлийн 2-т “Хүний эрхийн боловсрол, сургалт нь сургуулийн өмнөх, бага, дунд болон академик эрх чөлөөг эдэлж болохуйц дээд боловсролын зэрэг нийгмийн бүх хэсэгт, аливаа түвшинд чиглэж, төрийн болон хувийн хэвшлээс үл хамааран, албан болон албан бус, сайн дурын шинжтэй боловсролын бүх хэлбэрийг хамаарна. Мөн мэргэжлийн сургалт, ялангуяа сургагч багш, төрийн албан хаагчдын сургалт, насанд хүрэгчдийн боловсрол, нийтийн боловсрол, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа багтана” гэжээ.

Мөн тунхаглалын 7 дугаар зүйлийн 1-д “Улсууд болон холбогдох төрийн эрх бүхий байгууллага нь оролцоо, татан оролцуулах, хариуцлагын мөн чанарыг шингээн боловсруулж, хэрэгжүүлсэн хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн

³⁹ Насан туршийн боловсролын үндэсний төвийн 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 79/18 дугаар албан бичиг

дэмжих, баталгаажуулах үндсэн үүрэг хүлээнэ”, 8 дугаар зүйлийн 1–д “Улсууд болон холбогдох төрийн эрх бүхий байгууллага нь төрийн албан хаагчид, шүүгч, хууль хяналтын байгууллагын албан хаагчид, цэргийн бие бүрэлдэхүүнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын эрүүгийн эрх зүйг зохистой байдлаар оруулсан хүний эрхийн тохирох сургалтыг баталгаажуулах ба багш, дасгалжуулагч, бусад сурган хүмүүжүүлэгчид болон төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бие бүрэлдэхүүнд зориулсан хүний эрхийн тохирох сургалтыг хөхиүлэн дэмжинэ. Үүний тулд Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг үндэсний болон орон нутгийн хэрэгцээ, тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлэхэд анхаарал тавих ёстой” хэмээн заасан байна.

Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн хоёрдугаар үе шатны төлөвлөгөө, хөтөлбөрийн 37–д хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах тусгай үүрэг хариуцлага хүлээгчид а) Төрийн албан хаагчид–ямд, харьяа байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, дипломат алба, нутгийн захиргааны, нутгийн өөрөө удирдах ёсны, санхүүгийн, эдийн засгийн байгууллагын алба хаагч, багш, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, нийгмийн ажилтан; б) Хууль сахиулах байгууллагын албан хаагч–хил хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хорих байгууллага, цагдаа, мөн журам сахиулах зорилгоор цэргийн алба хаагчид; в) Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн хамаарна.

Төрийн байгууллагууд хүний эрхийн албан бус боловсролын салбарт бие даан, идэвх зүтгэл гаргаж ажилласнаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал үр нөлөөтэй юм. Тодруулбал, төрийн албан хаагчид хүний эрхийн боловсрол олгох сургалтад хамрагдсанаар өөрийн тогтсон хандлагаа өөрчлөх, хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэхийн хамт ажил, үүргээ гүйцэтгэхдээ хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээн эдлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрт зааснаар төрөөс албан бус боловсролоор дамжуулж хүний эрхийн мэдлэг ойлголтыг салбар бүрт хөгжүүлэхийг уриалсан билээ. 2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн ээлжит дүгнэлт, хэлэлцүүлгээр Монгол Улсын Засгийн газарт өгсөн 164 зөвлөмжид хууль, шүүх, хүчний байгууллагуудад хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх, шаардлагатай төсөв батлах, хууль сахиулах сургуулийн хөтөлбөр болон ажлын байрны сургалтад хүний эрхэд суурилсан арга зүйг оруулах зэрэг хэд хэдэн зөвлөмж ирсэн байна.

Эдгээр зөвлөмжийг 2016–2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний Ерөнхий төлөвлөгөөг 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын 204 дүгээр тогтоолоор баталсан байна. Үүний дагуу хүний эрхийн боловсролыг дэмжих талаарх зөвлөмжийн хэрэгжилтийн тайланд “Цагдаагийн ажил-Хүний эрх” сэдэвт хичээлийг Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган, II дамжааны сонсогчдод 2 кредит буюу 56 цагийн хичээл заадаг болжээ. Мөн 2018 онд “Хорих байгууллагын аюулгүй байдал-Хууль сахиулах ажил” бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталж, заавал судлах сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг 96 цаг буюу 2 кредит/цаг байхаар тусган хэрэгжүүлжээ.

Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага⁴⁰ болохын хувьд

⁴⁰ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг.

хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Бүдүүвч 1. Комиссын хүний эрхийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагааны чиглэл

Хүний эрхийн сурталчилгаа



- Хүний эрхийн бүх төрлийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг иргэд, олон нийтэд сурталчлах
- Иргэд, иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлчидтэй хүний эрхийг сурталчлахад хамтран ажиллах

Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа



- Хүний эрхийн албан боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих
- Тодорхой зорилтот бүлэгт хүний эрхийн сургалт явуулах замаар албан бус боловсрол олгох
- Хүний эрхийн мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах

Хүний эрхийн нөлөөллийн үйл ажиллагаа



- Хүний эрхийн тодорхой асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах
- Олон улсын хүний эрхийн гэрээг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохыг дэмжих
- Комиссын бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд таниулах

Түүнчлэн Комисс нь “Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих”⁴¹ чиг үүргийн хүрээнд бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх ажлыг тогтмол хийдэг. Ялангуяа төрийн байгууллага, албан тушаалтнуудад чиглэсэн хүний эрхийн сургалтыг олон арга хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн билээ. Тухайлбал, 2018 онд 339 удаагийн 818.5 цагийн хүний эрхийн сургалт хийж, 15,424 иргэн, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, оюутан, эмч, эмнэлгийн ажилтан, сэтгүүлч, хуульч өмгөөлөгч, төрийн албан хаагч, хувийн хэвшлийн төлөөллийг хамрууллаа.

Комисс 2016 оноос эхлэн улсын хэмжээнд 600 орчим хүний эрхийн сургагч багш бэлтгээд байна. Үүнд 21 аймгийн төрийн байгууллагын 420, цагдаагийн байгууллагын 48, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 38, Зэвсэгт хүчний 45, “Тэгш нийгэм холбоо” төрийн бус байгууллагын 22, “Бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” төрийн бус байгууллагын 16 ажилтан, албан хаагч сургагч багшийн сургалтад хамрагдсан байна.

⁴¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг.

Комисс 2018 онд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын багц цаг олгох богино хугацааны сургалтын хөтөлбөрт хүний эрхийн 11 сэдвийг магадлан итгэмжлүүлэв. Завхан, Говь-Алтай, Өмнөговь аймгийн болон Улсын төв III эмнэлэг, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагын 245 эмч, эмнэлгийн ажилтанд хүний эрхийн сургалт хийсэн нь чухал үйл ажиллагаа болов.

Тохиолдол 5

Би эмнэлгийн салбарт 18 жил ажиллахдаа анх удаа хүний эрхийн сургалтад сууж байна. Их нарийн зүйл байдаг юм байна. Үнэхээр сайхан сургалт байна. Баярлалаа.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн ажилтан,
Сургалтын дараах үнэлгээний хуудаснаас

Комиссын номын сан нь монгол, англи, орос хэл дээр нийтлэгдсэн 3,000 гаруй хүний эрх, хууль эрх зүй бусад төрлийн ном товхимолтой. Эдгээрээс электрон каталогт 1,600 ном бүртгэгдсэн байна. Цахим номын санд 2018 онд 1,300 хэрэглэгч нэмэгдэж, нийт 2,500 хэрэглэгчтэй бөгөөд тэдэнд цахимаар болон эх хувиар нь 1,220 номоор үйлчилсэн байна. Комиссын номын сангийн ихэнх үйлчлүүлэгчид нь Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн оюутнууд байдаг бөгөөд бусад их, дээд сургуулийн оюутнууд ирж үйлчлүүлэх нь ховор байна.

Түүнчлэн олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр жилд дунджаар 32 нэр төрлийн 21,500 ширхэг ном товхимол, эвхмэл хуудас, зурагт хуудас зэргийг хэвлүүлж иргэд олон нийтэд түгээж байна.

Төрийн аливаа байгуулага хүний эрхийн боловсролыг өөрийн харьяалах байгууллага, түүний албан хаагчдад түгээх үүрэг хүлээдэг. Уг үүргээ биелүүлэхдээ бусад байгууллагуудтай хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байна. Тухайлбал:

- Улсын Их Хурал, харьяалах байнгын хороод
- Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага
- Хүний эрхийн Үндэсний Комисс
- Төрийн албан хаагчдыг бэлтгэдэг боловсролын байгууллага
- Төрийн бус байгууллага
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага гэх мэт.

Төрийн байгууллагууд тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үндэсний зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Жендэрийн Үндэсний хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын Ерөнхий Прокурорын газрын сургалт, судалгааны төв зэрэг нь 2018 онд 10,731 гаруй алба хаагчдад хүний эрхийн сургалтад хамруулжээ. Нутгийн захиргааны байгууллагуудаас Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын Тамгын газар иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн боловсрол олгох сургалтыг дүүргийнхээ 24 хорооны нийт 263 иргэнийг хамруулан 2018 онд зохион байгуулжээ.

Ерөнхийдөө төрийн захиргааны төв, аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон түүний харьяа нийт 4,293 байгууллагад⁴² хүний эрхийн боловсрол олгох, сургалт сурталчилгааны ажил хангалтгүй байна.⁴³ Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлагууд, нутгийн захиргааны байгууллага болон хууль сахиулах байгууллагын түвшинд хүний эрхийн боловсролын чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааг тоймлон авч үзвэл төрөөс хүний эрхийн боловсролын талаар баримтлах нэгдмэл бодлогогүй байна. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд зарцуулж буй төсөв харилцан адилгүй, гол төлөв зохион байгуулагч талын зардлаар, эсвэл олон улсын байгууллагын төслөөр санхүүжүүлж, маш бага хувийг төсвөөс гаргадаг буюу ихэнх тохиолдолд огт төсөвлөдөггүй байна.

Комисст иргэдээс ирүүлж буй гомдол, мэдээллийн багагүй хувь нь төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой байна. Энэ нь төрийн үйлчилгээний шат дамжлага, хүнд суртал, чирэгдэл ихтэй, мэдээллээр хангадаггүй, хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэдэггүй зэргээр иргэдийг чирэгдүүлж, цаг хугацаа, санхүүгийн талаас хохирол учруулж, хууль тогтоомжоор баталгаажуулсан эрхээ эдлэхэд нь саад тотгор учруулж байгаатай холбоотой байна.

⁴² Төрийн албаны зөвлөлөөс гаргасан Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний 2018 оны статистик мэдээ

⁴³ Албан бус тогтолцоогоор хүний эрхийн боловсрол олгож буй төр болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас ирсэн мэдээлэл, 2018 он.

Тохиолдол 6

...яамны архив, бичиг хэргийн ажилтан “Чи энэ тайлангаар яах гэж байгаа юм. Юунд ашиглах гэж байгаа юм. Хувь хүнд ийм мэдээлэл гаргаж өгөхгүй, Төрийн нарийн бичгийн даргаас зөвшөөрөл ав” гээд өргөдлийг маань хүлээж авсангүй, хүнд суртал гаргалаа.

Иймээс зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр танайд хандаж байна...

Комисст ирүүлсэн гомдлоос, 2018 он.

Тохиолдол 7

Төрийн байгууллагуудын албан хаагчдын хүнд суртал хэзээ арилах юм бэ? Заримдаа ч үнэндээ ойлгохгүй, тэвчээр хүрэхгүй үе байх юм. Өнөөдөр гэхэд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс орж эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ авах гэж эгзээтэй л байцаагчтай хэрэлдэж, уралцсангүй. Арай л дэндүү байна.

Төрийн гэх нэрээр өөрсдийгөө дөвийлгөдөг ёс зүйгүй, харилцааны соёлгүй муухай ааш араншинтай хүмүүс олон байна. Хүүхдээ тэврээд ядарч зүдэрч явахад “Баянзүрхийн даатгалын хэлтэс орж баталгаажуул” гэх мэтээр илүү явдал хийлгэж байна. Төрийн албан хаагчдын хүнд суртал, ажлаа мэдэхгүй туршлагагүй нөхдөөс болж бичиг баримт бүрдүүлэлтийг хангах гэж хэд дахин гүйж байлаа. Харилцаа, хандлага нь биш ээ.

“Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын гишүүд Иргэн С-тэй хийсэн ярилцлагаас

Удирдлагын академи “Төрийн захиргааны менежмент”, “Төрийн удирдлага”-аар мэргэшүүлэх дипломын сургалтын хөтөлбөрт “Хүний эрх ба захиргаа” хичээл, “Бизнесийн удирдлага”-аар мэргэшүүлэх дипломын сургалтын хөтөлбөрт “Хүний эрх ба бизнес” хичээл тус тус 1 кредит буюу 20 цагаар тусгагдсан байна.

2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа Төрийн албаны тухай хуульд зааснаар Засгийн газрын бүрэн эрхэд төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх⁴⁴ ёстой ч одоогоор хөтөлбөр гараагүй байна. Иймээс тус хөтөлбөрт төрийн албан хаагчдад чиглэсэн хүний эрхийн боловсролын талаар тусгайлан анхаарч, хүний эрхийн сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарах нь зүйтэй юм.

Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, санаачилгууд

Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын⁴⁵ үүрэг, оролцоо чухал

⁴⁴ Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2.2 дахь хэсэг.

⁴⁵ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээр 2018 онд 18,000 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна. Гадаадын иргэн, харьяатын газраас авсан мэдээллээр 2017 оны байдлаар Монгол Улсад гадаадын төрийн бус байгууллагын болон олон улсын байгууллагын нийт 90 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны Статистикийн ерөнхий хорооны мэдээлэлд дурдсанаар албан ёсоор бүртгэлтэй байгаа 17,685 төрийн бус байгууллагын 48.5 хувь буюу 8,578 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл, улсын бүртгэлд бүртгүүлсэн төрийн бус байгууллагын дийлэнх хувь нь идэвхгүй буюу 5,437 огт үйл ажиллагаа эрхлээгүй, 3,340 үйл ажиллагаагаа түр зогсоосон, 267 үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон, 63 нь хаяг тодорхойгүй болон бусад шалтгааны улмаас ямар нэгэн мэдээлэл алга байна.

хэвээр байна. Тухайлбал, Комисст ирүүлсэн мэдээллээр 2018 онд Монголын Эмнести Интернэшнл, Монголын Улаан загалмай нийгэмлэг, Хүний эрх, хөгжил төв, Глоб Интернэшнл төв, “Бүх нийтийн боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвсэл, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын эмэгтэйчүүдийн сан, Залуус эрүүл мэндийн төв, Тэгш нийгэм холбоо, Монголын хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, иргэний боловсролын төв, Монфемнет үндэсний сүлжээ, Нээлттэй нийгэм форум, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Хүүхдийг ивээх сан, Гүүд Нейборс зэрэг байгууллага хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулж, хүний эрхийн сургалтад нийт 42,629 хүн хамруулжээ.

Албан боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, техникийн туслалцаа үзүүлж ирсэн Монголын Эмнести Интернэшнл, Нээлттэй нийгэм форум, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Иргэний боловсрол төв, Сонгогчдын боловсрол төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монфемнет үндэсний сүлжээ, “Бүх нийтийн боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл зэрэг төрийн бус байгууллагууд хүний эрхийн сургагч багш нарыг сургах, сургалтын материал, гарын авлагаар хангах талаар олон тооны төсөл, хөтөлбөрийг урт хугацаанд хэрэгжүүлж, багагүй туршлага хуримтлуулжээ. Гэвч иргэний нийгмийн байгууллагуудын сургалт сурталчилгааны үр нөлөөг боловсролын тогтолцоонд нэвтрүүлээгүй, тогтвортой хэрэгжүүлээгүй, үндэсний зөвшилцөлд хүрдэггүй, магадлан итгэмжилж, дэмжлэг үзүүлдэггүйгээс өнөөг хүртэл хүний эрхийн боловсрол албан боловсролын тогтолцооны нэг хэсэг болж чадаагүй байна.

Тохиолдол 8

Бид орон нутагт юу дутагдаж байгааг судлаад нийгэмд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах төсөл бичиж, санхүүжүүлэгч донорыг өөрсдөө олж хэрэгжүүлдэг. Төр, орон нутгийн зүгээс дэмжлэг байдаггүй.

Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын үндэсний сүлжээний Завхан аймаг дахь Sedaw-watch төрийн бус байгууллагын тэргүүний ярилцлагаас

Төрөөс хүний эрхийн боловсрол олгох, сургалт зохион байгуулах санхүүжилт, чанарын хяналт үнэлгээ болон магадлан итгэмжлэлийг шийдвэрлэж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж, урамшуулах хэрэгтэй байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн хүний эрхийн боловсрол

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын хэвлэн нийтлэх үйл ажиллагаа нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чухал үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтэд хүний эрхийн мэдлэг ойлголт түгээх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх, нийгэмд эерэг өөрчлөлт бий болгох онцгой үүрэг бүхий тогтолцоо юм.

Тиймээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал, Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний гуравдугаар үе шатанд хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчдэд хүний эрхийн сургалт явуулахаар тусгажээ. Үүнийг хэрэгжүүлэхдээ хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчдийн хүний эрхийг хөхиүлэн дэмжих,

хамгаалах үүргийг онцлон тэмдэглэх, тэдэнд зориулсан үр дүнтэй сургалтын хөтөлбөр удирдамжаар хангах, сургалтын тогтвортой стратеги боловсруулан хэрэгжүүлэх, хүний эрхийн сургалт явуулахад дэмжлэг үзүүлэхийг чиглэл болгожээ.

Одоогийн байдлаар Монгол Улсад 434 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор 88 сонин, 71 сэтгүүл, 127 телевиз, 48 радио, 100 мэдээллийн цахим хуудас нийт 4,462 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Нийт хэвлэл мэдээллийн ажилтнуудын 95-аас дээш хувь нь дээд боловсролтой, үлдсэн хэсэг нь дунд боловсрол эзэмшжээ. Сэтгүүлч, сурвалжлагчаар ажиллаж буй хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны 49 хувь нь сэтгүүлч мэргэжилтэй, бусад нь өөр мэргэжилтэй байна.⁴⁶

Монгол Улсад сэтгүүлч, сэтгүүл зүйн салбарын ажилтан бэлтгэдэг 10 орчим их, дээд сургууль байгаа хэдий ч эдгээрт хүний эрхийн хичээлийг огт заадаггүй тул энэ мэргэжлээр төгсөгчид хүний эрхийн анхан шатны мэдлэг, ойлголтгүй төгсдөгөөс гадна ажлын байрны болон бусад мэргэшүүлэх сургалтад хамрагдах боломж, нөхцөл хомс байна.

Комиссоос 2019 онд Увс, Баянхонгор, Сүхбаатар аймаг болон нийслэлийн сэтгүүлчидтэй хийсэн бүлгийн ярилцлагын үеэр “Хүний эрхийн сургалтад хамрагдаж байсан уу?”, “Ийм төрлийн сургалтад суух боломжтой” эсэхийг асуухад тэдний 60 хувь нь “өмнө нь хүний эрхийн тусгайлсан сургалтад хамрагдаж байгаагүй”, 30 хувь нь “зөвхөн нэг удаа суусан”, үлдсэн хувь нь “Өөр төрлийн сургалтын үеэр хүний эрхийн тухай сонсч байсан” гэх мэтээр хариулж байлаа. Тандалт судалгаанд оролцогчдын олонх нь “Хүний эрхийн сургалт

⁴⁶ Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн 17 дугаар их хуралд тус эвлэлийн ерөнхийлөгчийн тавьсан илтгэлээс, 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдөр.

чухал хэрэгцээтэй. Бидэнд хүний эрхийн мэдлэг, ойлголт олж авах хэрэгцээ шаардлага тулгардаг”, “Ядаж л өөрийн эрхээ хамгаалж чаддаг болно” гэжээ.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн редакци нь ажлын хэрэгцээнд тулгуурлан хүний эрхийн чиглэлээр сургалт явуулах, боловсон хүчнээ сургах хэрэгцээ шаардлагатайг тодорхойлдог ч хүн хүчний нөөц боломж, ажлын ачааллаас шалтгаалан нэгээс дээш хоногоор ажилтнаа сургах боломж төдийлөн байдаггүй ажээ. Тухайлбал, төвийн, орон нутгийн телевизүүд цөөн тооны сурвалжлагчтай тул 2–3 хоног үргэлжилсэн сургалтад 2 хүнийг ээлжлэн суулгах, эсвэл зөвхөн нэг өдөр нь л оролцуулах боломжтой гэсэн байна.⁴⁷

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын эвлэл, холбоод сүүлийн үед сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх хэрэгцээ зайлшгүй болохыг хүлээн зөвшөөрч, тодорхой санал, санаачилга гаргаж эхэлжээ. Тухайлбал, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл 2018 оны 5 дугаар сараас “Мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, тус хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, гадаад харилцаа, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, эрэн сурвалжлах, уул уурхай, анагаах, хөдөө аж ахуй зэрэг 8 чиглэлээр сэтгүүлчийг мэргэшүүлэх, хөтөлбөрийн хүрээнд яам бүрт тухайн салбарын мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх клуб байгуулахаар⁴⁸ төлөвлөжээ. Мөн Комисс 2012 оны 4 дүгээр сараас эхлэн “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубыг байгуулж, энэ хугацаанд давхардсан тоогоор 19

⁴⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2005–2018 онуудад зохион байгуулсан хүний эрхийн вакумжуулсан сургалтуудын илтгэх хуудас, тайлан мэдээ

⁴⁸ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдөр болсон “Мэргэшсэн сэтгүүлч бэлтгэх үндэсний хөтөлбөр”-ийн нээлтийн ажиллагаанд Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч Х.Мандахбаярын хэлсэн үг.

байгууллагын 26 сэтгүүлчид хүний эрхийн мэдлэг олгох сургалтыг сар тутам явуулж, мэргэшүүлж байна.

Их, дээд сургууль төгссөн сэтгүүлчдийг давтан сургалтад хамруулж, мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдаж байгаа нь өдөр тутмын мэдээ мэдээлэл, хэвлэл мэдээллийн бүтээлээс илэрхий харагдаж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг, ойлголт хангалтгүй байгаагаас эрхээ хамгаалах, шаардах чадамж сул, хөдөлмөрлөх эрх болон бусад эрхээ алхам тутам зөрчүүлэхэд хүрдэг төдийгүй хэвлэн нийтлэх, нэвтрүүлэх явцдаа хүний эрх, эрх чөлөөнд халдах, зөрчил гаргах тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, “Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллагаас хийсэн судалгаагаар 1999–2017 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан, гүтгэсэн, доромжилсон гэх асуудлаар шүүхээр шийдвэрлэсэн нийт иргэний болон эрүүгийн 848 хэргийн 426 нь буюу 50.2 хувь нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох хэрэг байна.⁴⁹ Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 49 удаагийн тохиолдлоор 98 сая төгрөгийн торгуулийг сэтгүүлчдэд оногдуулсан байна.⁵⁰

Түүнчлэн Комисст сэтгүүлч хүний эрх зөрчсөн талаар гомдол цөөнгүй ирсэн байна.

⁴⁹ Глоб Интернэшнл төв төрийн бус байгууллага, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан-2017 он” судалгаа (2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл)

⁵⁰ Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Глоб Интернэшнл төв төрийн бус байгууллага, Парламентын сэтгүүлчид зэрэг 15 байгууллагын хамтарсан мэдэгдэл, сэтгүүлчдийн төлөөлөл хэвлэлийн бага хурлын мэдээ, 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдөр <http://bataar.mn/n/69455>

Тохиолдол 9

Манай аймагт ахлах ангийн нэг хүүхэд амиа хорлохыг завдаж байшин дээрээс үсрэх гэж байна гэсэн мэдээллийн дагуу бид очиж сурвалжилсан юм. Тухайн үед олны анхаарал татсан сүрхий сурвалжлага бэлтгэлээ гээд их додигор байлаа. Гэтэл удалгүй хэрэг бишидсэн. Учир нь тэр хүүхэд дахиад амиа хорлохыг завдаж, сүүлдээ гэр бүлээрээ тэр нутгаас нүүж шилжихээс өөр аргагүй байдалд хүрсэн тухайгаа бидэнд мэдэгдсэнд их балмагдсан. Тэр үед хүний эрхийн тухай огт ойлголт, мэдлэг байхгүй, сургалт энэ тэрт суусан ч юмгүй байв. Дөнгөж төгсч ирсэн шинэ сэтгүүлч байсан болохоор хаана, ямар сонирхолтой мэдээ байна, түүнийг л гаргадаг байлаа. Бидний гол алдаа нь тэр охины овог нэр, сургууль, анги, гэрийн хаягийг мэдээлсэнд байсан юм. Дахиж тийм алдаа гаргаагүй ээ. Хүний эрхийн сургалтад дуртайяа оролцох болно.

Орон нутгийн сэтгүүлчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагын үеэр. 2019 оны 3 дугаар сар

Тохиолдол 10

Нэгэн өглөөний уулзалтад хохирол нөхөн төлүүлэх эрхийн сэдвээр санал солилцохоор очихдоо иргэн миний бие өөрт тохиолдсон асуудлаар ...телевизийн сэтгүүлчид ярилцлага өгснийг тус телевиз мэдээллийн хөтөлбөрөөрөө 2018 оны ...сарын ...-ны өдөр олон нийтэд цацаж нэр төрд минь халдсан бүдүүлэг алдаа гаргаж, эрхийг минь зөрчсөнд гомдолтой байна.

Миний хүү хүчингийн гэмт хэргийн золиос болж, шүүхээс гэм буруутай этгээдээс нөхөн төлбөр олгуулахаар шийдвэрлэсэн ч өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байгааг шийдвэр гаргагчдын сонорт хүргэх зорилгоор ярилцлагыг өгсөн юм. Гэтэл хүүд тохиолдсон явдлыг дэлгэрэнгүй тоочиж, иргэн

миний зүс царай, овог нэрийг ил гаргаж олонд зарласан нь манай гэр бүлд маш их хохирол авчирлаа...

Комисст ирүүлсэн гомдлоос, 2018 он

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Фридрих Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр сэтгүүлчдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, үйлдвэрчний эвлэл байгуулах санаачилгын хүрээнд 2018–2019 онд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд хамтран үйлдвэрчний эвлэл байгуулах санаачлагчдын бүлгийг байгуулжээ. Тус бүлэг нь 2019 он гарсаар үйлдвэрчний эвлэлийн дөрвөн анхан шатны хороо байгуулаад байна.⁵¹

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарал хандуулах нь зүйтэй. Олон нийтийг соён гэгээрүүлэх, хүний эрхийн соёл, боловсролыг түгээхэд чухал үүрэгтэй тус байгууллагын төсөв санхүүжилт, нэвтрүүлгийн бодлогод хүний эрхийн боловсролыг түгээх аяныг нэн тэргүүнд тусгах хэрэгцээ шаардлага тулгараад байна. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз нь 2018 оноос эхлэн “Дэлхийн түүхүүд” хүний эрхийн цуврал баримтат киног монгол хэлнээ орчуулан нэвтрүүлж эхэлсэн нь сайшаалтай ч “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийг эс тооцвол хүний эрхийн мэдлэг, ойлголт олгохуйц тусгайлсан хөтөлбөр, нэвтрүүлгийн бодлогогүй байна. Олон нийтийн мэдээллийн сувгаар дамжуулан хүний эрхийн сургалт, мэдээллийн цогц аяныг зохион байгуулах нь нэн чухал тул цаашид энэ чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн

⁵¹ 2019 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Фридрих Эбертийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газраас ирүүлсэн мэдээллээс.

радио, телевиз хэвлэл мэдээллийн салбарт манлайлж ажиллах шаардлагатай юм.

Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн гуравдугаар үе шатны чиглэлийн хүрээнд Засгийн газар нь сэтгүүлчдийг хамгаалах үүргийг нэн тэргүүнд хүлээж, тэдний хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх стратегийг баримтлан ажиллавал зохино. Үүний тулд юуны өмнө хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа, арга хэлбэрт үнэлгээ, дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагаа тодорхойлох нь зүйтэй байна. Түүнчлэн мэргэжлийн сэтгүүлч, ажилтнуудад хүний эрхийн мэдлэг, ойлголт олгох, энэ чиглэлээр мэргэшүүлэн бэлтгэх, чадавхжуулах, зэрэг дэмжлэг үзүүлэх боломжит арга хэлбэрүүдийг хэрэгжүүлж эхлэх, санал санаачилга шаардлагатай байна.

Дүгнэлт

Монгол Улсын боловсролын салбарын бодлого төлөвлөлт, эрх зүйн баримт бичгүүдэд хүний эрхийн боловсролын тогтолцоог бэхжүүлээгүй, үнэт зүйлс, тэргүүлэх чиглэлийг тодорхой болгоогүйн улмаас хүний эрхэм чанарыг хүндэтгэдэг, хүний эрхийн хэм хэмжээ, зарчмуудыг хүлээн зөвшөөрч, амьдралдаа мөрдлөг болгон хэвшүүлдэг хүний эрхийн соёл, хандлагатай залуус, хойч үеийг төлөвшүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна.

Олон нийт хүний эрхийн боловсролын ач холбогдлыг ойлгож буй хэдий ч нийгмийн харилцаанд оролцохдоо эрх, эрх чөлөөгөө аливаа эрсдэл, зөрчлөөс хэрхэн хамгаалах талаар цогц ойлголт, мэдлэг, чадавх хангалтгүй байна. Түүнчлэн, албан ба албан бус боловсролын салбарт хүний эрхийн боловсролын чиглэлээр дорвитой ахиц гарахгүй байна. Үүний учир шалтгаан нь хүний эрхийн боловсролын албан

ба албан бус сургалтын үйл ажиллагаа системчлэгдээгүй, үр дүн муутай, мөн хүний эрхийн боловсролын чиглэлээр төрийн нэгдсэн бодлогогүй явж ирсэнтэй холбоотой байна.


Монгол Улсад Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмж, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд хүний эрхийн боловсрол олгох, иргэдийн хүний эрхийг дээдлэх соёл, ухамсрыг бэхжүүлэх чиглэлээр олон тооны төсөл хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагын түвшинд хэрэгжүүлж багагүй туршлага хуримтлуулсан ч энэ нь албан боловсролын тогтолцоонд суурилсан урт хугацааны тогтвортой бодлого, төлөвлөлт болж чадахгүй байна. Нөгөө талаас холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн оролцоо, үүсгэл санаачилга дутагдалтай байна.

Одоогийн боловсрол, сургалтын байгууллагууд, эдгээрт ажиллаж буй багш, мэргэжилтнүүд, боловсон хүчний чадавхд түшиглэн албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх нь өнөөдрийн нийгмийн хэрэгцээ шаардлага болоод байна. Ингэхдээ бүх шатны сургууль боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг хуульчлан батлах, түүнчлэн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд бусад байгууллагуудын албан ёсны дэмжлэг, оролцоог чухалчлан үзвэл зохино.

Олон улсын түвшинд хүний эрхийн боловсролын тогтолцооны хэд хэдэн загвар бий болж төлөвшжээ. Эдгээр загварыг харьцуулж, шинжлэн үзэхэд Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын өнөөгийн байдал нь “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын манлайлах үүрэг бүхий загвар (Загвар 1)–тай


нийцэхүйц байна. Цаашид энэ загварыг илүү сайжруулж, “Хүний эрхийн боловсролын бүрэн тогтолцоот загвар” (Загвар 2)-ыг Монгол Улсад нэвтрүүлэн хэрэгжүүлэх талаар бүх оролцогч талууд хүчин чармайлтаа нэгтгэх нь чухал юм.

Бүдүүвч 2. Хүний эрхийн боловсролын үндэсний тогтолцооны загварууд⁵²



(Загвар 1) Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын манлайлах үүрэг бүхий загвар

⁵² https://www.hurights.or.jp/archives/human_rights_education_in_asian_schools/section2/2001/03/broader-support-for-human-rights-education-in-schools.html



(Загвар 2) Хүний эрхийн боловсролын бүрэн тогтолцоот загвар

Хүний эрхийн боловсролын бүрэн тогтолцоот загвар нь хүний эрхийн боловсрол, сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг холбогдох талуудын хамтын ажиллагаа, эргэх холбоонд тулгуурлан авч үздэг тул оролцоо, дэмжлэг болон нөөцийн зохистой хуваарилалт, харилцан уялдаа холбоог хангадаг давуу талтай юм. Энэ нь боловсрол, сургалтын байгууллагуудад голлох ачааллыг өгдөггүй бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад оролцогч талуудын чиг үүрэг, дэмжлэгийн хоёр талт чиглэлийг бий болгодог тул тогтвортой, динамик загвар гэж үздэг байна.

Цаашид хүний эрхийн боловсрол, сургалтын үндэсний тогтолцоог хэрэгжүүлэх үндсэн субъектуудын хүрээг төрийн холбогдох байгууллага, яамд, боловсролын төрөлжсөн байгууллага, хүний эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын ба төрийн бус байгууллагууд, хүний эрхийн судалгаа, сургалт, мэргэжлийн байгууллагууд, хүний эрхийг хамгаалагчид, зүтгэлтнүүдийн үүсгэл санаачилгад тулгуурлан өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй байна.

Иймд хүний эрхийн боловсролын талаарх дэлхий дахины чиг хандлага, олон ургалч байр суурийг харьцуулан Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагад нийцсэн хүний эрхийн боловсролын цогц бодлого, үзэл баримтлалыг тал бүрийн оролцоотой тодорхойлж, түүнтэй уялдсан бодлого, хөтөлбөр, стандартыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт үнэлгээг тогтмол хийх зэргээр тогтолцооны хувьд хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

II

БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН АСУУДАЛ

“...Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар
зүйлийн 6 дахь заалт)

*“Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон
сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн
зөвшөөрнө.”*

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын
12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

*“Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн
бэрхшээлийн улмаас алагчилалгүйгээр эрүүл мэндийн дээд
түвшингийн стандартад хүрэх эрхийг хүлээн зөвшөөрнө.”*

(Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын
25 дугаар зүйл)

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах төрийн үүрэг

Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг нь хүний нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо, түүний үйл ажиллагаа хэвийн байх төдийгүй, хүн бие махбод, оюун санаа, нийгмийн талаар бүрэн төгс, эрүүл саруул байх тухай ойлголт юм. Хүн бүр сэтгэл ханамжтай, аюулгүй бэлгийн амьдралтай, нөхөн үржих чадвартай байх, хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэхээ чөлөөтэй шийдэхэд тус болох гэр бүл төлөвлөлтийн аюулгүй, үр дүнтэй арга хэрэгсэл, мэдээллээр хангагдах, жирэмсний болон амаржих хугацаанд осол, аюулгүй байж, эрүүл хүүхэд төрүүлэх боломж бүрдүүлсэн эрүүл мэндийн цогц үйлчилгээг хүртэх боломжоор хангагдсан байх ёстой.⁵³

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн тайланд⁵⁴ хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүд өөрийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар бие даасан шийдвэр гаргаж чаддаггүй бөгөөд бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөмтгий, нэн ялангуяа тэдний дунд хүчээр үр хөндүүлэх, жирэмслэлтээ таслуулах, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хүчээр хэрэглэх явдал түгээмэл байгааг дурджээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүд хэрэгцээндээ нийцсэн эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө авч чадахгүй байна.

Эдгээр саад бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийн талаарх олон нийтийн буруу ойлголт, хандлага, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй.⁵⁵

⁵³ Хүн ам, хөгжлийн олон улсын бага хурлын мөрийн хөтөлбөрийн бүлэг VII, 7.2

⁵⁴ Young Persons with Disabilities: Global Study on Ending Gender-based Violence and Realising Sexual and Reproductive Health and Rights, UNFPA, 2018.

⁵⁵ Ibid n 1, p 7. OHCHR: Gender stereotyping as a human rights violation", October 2013.

Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийг бэлгийн харилцаанд орох шаардлагагүй, хүүхэд төрүүлэх, гэрлэх боломжгүй, чадваргүй гэх үзэл⁵⁶ тэдний мэдээлэл авах, хүчирхийллээс ангид байх, найдвартай, аюулгүй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг нь хязгаарладаг ажээ. Түүнчлэн бэлгийн хүчирхийлэлд өртөх, хүсээгүй жирэмслэх, бэлгийн замаар дамжих халдвар авах эрсдлийг нэмэгдүүлдэг байна.⁵⁷ Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийг үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл 3 дахин өндөр байна.⁵⁸

Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө зэрэг нөхөн үржихүйн үндсэн тусламж нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд бусад эмэгтэйчүүдийн нэгэн адил чухал бөгөөд тэдний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлэх орчин, зохион байгуулалт Монгол Улсын хэмжээнд хүртээмжгүй, хангалтгүй байна.

2018 оны байдлаар Монгол Улсад 106,691⁵⁹ хөгжлийн бэрхшээлтэй хүн (нийт хүн амын 3.3 хувь) байгаагийн 43.1 хувь буюу 46,030 нь эмэгтэйчүүд байна.⁶⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 19.7 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг бол улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн

⁵⁶ Spratt, J (2013), A Deeper Silence: The unheard experiences of women with disabilities and their sexual and reproductive health experiences – Kiribati, the Solomon Islands, and Tonga, UNFPA Pacific Sub-Regional Office, Suva, Fiji, p 10.

⁵⁷ UNFPA (2018), Young Persons with Disabilities: Global Study on Ending Gender Based Violence and Realising Sexual and Reproductive Health and Rights, Summary Brief, p 6.

⁵⁸ UNFPA Global Study on Ending Gender-based Violence and Realising Sexual and Reproductive Health and Rights, 2018.

⁵⁹ Үндэсний Статистикийн Хороо, www.1212.mn, 2018 он.

⁶⁰ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах, 2017 он, 7 дахь тал.

1.9 хувь нь буюу 447 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд тэдний 205 нь эмэгтэйчүүд байна.⁶¹

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 2014 онд IRIM судалгааны байгууллагаас хийсэн “Монгол Улс дахь жендэрийн тэгш байдлын талаарх үзэл хандлага”⁶² баримт бичгийн судалгаа, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын санхүүжилтээр 2013–2014 онд “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв” төрийн бус байгууллагаас хийсэн судалгаагаар⁶³ Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн хэрэгжилтэд орчин болон мэдээллийн хүртээмжгүй байдал ихээр нөлөөлдөг, улмаар энэ нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалт, далд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд хүргэж байна гэжээ.

Хүний аливаа эрх нь хоорондоо харилцан хамааралтай тул бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь бусад эрхтэй, ялангуяа нийгмийн амьдралд оролцох, хөдөлмөрлөх эрхтэй харилцан уялдаатай. Эдгээрийг олон улсын баримт бичигт баталгаажуулсан ч эрхээ эдлэх нөхцөл, баталгааг төр бүрдүүлэх ёстой юм.⁶⁴

⁶¹ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2018 оны эхний 8 сарын байдлаар, Үндэсний Статистикийн Хороо.

⁶² Швейцарын Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэн Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, 2014, хуудас 47.

⁶³ “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх” судалгаа, 2014 он. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв.

⁶⁴ “Хүний эрх эмхэтгэл” 2014 он, “УБ хот, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс.

Египетийн Кайр хотноо 1994 онд хуралдсан “Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурал”-аас баталсан “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”⁶⁵-т нөхөн үржихүйн эрхийг тодорхойлохдоо хосууд болон аливаа хувь хүн хүүхэдтэй болох эсэх, мөн хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэхээ чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдэх; энэ шийдвэрээ гаргахад хэрэгтэй мэдээлэл авахаас гадна бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн дээд түвшинд эрүүл байх; аливаа хүн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хамгийн чанартай, стандартын тусламж, үйлчилгээ авах; ялгаварлан гадуурхалт, албадлага, хүчирхийллээс ангид байж, нөхөн үржихүйн асуудлаар өөрсдөө шийдвэр гаргах эрхтэй байна гэжээ.⁶⁶

Түүнчлэн Олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбооноос бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтэй салшгүй холбоотой хүний бусад эрхийг дараах байдлаар жагсаажээ.⁶⁷ Үүнд: амьд явах; бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралаа өөрөө шийдэх; ялгаварлан гадуурхалтаас ангид байх; халдашгүй байх; үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх; мэдээллээр хангагдах; баталгаатай, хүртээмжтэйгээр бэлгийн боловсрол олж авах; гэр бүлээ төлөвлөх, гэрлэх эсэхээ өөрөө шийдэх; эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ авах; эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон эрхийг багтаажээ.

⁶⁵ Египетийн Кайр хотноо 1994 оны 9 дүгээр сарын 5–13-ны өдрүүдэд хуралдсан “Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурал”-аар баталсан “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”.

⁶⁶ Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурлын “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн Нөхөн үржихүйн эрх ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, хэсэг 7.3., Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан орчуулга.

⁶⁷ IPPF Charter guidelines on sexual and reproductive rights.

Эдгээр эрхийг Монгол Улсын нэгдэн орсон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц⁶⁸, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай⁶⁹, Гэр бүлийн тухай⁷⁰, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай⁷¹ зэрэг хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030⁷², Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого⁷³, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр⁷⁴, Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр⁷⁵, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр⁷⁶, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр⁷⁷–т тус тус баталгаажуулжээ. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээний идэвхтэй оролцогч болохыг баталгаажуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн

⁶⁸ Монгол Улс 2009 оны 5 дугаар сарын 13–нд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдэн орж, 2009 оны 12 дугаар сарын 19–ний өдөр соёрхон баталсан.

⁶⁹ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2011 он.

⁷⁰ Гэр бүлийн тухай хууль 1999 он.

⁷¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он.

⁷² Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан.

⁷³ Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 16–ны өдрийн 261 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.

⁷⁴ Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24–ний өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр.

⁷⁵ Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7–ны өдрийн 78 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр.

⁷⁶ Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29–ний өдрийн 321 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр.

⁷⁷ Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26–ны өдрийн 129 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр.

тухай хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцтой нийцүүлж 2016 онд баталсан нь Монгол Улсад эрх зүйн ээлтэй орчинг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

Өнгөрсөн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд бусад иргэдийн нэгэн адил оролцох эрхийг үл хүлээн зөвшөөрч, тэднийг гагцхүү “төрийн тусламж, дэмжлэг хүртэгч”, “эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээний объект” мэтээр үзэх нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээний загвар үйлчилж байв. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц батлагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгмийн хандлагад шинэ эргэлт гарч “Хүн зөвхөн согог, гэмтлийнхээ улмаас хөгжлийн бэрхшээлтэй болдоггүй бөгөөд бие эрхтний согог, гэмтэл, нийгмийн орчны хязгаарлалттай нэгдэн нийлж хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг”⁷⁸ гэсэн ойлголтыг гаргаж иржээ. Тухайлбал, тэргэнцэртэй хүн ямар нэг ажил хөдөлмөр эрхлэх чадваргүйдээ биш, гагцхүү ажлын байр түүнд хүртээмжгүй учраас хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Үүний нэгэн адил сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд ч бусад хүүхдийн адил суралцах оюуны чадавхгүйдээ биш, харин тэдэнд сургалтын орчин, гарын авлага, багш хангалтгүй, сургууль хүртээмжгүйгээс сургуульд бүрэн хамрагдаж, амжилттай суралцаж чадахгүй байна. Энэ хандлагыг хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар хэмээн тодорхойлж, нийгмийн орчин болон үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгоход анхаарах шаардлагатайг дээрх конвенцоор баталгаажуулжээ.

Ийнхүү олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах,

⁷⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц 1 дүгээр зүйл.

хамгаалах талаар баримтлах зарчим, төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, оролцоо тодорхой болж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боломждоо тулгуурлан хөдөлмөр эрхлэх, онцлог хэрэгцээндээ нийцсэн нийгмийн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэгш хамрагдах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Гэвч хэрэгжүүлэх механизм бүрэн ажиллахгүй, төрийн удирдах болон гүйцэтгэх шатны байгууллагуудын чиг үүрэг ерөнхий, зарим тохиолдолд тодорхойгүй, мөн хуулийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын хандлага, мэдлэг хангалтгүй зэргээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарт бодитой нөлөөлж чадахгүй байна. Цаашлаад эдгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, нас зэргийг тооцдоггүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудал орхигдох, анхаарлын гадна үлдэх явдал түгээмэл байна.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод⁷⁹ “хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэх”⁸⁰ зорилгыг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн тодорхойлсон ч хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн нийгэм, эдийн засаг, хөгжлийн үйлчилгээг орхигдуулж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрх зөрчигдөхөд хүргэж байна.

⁷⁹ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2016–2025 он.

⁸⁰ Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 16–ны өдрийн 261 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого.

Тухайлбал, иргэд олноор үйлчлүүлдэг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нөхөн үржихүйн кабинетэд тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тохирсон хүртээмжтэй үзлэгийн ор, харааны болон сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн онцлогт тохирсон угтах үйлчилгээ, дохионы хэлмэрч, орчуулагч байдаггүй. Мөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, мэдээлэлд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй холбоотой асуулт ордоггүй тул дээрх эмэгтэйчүүд ямар төрлийн үйлчилгээг илүү авдаг, жилд хэдэн эмэгтэй үйлчилгээнд хамрагдаж буй талаар тоон мэдээлэл улсын хэмжээнд гардаггүй⁸¹ байна. Энэ төрлийн судалгаа, тоо баримт байхгүй тул тухайн асуудлаар бодлого, төлөвлөлт хийдэггүй, улмаар тэдний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлж чаддаггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил бие даан амьдарч, нийгмийн амьдралд оролцох хүсэлтэй байдаг ч сурах, хөдөлмөрлөх, нийгмийн үйл хэрэгт оролцох, гэр бүлтэй болох, эмнэлэг, сургууль, олон нийтийн байгууллагаас үйлчилгээ авах, тээврийн хэрэгслээр зорчих, хэрэгцээтэй мэдээллээр бүрэн хангагдах боломж, нөхцөл хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь нийгмийн олон хүчин зүйлээс хамааралтай ч нийгэм дэх буруу хандлага ихээхэн нөлөөлдөг.

Тухайлбал, Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст халамжийн үйлчилгээг хүргэхдээ гэр бүлийнхэнд нь даатгах, тэднийг асран хамгаалагчид мөнгөн тэтгэмж олгох зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрт хамаарах асуудлаар шийдвэр гаргах, бие даан амьдрах, гэр бүлтэй болох, бэлгийн хамтрагчтай байх, хүүхэд төрүүлэх, эцэг эх байх эрхээ

⁸¹ Эрүүл мэндийн яамнаас 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 1а/1009 дугаар албан бичиг.

эдлэхэд гэр бүлийн гишүүд хөндлөнгөөс нөлөөлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг хангах нь төрийн үүрэг тул тулгамдаж буй асуудлыг тоо баримт, судалгааны үндэслэлтэйгээр баримтжуулж, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагч, олон нийтийн анхааралд хүргэх шаардлагатай байна.

2.2.Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал

Комисс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтийн байдлыг үнэлэх, нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн санал, дэмжлэгтэйгээр Орхон, Булган, Дорноговь аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт шалгалт, Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо төрийн бус байгууллагатай хамтран Архангай, Өвөрхангай, Хэнтий, Дархан-Уул, Баянхонгор, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотод судалгаа⁸² хийв.

Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй 300 эмэгтэй хамруулснаас 42 хувь нь тулгуур эрхтний, 31 хувь нь хараа, сонсголын бэрхшээлтэй, 17 хувь нь оюуны, 10 хувь нь бусад хэлбэрийн бэрхшээлтэй байв. Судалгаанд оролцсон хоёр хүн тутмын нэг нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой бөгөөд нийт оролцогчдын 90 хувийнх нь гэр бүлийн сарын орлого хэрэгцээнд хүрэлцдэггүй учир хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд тэтгэвэр, тэтгэмжийнхээ 84.5 хувийг гэр бүлийн хэрэгцээнд зарцуулдаг байна.

⁸² “Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, нөлөөлөгч зарим хүчин зүйл” судалгаа, Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо, ХЭҮК, 2018 он.

Дээрх эмэгтэйчүүдийн 40.2 хувь нь гэрлэсэн, 24.7 хувь нь ганц бие, 8.1 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан, 5.5 хувь нь хамтран амьдрагчтай гэж хариулсан бол 88.6 хувь нь ам бүлийн тоо 1–2 гэжээ. Мөн нийт оролцогчдын 32.8 хувь нь боловсролын түвшин доогуур буюу уншиж, бичиж чаддаггүй бол ажил эрхлэлтийн түвшин дөнгөж 33 хувь байна. Тэдний боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртөмтгий, бусдаас хэт хараат болгож байгааг судалгааны дүн харуулж байна. Уг судалгаагаар тогтоогдсон зарим нөхцөл байдлыг доорх дэд сэдвүүдийн хүрээнд тоймлов.

2.2.1 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл авч буй байдал, мэдлэг, хандлага

Нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллээр хангагдах эрхийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ⁸³, дотоодын хууль тогтоомжоор⁸⁴ баталгаажуулснаас гадна эрүүл мэнд, нөхөн үржихүйн, ялангуяа бэлгийн цогц боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендэрийн хувьд тусгай хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах⁸⁵, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаар сургалт зохион байгуулах, брайль

⁸³ Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 12.1 16.1 (e), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 25 дугаар зүйл.

⁸⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29.1.1

⁸⁵ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 3.1.13

үсгээр сурталчилгааны материал боловсруулж түгээх⁸⁶, хараагүй, харааны бэрхшээлтэй эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох⁸⁷ зэргийг холбогдох баримт бичгүүдэд тусгажээ.

Судалгаанд оролцогчдын 16 хувь нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээллийг эмч, мэргэжилтнүүдээс, 84 хувь нь найз нөхөд, гэр бүлийн гишүүд, интернэт, мэдээллийн хэрэгсэл зэрэг эх сурвалжаас авч байна. Мөн давхардсан тоогоор тэдний 51 хувь нь энэ төрлийн мэдээллийг телевизээс авдаг гэжээ. Гэтэл телевизүүдийн мэдээлэл нь харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй бус байгааг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос 2015 онд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжид дурдсаныг анхаарах хэрэгтэй.⁸⁸

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээллийг боловсролын түвшингээс хамаарч, харилцан адилгүй хүлээн авч байна.

⁸⁶ Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр.

⁸⁷ Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай олон улсын Марракешийн гэрээ, 2015 он.

⁸⁸ Тус зөвлөмжид "...Оролцогч улс хүртээмжийн талаар авч байгаа арга хэмжээгээ зөвхөн хөдөлгөөний бэрхшээлээр хязгаарлаж, мэдээлэл харилцааны технологийн бусад саад бэрхшээлийг орхигдуулсан байна гэж Хороо үзэж байна. Ялангуяа брайль болон дохионы хэлийг хууль ёсны болгоогүй бөгөөд одоогоор зөвхөн нэг телевизийн суваг маш хязгаарлагдмал хугацаанд хүртээмжтэй контент (мэдээллийн бүтээгдэхүүн) явуулж байна гэж конвенцын Хороо үзэж байна. Оролцогч улс хүртээмжийн талаар хууль тогтоомж хэрэгжүүлэх зэрэг алхам хийж байгаа боловч энэхүү хүртээмжийн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөөцийн хуваарилалт болон албадан хэрэгжүүлэх арга зам нь хангалтгүй хэвээр байна" гэжээ.

(Хүснэгт 3) Боловсролгүй болон бага боловсролтой иргэдийн 20 хүрэхгүй хувь нь л энэ төрлийн мэдээллийг авдаг бол бүрэн бус дунд ба түүнээс дээш боловсролтой эмэгтэйчүүдийн 80 хувь нь мэдээллийг авч чаддаг ажээ.

Хүснэгт 3. Боловсролын түвшин ба мэдээллийн эх үүсвэр

Судалгаанд оролцогчдын боловсролын байдал	Мэдээллийн эх үүсвэр						Нийт
	Телевиз, радио (хувиар)	Хэвлэмэл, зурагт хуудас (хувиар)	Гэр бүл, найз нөхөд (хувиар)	Бүлэг, хамт олны сургалт (хувиар)	Эмч, мэргэжилтнүүд (хувиар)	Бусад (хувиар)	
Боловсролгүй	3.8	-	1.1	0.8	0.8	4.6	11.1
Бага	3.4	0.4	0.8	0.4	1.1	1.1	7.3
Бүрэн бус дунд, бүрэн дунд	26.4	1.5	5.7	4.2	6.9	8.8	53.6
Их, дээд сургууль, коллеж	17.2	0.8	1.1	1.1	5	2.7	28
Нийт	51	2.7	8.8	6.5	13.8	17.2	100

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад оролцогчид нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг ихэвчлэн ээж, эгч, найз нөхдөөсөө авдаг, харин өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эмэгтэйчүүдийн эмчгүй, эсхүл эмч нар нь туршлага багатай, дүүргийн эмнэлэгт үзүүлэхэд 1–2 сар хүлээдэг, эмнэлэгт дохионы хэлний орчуулагч байдаггүй, эмч нарын ажлын ачаалал их, харилцаа хандлага муу зэргээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллагаас дээрх үйлчилгээг авахад хүндрэлтэй байдгийг дурджээ.

Тохиолдол 11

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн наад захын асуудал болох сарын тэмдэг хугацаандаа ирэхгүй байх, цагаан юм ихээр гарах үед хэрхэх талаар зөвлөгөөг өрхийн эмнэлгээс хангалттай авч чаддаггүй. Миний хувьд интернэт, гүүгл ашиглаж л энэ төрлийн мэдээлэл авдаг. Гэтэл авч байгаа мэдээлэл үнэн зөв эсэх нь маш эргэлзээтэй байдаг. Би ингэж мэдээлэл авч байхад оюуны, харааны бэрхшээлтэй хүмүүс бүр л хэцүү байдаг байх.

Бүлгийн ярилцлага, тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэй

Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдлын вирусын халдвараас сэргийлэх мэдлэг, хандлага, дадалтай холбоотой асуудлыг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт дараах байдлаар тусгасан байна. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод (2007–2021) эрүүл мэндийн хөгжлийн асуудалд баримтлах стратегийг тодорхойлохдоо иргэдийг БЗДХ, ХДХВ, ДОХ, сүрьеэгээс өөрсдийгөө хамгаалах чадвартай болгох арга хэмжээг тусгажээ. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.2–т “Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын талаарх үнэн зөв, бодит мэдээлэл олж авах, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх аргад суралцах бүрэн эрхтэй” гэж заасан байна. Мөн тус хуульд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тус халдварт өвчнөөс сэргийлэх арга, дадал хандлагын талаар сургалт сурталчилгаанд ажилтнуудаа идэвхтэй хамруулж хамтран ажиллахаар зохицуулсан байна. Түүнчлэн дээрх өвчний

халдварыг эрт илрүүлэн эмчилгээ, үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор эмнэлгийн үйл ажиллагааг стандартчилж, эрт илрүүлэлт оношилгооны нарийн арга зүйг баталжээ.⁸⁹

Гэвч дээрх судалгаанд оролцогчдын гурван хүн тутмын нэг нь БЗДХ, ХДХВ-ын талаар мэдлэг ойлголт хангалтгүй байв. Судалгаанд оролцогчдын 17 хувь нь БЗДХ авч байсан гэсэн бол 50 хувь нь асуултад хариулаагүй байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, мэдээлэл хомс, оролцох боломж бага байгаа нь БЗДХ, ХДХВ-ын халдвар авах эрсдлийг нэмэгдүүлж байна. Хэдийгээр энэ төрлийн мэдээ мэдээлэл авах эрх нь хуулиар баталгаажсан боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн мэдээллийн хүртээмж хомс байна.

Судалгаанд оролцогчдоос БЗДХ, ХДХВ хэрхэн халдварладаг талаарх мэдлэг, ойлголтыг тодруулахад давхардсан тоогоор 57.6 хувь нь хамгаалалтгүй бэлгийн хавьтлаар, 25.8 хувь нь зүү тариураар, 2.2 хувь нь үнсэлцэхэд, 4.1 хувь нь жорлонгоор, 5.9 хувь нь ахуйн замаар, 19.2 хувь нь цус, цусан бүтээгдэхүүнээр, 29.9 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Мөн эдгээр өвчний үед илрэх шинж тэмдгийн талаар мэддэг эсэхийг асуухад 50.9 хувь нь огт мэдэхгүй, 24 хувь нь бага зэрэг, 10.7 хувь нь сайн, 7.7 хувь нь маш сайн мэднэ гэжээ. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний талаарх мэдлэг ойлголтыг нь тодруулахад 9.2 хувь нь гепатит, 38.7 хувь нь тэмбүү, 49.1 хувь нь ДОХ, 26.6 хувь нь трихомониаз, 2.2 хувь нь хламид, 9.2 хувь нь мөөгөнцрийн тухай тус тус мэддэг гэж хариулжээ.

⁸⁹ Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 8-р сарын 3-ны өдрийн А/305 тушаалын хавсралт БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үзүүлэх журам.

Тохиолдол 12

Бэлгийн замын халдварт өвчин, ДОХ-ын талаар огт сонсож байгаагүй. Хааяа зурагтаар бэлгэвч хэрэглэ гээд байдаг. Нэг залуутай хамт амьдарч байгаад бэлгийн харилцаанд орсон. Тун удалгүй намайг хаяад явсан. Сар гаруй хугацааны дараа доороос үнэртэй ногоон юм ихээр гарах болсон. Гэрийнхэндээ хэлж чадахгүй нэг найзтайгаа цуг явсан чинь “Чи өвчин авсан юм уу? Балиар юм” гээд намайг хаяад явсан. Сургуульдаа ч явахаасаа ичдэг болсон. Хэрвээ би тэр үед эмэгтэй хүн өвчин авдаг гэдгийг мэдсэн бол, бэлгэвч хэрэглэх ёстойг мэдэж байсан бол ийм байдалд орохгүй байх байсан.

Сонсголын бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан
ярилцлага

Тохиолдол 13

Манай хараагүй найз БЗДХ-тай болсон. Энэ тухайгаа хэнд хэлэхээ мэдэхгүй, ямар өвчин авснаа яаж мэдэх вэ гэж их шаналсан. Арай гэж нэг найздаа ойлгуулаад эмнэлэг дээр очсон чинь БЗДХ-тай хүмүүс улаан шугамтай хэсгийн цаана очдог юм байна. Тэнд нь очоод зогсохоос ичээд нөгөө хүн манай найзыг орхиод явсан. Эмчид үзүүлэхээр ороход “Өөрийгөө яая гэж байж өвчин чирч ирээд хэнтэй, хэрхэн, яаж?” гээд нэг бүрчлэн яриулах гээд их эвгүй харьцсан. Дахиж эмнэлэг дээр очоогүй. Хүнээс асууж байгаад нэг эм авч уусан, эдгэсэн байх гэж найдаж байгаа. Ийм үед утасдаад зөвлөгөө авчихдаг үйлчилгээ байвал их хэрэгтэй санагдсан. Мөн хэнээс, хэзээ, яаж гэсэн асуулт асуухгүйгээр эмнэлэгт хүргээд өгдөг туслах үйлчилгээ байвал олон талаар маш их хэрэгтэй байна. Мөн эмч нарт хөгжлийн бэрхшээлтэй хүн ч гэсэн бусад иргэдийн адил өвддөг, эмчилгээ авах эрхтэйг ойлгуулах сургалт хэрэгтэй юм шиг санагдсан.

Харааны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан
ярилцлага

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаас харахад харааны болон сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүд бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХ-ын талаарх мэдээлэл, үйлчилгээ хүртээмжгүйн улмаас бэлгийн замын халдвараас өөрийгөө хамгаалах арга хэмжээ авч мэдэхгүй, бэлгийн замаар дамжих халдварт өвчин авах, халдвар авсан тохиолдолд мэргэжлийн эмчээс зөвлөгөө, үйлчилгээ авч чадахгүй байх, хүсээгүй жирэмслэх, үр хөндүүлэх зэргээр хохирч байна. Иймд тэдний онцлог хэрэгцээнд тохирсон хүртээмжтэй мэдээлэл, үйлчилгээг бий болгох нь чухал байна.

2.2.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдалт

Эрүүл мэндийн анхан шатны болон урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж, иргэдийг хамруулах нь эрүүл мэндийн байгууллага болон иргэдэд аль алинд нь чухал тул эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанарт төр анхаарлаа хандуулах шаардлагатай юм. Үйлчлүүлэгч төвтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин нөхцөлөөс гадна үйлчилгээний менежмент, мэргэжлийн чадавх, хандлага ихээхэн хамааралтайг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод дурдсан.⁹⁰

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдалтыг дэмжих чиглэлээр хууль тогтоомжоос гадна хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх⁹¹, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,

⁹⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 25, 26 дугаар зүйл.

⁹¹ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 4.1.1

эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлдэх⁹², хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн үйлчилгээг хүртэх, гэр бүл, нийгмийн амьдралд идэвхтэй, тэгш оролцоход ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох⁹³, эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүний өвөрмөц хэрэгцээнд нийцсэн ээлтэй тусламж, үйлчилгээг бий болгох⁹⁴, эрэгтэй, эмэгтэй хүнийг нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн чиглэлийн бусад сургалт, сурталчилгаанд оролцох, үзлэг, шинжилгээнд хамрагдахад саад учруулахыг хориглох⁹⁵ зэргээр бодлогын бусад баримт бичгүүдэд тусгасан байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/512 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага” эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зааварт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн бүх шатны байгууллагууд дотоод дүрэм журамдаа өөрчлөлт оруулж, тэдний онцлог хэрэгцээнд тохируулсан үйлчилгээг хүргэх талаар тодорхой заажээ.

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авч чадахгүй байгаа нь эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлага, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтоос ихээхэн хамааралтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ

⁹² “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр 3.2.4.10

⁹³ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 4.3.9.

⁹⁴ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр 3.1.3.2

⁹⁵ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг.

үзүүлнэ” гэж заасан ч хангалттай хэрэгждэггүйг судалгааны дүн харуулж байна.

Тохиолдол 14

Эмнэлгийн ачаалал маш их, дараалал ихтэй байдаг. Энэ үед бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах боломжгүй байдаг. Үзүүлэх гээд очихоор “Яасан?” гэж асуудаг. “Зөвлөгөө авах гэсэн юм” гэхээр “Ажил ихтэй амжихгүй” гэж хэлдэг. Утсаар зөвлөгөө авах гэхээр “Үзүүлээгүй хүнд юу ярих юм бэ” гэж хэлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй хийсэн
бүлгийн ярилцлага, Сэлэнгэ аймаг

Тохиолдол 15

Хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэйчүүд, ялангуяа харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд их өртдөг. Жишээ нь би хэнд хүчирхийлүүлсэнээ мэдэж чадаагүй, бэлгийн замын халдварт өвчин авч байсан. Эмнэлэгт үзүүлэхээр очиход “Хараагүй байж хэнээсээ авдаг байна. Эрийн донтой байх нь ээ” гэж эмч хэлж байсан. Би эмнэлэгт очих дургүй. Яагаад өвчин авсан талаар асуухгүй байж шууд дүгнэлт хийдэг.

Харааны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Судалгаанд оролцогчдын 56.1 хувь нь жилд 1–2 удаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг, 14.4 хувь нь огт хамрагдаж байгаагүй, 12.9 хувь нь жилээс дээш хугацаанд, 10.3 хувь нь сард 1–2 удаа үзлэгт хамрагддаг гэжээ.

Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлийн төрөл ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдалт

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байдал	Хувь
Тулгуур эрхтний бэрхшээлтэй	Хамрагдаж байгаагүй	0.8
	Жилд 1–2 удаа	9.8
	Улиралд 1–2 удаа	1.1
	Сард 1–2 удаа	1.1
	Бусад	2.6
Сонсголын бэрхшээлтэй	Хамрагдаж байгаагүй	3.4
	Жилд 1–2 удаа	8.3
	Улиралд 1–2 удаа	0.8
	Сард 1–2 удаа	1.9
	Бусад	0.8
Харааны бэрхшээлтэй	Хамрагдаж байгаагүй	8.3
	Жилд 1–2 удаа	25.7
	Улиралд 1–2 удаа	0.4
	Сард 1–2 удаа	3
	Бусад	6
Оюуны бэрхшээлтэй	Хамрагдаж байгаагүй	2.3
	Жилд 1–2 удаа	8.7
	Улиралд 1–2 удаа	1.1
	Сард 1–2 удаа	3
	Бусад	2.3
Бусад хөгжлийн бэрхшээлтэй	Хамрагдаж байгаагүй	0
	Жилд 1–2 удаа	6.4
	Улиралд 1–2 удаа	0.8
	Сард 1–2 удаа	1.5
	Бусад	1.5

Дээрх хүснэгтээс харахад нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд сонсголын бэрхшээлтэй эмэгтэйчүүд хамгийн бага хамрагддаг байна. Мөн Комиссоос хийсэн хяналт шалгалтын явцад эрүүл мэндийн байгууллагын

ажилтнуудаас өгсөн мэдээлэлд сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээ авахад заавал хэлмэрчтэй ирэх шаардлага бий болдог талаар дурдсан болно. Төрийн үйлчилгээний энэ мэт хүртээмжгүй байдал нь хувь хүний эрүүл мэндийн нууцын халдашгүй байдлыг хөндөж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаас зайлсхийх, зохих үйлчилгээг авч чадахгүйд хүргэж байна.

Тохиолдол 16

Сонсголын бэрхшээлтэй болохоор эмнэлгийн үйлчилгээ авна гэдэг бол маш хэцүү. Бичгээр илэрхийлэх гэхээр өөрсдөө бичиг үсэг сайн мэдэхгүй, эмнэлгүүдэд дохионы хэлмэрч байхгүй.

Сонсголын бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авахад 51.3 хувь нь хүндрэлтэй, 22.1 хувь нь хааяа хүндрэлтэй байдаг гэж хариулсан бөгөөд бусад бэрхшээлтэй харьцуулахад харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд илүү саад бэрхшээл учирдаг байна.

Тохиолдол 17

Хөгжлийн бэрхшээлтэй гэхээр хүмүүс тэргэнцэртэй байх ёстой мэтээр төсөөлдөг. Би уналт таталт өгдөг. Эмнэлгүүдэд суух сандал цөөхөн. Би гаднаасаа ямар ч бэрхшээлгүй харагддаг учраас хүмүүс мэддэггүй. Олон хүнтэй газраар явах, хүмүүс шуугилдах, бүгчимдэх, 20–30 минут дараалалд зогсоход л өөрийн хяналтгүй шууд ухаан алддаг тул дүүргийн эмнэлгээр явж үзүүлэхэд их бэрхшээл учирдаг.

Эпилепси оноштой эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага, Улаанбаатар хот

Тохиолдол 18

Бэлгийн замаар дамжих халдварт өвчин авчихсан байж магадгүй гээд эмнэлэгт үзүүлэхийг хүссэн ч нууцыг минь хадгалаад эмнэлгээр дагуулаад явах найдвартай хүн олоогүй, эцэст нь танилаасаа нэг сайн эмний тухай сонсоод авч уусан. Эдгэсэн байх аа л гэж найдаж байгаа. Ийм тохиолдолд туслах үйлчилгээний ажилтан маш их хэрэгтэй байна.

Харааны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол 19

Би 44 настай, тэргэнцэртэй болоод 20 жил болж байна. Эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэхийг хүсдэг ч тохирох ариун цэврийн өрөө эмнэлэгт байхгүй, үзлэгийн орон дээр гарах зэрэг бэрхшээлээс айгаад одоог болтол нэг ч удаа үзүүлээгүй. Мэдээж өөртөө санаа зовж байна.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага, Улаанбаатар хот

2.2.3. Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгсэл, түүний хэрэглээ

Судалгаанд оролцогчид ерөндөг, эм, хуанлийн аргуудыг хамгийн их хэрэглэдэг гэжээ. Гэхдээ жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг ашиглахад санхүүгийн боломжгүй, эмнэлгийн орчны хүртээмжгүй байдал болон өөрт тулгарсан асуудлыг эмч, эмнэлгийн ажилтнуудад ойлгуулахад хэцүү байдаг гэж хариулжээ.

Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийг хэрэглэдэг эсэхийг асуухад 10 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол 21 хувь нь хуанли, 39.1 хувь нь бэлгэвч, 27.3 хувь нь эм, 25.8 хувь нь тариа, 31.7 хувь нь ерөндөг, 21.8 хувь нь суулгац, 4.1 хувь нь диафрагма, 10.7 хувь нь үрийн суваг боох аргыг хэрэглэдэг гэжээ. Харин эмэгтэйчүүдийн 8.9 хувь нь гадуур тавих, 7 хувь нь угаах аргыг жирэмслэлтээс хамгаалах арга гэж үзсэн байна.

Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн талаарх мэдлэгийн түвшинг насаар нь харьцуулж үзэхэд 35-аас доош насны эмэгтэйчүүд энэ талын мэдлэг бага, харин 36-45 насны эмэгтэйчүүд илүү мэдлэгтэй байна.

Хүснэгт 5. Жирэмслэлтээс хамгаалах аргын талаарх мэдлэгийг насны ангиллаар үзвэл (хувиар)


Арга, хэрэгсэл	15-25 нас	26-35 нас	36-45 нас	46-с дээш
Хуанли	5.9	29.4	47.1	17.6
Бэлгэвч	9.2	26.2	33.8	30.8
Эм	8.3	8.3	50.0	33.3
Тариа	16.7	25	41.7	16.7
Ерөндөг	-	-	60	40

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл хомс, мэдээллийн эх үүсвэр баталгаагүй байгаагаас жирэмслэлтээс хамгаалах тохирох арга хэрэгслийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байна.

Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгсэлтэй холбоотой хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд ямар асуудал тулгарч байгааг асуухад 5.9 хувь нь хүртээмжтэй мэдээлэл байхгүй, 1.8 хувь нь эмнэлэг рүү дагуулж явах хүнгүй, 6.6 хувь нь эдийн засгийн боломжгүй, 4.4 хувь нь орчин хүртээмжгүй тул очиж үйлчилгээ авч чаддаггүй, 1.8 хувь нь бусдад өөрийгөө ойлгуулж чаддаггүй, 19.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийг бусдын шаардсанаар хэрэглэдэг эсэхийг асуухад дараах хариултыг өгчээ.


Бүдүүвч 3. Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийг хэн нэгний шахалтаар хэрэглэсэн эсэх

Жирэмслэлтээс хамгаалах аргыг хэн нэгний шахалтаар хэрэглэсэн эсэх?



Бүдүүвч 4. Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийг хэний шаардсанаар хэрэглэдэг болох

Жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийг хэний шаардсанаар хэрэглэсэн бэ?



Мөн судалгаанд хамрагдсан оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар хот, орон нутагт оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд жирэмслэлтээс сэргийлэх тариаг заавал хийдэг, татгалзсан тохиолдолд халамжийн тэтгэмж олгохгүй, асаргааг сунгахгүй гэх мэтээр халамжийн ажилтан, өрхийн эмч нар дарамт үзүүлж хүчээр хийдэг, зарим аймагт 3 сар тутмын аян болгож энэ ажлыг зохион байгуулдаг гэж хариулсан байна.

Тохиолдол 20

Намайг 18 нас хүрэхэд л өрхийн эмч надад жирэмслэлтээс хамгаалах тариа хийж эхэлсэн. Анх тариа хийлгэж байхад 48 кг жинтэй байсан. Одоо би 85 кг жинтэй болтлоо таргалсан. Энэ тариаг ийм олон жил тариулж болохгүй гэж сонссон.

Эпилепси өвчтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол 21

Би 35 настай, хүний эрхийн байгууллагад ажилладаг. Жилийн өмнө төрсөн. Сүүлийн саруудад өрхийн эмч маань байнга залгаж жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл тавиулахыг шаардаж байгаа. Би эмчид “Энэ миний эрхийн асуудал, шийдвэрээ би өөрөө гаргана” гэж хариулахад “Тэгвэл чиний асаргааны тэтгэмжийг сунгахгүй” хэмээн дарамталсан.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ярилцлага,
Улаанбаатар хот

Тохиолдол 22

Миний охин оюуны бэрхшээлтэй, 22 настай. Надаас салахгүй гэрийн ажил хийгээд миний дэргэд байдаг. 16 нас хүрэнгүүт багийн эмч жирэмслэлтээс сэргийлэх тариа хийхийг шаардаж эхэлсэн. Бид хоёр хийлгэхгүй гэж хэлсэн боловч групп сунгахгүй гэсэн болохоор аргагүйн эрхэнд 3 сар тутам тариаг хийлгэж байна. Миний охин хүнтэй ч унтаж үзээгүй, эрүүл мэндэд нь яаж нөлөөлөх бол гэж санаа зовдог. Бид хоёрт халамжийн хэдэн төгрөг нь хэрэгтэй болохоор л аргагүй байдалд ордог.

Асран хамгаалагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлага,
Хэнтий аймаг

Тохиолдол 23

Би 38 настай. Охин маань 18 настай. Саяхан хоёр дахь амьдралаа эхлүүлсэн. Нөхөр маань хүүхэд нэхээд, жирэмслэхгүй болохоор эмчид үзүүлтэл үрийн сувгийг анхны хүүхдээ төрүүлэх үед боосон байна гэж хэлсэн. Учрыг лавлалат өмнөх нөхөр маань ээжтэй ярилцаад шийд гаргасан, надад хэлээгүй байсныг саяхан мэдсэн. Би нөхөртөө энэ байдлаа хэлж чадахгүй, цаашид яахаа мэдэхгүй байна.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага,
Сэлэнгэ аймаг

Дээрх нөхцөл байдлаас харахад “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”⁹⁶, “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай тушаал”⁹⁷ зэрэг эрх зүйн актыг практикт буруу хэрэглэснээс болж хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх зөрчигдөж байна. Тодруулбал, “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”-д өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг илрүүлэх асуумжид сэтгэц мэдрэлийн эмгэгтэй жирэмсэн эмэгтэйг өндөр эрсдэлтэй жирэмсэн гэж үзэхээр оруулсан бөгөөд бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, дүүргийн эрүүл мэндийн төв, сум дундын болон хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүдэд өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг эх барих-эмэгтэйчүүдийн эмч,

⁹⁶ Эрүүл мэндийн яамны сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны 338 дугаар тушаалаар баталсан “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээ”-ний журам.

⁹⁷ Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2017 оны А/39, А/12 дугаар тушаал.

хавсарсан эмгэгтэй тохиолдолд холбогдох мэргэжлийн эмч нартай хамтран хянахаар зохицуулсан болно.⁹⁸

Гэвч бодит байдалд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг бэрхшээлийн төрөл, хүнд, хөнгөнийг сайтар харгалзахгүйгээр өндөр эрсдэлтэй жирэмсний ангилалд хамааруулан ойлгож жирэмслүүлэхгүй байх, жирэмсэлсэн тохиолдолд тэднийг буруутгаж, зүй бус харилцах, жирэмслэлтийг таслах, өөрт нь мэдэгдэлгүй үрийн сувгийг боох, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл тогтмол хэрэглэхийг шаардах, нийгмийн халамж олгохгүй гэх зэргээр шахалт үзүүлэх явдал гардаг талаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд цөөнгүй дурджээ.

2.2.4. Жирэмслэлт, үр хөндөлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжид “...Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, ялангуяа сэтгэц болон оюун ухааны бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хязгаарлаж, албадан үрийн суваг боох, үр хөндөхийг зөвшөөрдөг заалтыг Эрүүл мэндийн тухай хуулиас хасах, ийм дүрэм журам, зохицуулалтыг хүчингүй болгохыг Хороо Оролцогч улсаас шаардаж байна. Оролцогч улсын эрүүл мэндийн хууль, тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс эмчилгээний талаар үнэ төлбөргүй мэдээлэл авч чадахгүй, өөрсдийнх нь зөвшөөрлийн дагуу үйлчилгээ үзүүлэхгүй байна гэж үзэж байна”⁹⁹ гэжээ. Судалгаанаас үзэхэд гэр бүлийн

⁹⁸ Эрүүл мэндийн яамны сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны 338 дугаар тушаалаар “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журмын 3.4.7 дахь заалт.

⁹⁹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хорооноос Засгийн газарт 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өгсөн зөвлөмжийн 29 дэх хэсэг.


гишүүд, эмнэлгийн мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн жирэмсэлж, үр хүүхэдтэй болох шийдвэр гаргахад нь хөндлөнгөөс оролцож, нөлөөлж байна.

Судалгаанд оролцогчдын 26.9 хувь нь хүүхэд төрүүлж байгаагүй, 43.1 хувь нь 1–2 удаа, үлдсэн 24.4 хувь нь 3 болон түүнээс дээш удаа төрүүлж байсан бол хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 19.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй болохоос өмнө, 23.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй болсны дараа төрүүлсэн байна.

Жирэмсэлж байсан эмэгтэйчүүдийн 45.8 хувь нь жирэмсэн болсноо мэдээд баярласан, 10.7 хувь нь айсан, 5.5 хувь нь гайхсан гэжээ. Жирэмсэн болсныг нь гэр бүлийн 47.2 хувь нь дэмжсэн, 10 хувь нь баярлаж хүлээн авсан, 5.2 хувь нь дэмжээгүй гэж хариулсан байна.

Бүдүүвч 5. Жирэмсний хяналтад орсон байдал

Жирэмсний хэдэн сартайд эмчийн хяналтад орсон бэ?



Тэдний 73 хувь нь эхний гурван сард, 21 хувь нь 4–6 сартайдаа эмчийн хяналтад орсон байна. Монголд 15–49 насны эмэгтэйчүүдийн 81 хувь нь жирэмсний эхний 3 сард хяналтад ордог бол¹⁰⁰ хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд энэ үзүүлэлт бага байна.

Хүүхэд төрүүлж байсан эмэгтэйчүүдээс “Төрөх эмнэлэгт байхад таны сэтгэлд нийцэхгүй зүйлс тохиолдож байсан уу?” гэж асуухад 35.1 хувь нь тийм зүйл байгаагүй гэсэн бол 65 хувь нь эмнэлгийн мэргэжилтний хандлага харилцаа, эмнэлгийн орчин нөхцөл хангалтгүй байсан талаар дурдсан байна. Тухайлбал, 12.5 хувь нь эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлага муу, 6.3 хувь нь хүнд сурталтай, 10 хувь нь авлига өгсөн хүнд сайн үйлчилдэг, 4.8 хувь нь төрөлтийн талаар ямар ч зөвлөгөө өгөөгүй, 7 хувь нь тохируулгат тоног төхөөрөмж, ор байгаагүй, 4.8 хувь нь ариун цэврийн өрөөг ашиглаж чадахгүй байсан, 1.8 хувь нь эмчтэй харилцаж чадахгүй байсан гэжээ.

Комиссоос 2019 оны 2 дугаар сард Дорноговь, Орхон, Булган аймгуудын нэгдсэн эмнэлэгт хийсэн хяналт шалгалтаар тус эмнэлгүүдийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч нартай уулзалт, ярилцлага хийхэд хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйд үзлэг хийх, төрүүлэх зориулалтын ор, тоног төхөөрөмж байдаггүй нь хүндрэл учруулдаг талаар хэлж байлаа. Түүнчлэн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн кабинетын орц, гарц, ариун цэврийн өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд үйлчлүүлэх нөхцөл боломжоор бүрэн хангагдаагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай¹⁰¹ хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Эрүүл мэндийн

¹⁰⁰ Эх сурвалж: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас 2013 онд хийсэн Нийгмийн олон үзүүлэлтийн түүвэр судалгаа.

¹⁰¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг.

байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.”, 20.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 20.2–т заасан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах орчныг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр–эрүүл ахуйн материал, эрт илрүүлгийн урвалж бодисын зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэнэ” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд нэн тэргүүнд тулгамддаг нөхөн үржихүйн асуудал нь эмнэлгийн үйлчилгээ хэвийн авч чаддаггүй, жирэмслэх, ураг тээх явцад үүсч болох эрсдлийг хянах боломж хязгаарлагдмал байдаг явдал юм. Финландын Засгийн газрын Флом олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо төрийн бус байгууллагаас “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дэмжих бүлгүүдийг чадавхжуулах замаар тэдэнд хүрэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад нөлөөлөх нь” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 1 дүгээр амбулаторийг хүртээмжтэй нөхөн үржихүйн кабинет, дасгалын өрөөтэй болгожээ. Уг кабинет нь олон үйлдэлтэй, эмэгтэйчүүдийн үзлэгийн ортойгоос гадна дасгал, хөдөлгөөн хийх төхөөрөмжтэй байна. Түүнчлэн тэргэнцэртэй жирэмсэн эмэгтэйчүүдэд суугаагаараа жингээ үзэх боломжийг бүрдүүлжээ. Одоогоор улсын эмнэлгүүд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан тусгай ор, жин, дасгалын тоног төхөөрөмжгүй бөгөөд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвд нээгдсэн уг кабинет анхдагч нь болжээ. Тус кабинет 2017 оны 12 дугаар сард нээлтээ хийсэн бөгөөд аймаг,

дүүрэг харгалзахгүй үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэхэд чиглэжээ.¹⁰² Гэвч энэ төрлийн кабинетын тоо, хүртээмж улсын хэмжээнд хангалтгүй байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос 2015 онд Засгийн газарт өгсөн зөвлөмжид “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг санхүүгийн хязгаарлалтгүйгээр үзүүлэх шаардлагатай арга хэмжээ авах, мөн тэдний бэрхшээлээс үл шалтгаалан бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үнэ төлбөргүй үйлчилгээ, эмчилгээний талаар мэдээлэл авч, эмчилгээг зөвшөөрөх эрхтэй” гэсэн бөгөөд 2017 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар “Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”¹⁰³-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад нөхөн үржихүйн насны бүх охид, эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх үйлчилгээний төрөлд жирэмсний, төрсний дараах үеийн болон нөхөн үржихүйн бусад төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлэхээр заасан байна.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өрхийн эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үнэ төлбөргүй авах эрх зүйн орчин бүрдсэн боловч тухайн эмнэлгийн байгууллагын хүртээмж, хүрэлцээнээс шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд үйлчилгээнд хамрагдах боломж хангалттай бүрдээгүй байна. Тухайлбал, тулгуур эрхтний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй эмэгтэйчүүд өрхийн эрүүл мэндийн төвд хандаж үзлэг, шинжилгээнд хамрагдаж чадахгүй хэвээр байна.

¹⁰² “Өсвөр насны охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт” баримт бичгийн судалгаа, 2018 он, ХЭҮК.

¹⁰³ 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 470 дугаар тушаал.

Тохиолдол 24

Нэг удаа дүүргийн эмнэлэг дээр зохион байгуулдаг жирэмсэн ээжүүдийн сургалтад суусан. Тэнд ээжүүдийн төрөлтийг дэмжих дасгал зааж, би дагаж хийхийг хүссэн ч эмч "...за, ингээд гараа өргөөд, ...хөлөө ингээд дээш өргөөрэй, намайг дууриагаад хийгээрэй" гээд яриад л байсан. Би харж чадахгүй болохоор юу болоод байгааг бүрэн ойлгоогүй.

Харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй хийсэн
бүлгийн ярилцлага

Тохиолдол 25

Жирэмслээд өрхийн эмч дээрээ ирэхэд "Чи хаяг дээрээ байдаггүй биз дээ. Яг хаана амьдарч байгаа вэ, тэндээ л эмчийн хяналтад ор, чамайг жирэмсний хяналтад авахгүй, чи бол эрсдэлтэй жирэмсэн. Ямар нэгэн юм болчихвол би хариуцлага хүлээхгүй" гэж хэлээд татгалзсан.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Судалгаанд оролцогчдын 63.6 хувь нь үр хөндүүлж байгаагүй, 36.4 хувь нь үр хөндүүлж байсан гэж хариулжээ. Үүнээс 26 хувь нь өөрийн хүсэлтээр, 31 хувь нь биеийн эрүүл мэндийн улмаас, 13 хувь нь бусдын дарамт шахалт, 5 хувь нь хүчирхийллийн улмаас жирэмсэлсэн, 25 хувь нь бусад (нөхөр өөр хүнтэй болсон г.м) шалтгаанаар үр хөндүүлж байжээ.

Тохиолдол 26

Эмч нар жирэмслэхийг хориглодог. Тийм болохоор 5 сартай жирэмсэн хүртлээ эмч нараас нуусан. Намайг эмч нарын зөвлөгөөнөөр орох өдөр эмч нар жирэмсэн гэдгийг мэдээд үр хөндөлт хийлгэхийг ятгасан. Татгалзах үед тэд тал талаас гар бариад би цочролд ороод ухаан алдсан. Сэрэх үед жирэмслэлтийг зогсоосон, үрийн сувгийг боосон байсан. Үүгээр зогсохгүй гэр бүлийнхэнд маань хүлээлгэж өгөхдөө уналт таталтын эмийг нь сайн уулга гэсэн бичиг энгэрт томоор бичээд гаргасан. Цочролоос болоод энэ үед миний ухаан санаа хагас байсан.

Оюуны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 148 дугаар тушаалаар баталсан “Үр хөндөлтийг зохицуулах журам”-ын 5.г-д “...мэргэжлийн эмч нарын дүгнэлт, зөвлөгөөний шийдвэрээр дор дурдсан заалтаар зөвхөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, амаржих газар, нэгдсэн эмнэлэгийн төрөх тасагт туршлагатай мэргэжлийн зэрэгтэй эх барих эмэгтэйчүүдийн эмч гүйцэтгэнэ” гэж заасны дотор “Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийгөө болон бусдыг асрах чадваргүй эмэгтэй өөрөө хүсвэл” гэж тусгасан байна. Гэвч уг журмыг хэрэгжүүлж буй эмнэлгийн мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг сэтгэцийн эмгэгтэй, удамшлын өвчтэй гэх шалтгаанаар хэвийн жирэмсэлж, хүүхэд төрүүлж, өсгөж чадахгүй гэж үзээд жирэмслэлтийг хүчээр тасалж байгаа хүний эрхийн зөрчлийг зогсоох хэрэгтэй юм.

Түүнчлэн Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд эрүүл мэндийн салбарын үзүүлэлтээр жирэмсэлсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эдгээрээс үр хөндүүлсэн, ураг зулбасан, эх эндсэн эсэх талаарх тоон мэдээлэл улсын хэмжээнд гардаггүй бөгөөд энэ тоон мэдээллийг 2019 онд шинээр оруулахаар төлөвлөж байгаа талаар дурджээ.¹⁰⁴

2.2.5 Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 6 дугаар зүйлд “Оролцогч улсууд нь конвенцод заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх, боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг авна” гэж заажээ. Түүнчлэн Конвенцын хэрэгжилтийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Засгийн газарт өгсөн зөвлөмжид “...Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл зэрэг хүчирхийлэлд өртөж буй тохиолдлын баримтжуулалт дутмаг, мөн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд хамаарах асуудлаар шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоо хязгаарлагдмал байгаад Хороо санаа зовинож байна. Иймд хуулийн шинэчлэл, бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ, ялангуяа гэр бүлийн амьдрал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт болон гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдтэй зөвлөлдөхийг Хороо Оролцогч улсаас шаардаж байна. Мөн Оролцогч улс

¹⁰⁴ Эрүүл мэндийн яамнаас 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Комисст ирүүлсэн 1а/1009 дугаар албан бичиг.

жендэрийн бодлогодоо хөгжлийн бэрхшээлтэй охид, хүүхдүүдийг хамруулах¹⁰⁵-ыг зөвлөжээ.

Судалгаанд оролцогчдын 73.8 хувь нь бэлгийн харилцаанд орсон гэх бөгөөд тэдний 52 хувь нь 20-оос дээш, 23.2 хувь нь 17–19 настайдаа орсон байна. Бэлгийн харилцаанд орсон эмэгтэйчүүдээс нөхөн үржихүйн хамгийн идэвхтэй буюу 26–45 насны эмэгтэйчүүдийн 28 хувь нь огт ордоггүй, 33 хувь нь жилд цөөн удаа бэлгийн харилцаанд ордог гэж хариулжээ.

Энэ төрлийн харилцаанд нийгмийн болон хандлагын олон хүчин зүйлс нөлөөлж байгаа нь эмэгтэйчүүдтэй хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаас харагдаж байна.

Тохиолдол 27

Би 40 настай. Хүүхэд байхдаа саажилтын улмаас тэргэнцэртэй явдаг болсон. Одоог хүртэл бэлгийн харилцаанд орж үзээгүй. Зурагт, интернэтээс гадны мэдээллийг авдаг, хааяа гадуур гарах үед аав, ээж, дүү нараас маань хэн нэг нь заавал хамт явдаг. Надад хүнтэй танилцах, эрэгтэй найзтай болох боломж олддоггүй. Би бусад хүмүүс шиг амьдарч чадахгүй ч хүүхэдтэй болохыг маш их хүсдэг.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд орчны хүртээмжгүй байдлаас шалтгаалан бие даан нийгмийн амьдралд оролцож чаддаггүй, хэн нэгний тусламж дэмжлэг, хараа

¹⁰⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хорооноос Засгийн газарт 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өгсөн зөвлөмжийн 11 дэх хэсэг.

хяналтад байдаг тул найз залуу, бэлгийн хамтрагчтай болох боломж тэр бүр олддоггүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлийн талаарх гэр бүлийн гишүүдийн ойлголт, хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөнд нөлөөлж байна. Хот, орон нутагт ялгаагүй хөгжлийн бэрхшээлтэй охиноо гэрлэх насанд хүрэх үед бие даан амьдрах, сонголтоо өөрөө хийх эрхийг хүндэтгэх тухай мэдлэг, ойлголт хангалтгүй байна.

Тохиолдол 28

Анх 20 настайдаа найз залуутай болж байсан. Энэ үед аав ээж хоёр маань “Чам шиг хүн хүнтэй суудаггүй юм аа, хүүхэд ч гаргаж болохгүй. Чи зүгээр л гэртээ бай” гэж загнаж, найз залуутайгаа уулзахыг хорьдог байсан. Удалгүй би жирэмсэн болж энэ тухайгаа аав ээждээ хэлэхээс айж, найз залуудаа хэлтэл “Чамаас эрүүл хүүхэд төрөхгүй, авахуул” гэсэн. Маш их цочирдсон ч хүүхдээ гаргана гэж зориглож байтал хүүхэд маань 4 сартайдаа зулбачихсан. Дахиж би ерөөсөө жирэмслээгүй. Миний амьдралын туршлагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй охидод эцэг эхийн дэмжлэг их хэрэгтэй юм байна лээ, Тэр үед ээж, аав маань намайг ойлгож дэмжсэн бол гэж их боддог.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага, Дархан–Уул аймаг

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хангахын тулд нэн түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадавхжуулж, эрхээ мэдэх, шаардах чадварт сургах, улмаар гэр бүлийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын талаар ойлголт өгч, мэдээллээр хангах, нийгмийн дэмжлэгт орчин, бие даан амьдрах, туслах үйлчилгээг бий болгох замаар хөгжлийн

бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг хэн нэгнээс хараат бус амьдрах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн бүх төлөөллийг хамруулж 2017 онд хийсэн жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлангаас харахад судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 14 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлж байв.¹⁰⁶ Тэгвэл Комиссоос хийсэн судалгаанд Улаанбаатар хотоос оролцогчдын 18 хувь нь, орон нутгийн оролцогчдын 3.6 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, 19.9 хувь нь ойр орчимд нь хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгэн бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тохиолдлыг мэднэ гэжээ.


Бэлгийн хүчирхийллийн талаарх ойлголтыг тодруулахад 7 хувь нь санаандгүй байдлаар биед хүрэх, илэх, 7 хувь нь зөвшөөрөлгүй үнсэх, тэврэх, 2 хувь нь бэлгийн чадавх, зан үйл, туршлагын талаар ярих, 8 хувь нь порно бичлэг, хэвлэмэл материал үзүүлэх, 6 хувь нь бэлгийн харилцаанд орохыг шаардах, 63 хувь нь хүчиндэх, хүчиндэхээр завдах үйлдлийг дурджээ.

Дээрх хүчирхийллийн хэлбэрүүдийн аль нь танд тохиолдож байсан бэ? гэсэн асуултад 49.1 хувь нь тохиолдож байгаагүй, 14 хувь нь санаандгүй байдлаар биед хүрэх, илэх, 9.6 хувь нь зөвшөөрөлгүй үнсэх, тэврэх, 3.3 хувь нь бэлгийн харилцааны тухай ярих, 1.5 хувь нь порно бичлэг, хэвлэмэл материал үзүүлэх, 5.9 хувь нь бэлгийн харилцаанд орохыг шаардах, 4.8 хувь нь бэлгийн сэдэл бүхий дохио зангаа үзүүлэх, 7.7 хувь нь хүчиндэх, завдах гэж хариулсан байна.

¹⁰⁶ Үндэсний Статистикийн Хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлаг, Хүчирхийллийн нүцгэн үнэн, 2017 он.

Бүдүүвч 6. Дээрх хүчирхийллийн хэлбэрүүдийн аль нь танд тохиолдож байсан бэ?

Дээрх хүчирхийллийн хэлбэрүүдийн аль нь танд тохиолдож байсан бэ?



- Хүчирхийлэлд өртөж байгаагүй
- Санаандгүй байдлаар биед хүрэх, илэх
- Зөвшөөрөлгүй үнсэх, тэврэх
- Бэлгийн харилцааны тухай ярих
- Порно бичлэг, хэвлэмэл материал үзүүлэх
- Бэлгийн харилцаанд орохыг шаардах
- Бэлгийн сэдэл бүхий дохио зангаа үзүүлэх
- Хүчиндэх, хүчиндэхээр завдах

Бүдүүвч 7. Хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн хамаарал


Хүчирхийлэл үйлдэгч хохирогчтой ямар хамааралтай байсан бэ?




Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг хүчирхийлэгчид нь ихэвчлэн тэдний гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүс байна.

Бүдүүвч 8, 9. Хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэлсэн эсэх

Хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэн нэгэнд хэлж байсан уу?



Хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэнд хэлж байсан бэ?



Хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэн нэгэнд хэлж байсан уу? гэсэн асуултад 71 хувь нь үгүй, 29 хувь нь тийм гэж хариулсан байна. Тийм гэж хариулсан оролцогчдын 55 хувь нь найздаа, 42 хувь нь гэр бүлийн гишүүддээ, 3 хувь нь бусад байгууллагад, 3 хувь нь цагдаад хандсан гэжээ.

Цагдаагийн ерөнхий газраас Комисст ирүүлсэн мэдээлэлд Эрүүгийн хуульд заасан бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирогчоор тогтоогдсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан Хүчиндэх гэмт хэрэгт 2018 онд улсын

хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 24 эмэгтэй хохирогчоор тогтоогдсоны 7 нь насанд хүрээгүй охид, 17 нь насанд хүрсэн эмэгтэйчүүд байна.¹⁰⁷ Энэ төрлийн гэмт хэрэгт орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд илүү хохирчээ. Тухайлбал орон нутагт насанд хүрээгүй 6, насанд хүрсэн 11 эмэгтэй хохирогчоор тогтоогдсон байна.

2018 онд тус хуулийн 12.2 дугаар зүйлд заасан Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг, 12.5 дугаар зүйлд заасан Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, 15.5 дугаар зүйлд заасан Хууль бусаар үр хөндөх гэмт хэргүүдэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирогчоор тогтоогдоогүй гэжээ.

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн ярилцлагаас үзвэл ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд цагдаагийн байгууллагад мэдэгдэлгүй өнгөрөх магадлалтай байна. Иймд үүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулийн хэрэгжилтийг¹⁰⁸ хангуулах, хяналтыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголт, хүчирхийллийг мэдээлэх чадавхийг нэмэгдүүлэх, тэдний онцлогт тохирсон мэдээллээр хангах хэрэгтэй юм.

¹⁰⁷ Цагдаагийн ерөнхий газраас 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн О1/122 дугаар албан бичиг.

¹⁰⁸ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх”.

Тохиолдол 29

Гэртээ ээж, аав, хүүтэйгээ дөрвүүлээ амьдардаг. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар ээжээсээ сонсож байсан. Хүчинд автаж үеэлтэйгээ бэлгийн харилцаанд орсон. Энэ тухайгаа аав, ээждээ хэлсэн ч аав дүүгээ загнаад л өнгөрсөн. Бид нар дүүгийнхтэй нь нэг хашаанд хамт амьдардаг. Тухайн үед цагдаад хэлээгүй өнгөрсөн. Нэг хашаанд байдаг болохоор дахиад хүч хэрэглэх вий гэхээс их айдаг. Хааяа жорлон орох гээд явж байхад сэмхэн манайд ороод ир гээд чирээд байдаг. Сogтуу үедээ мессэж бичиж гараад ир гэх зэргээр айлгадаг.

Оюуны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол 30

Ээж, аав гадагш гарах болоод намайг нэг танихгүй ахаар харуулсан. Тэр ах намайг хүчирхийлсэн. Энэ тухай аав, ээждээ хэлснээс хойш аав намайг 3 удаа хүчирхийлсэн. Аав ээжийг зоддог болохоор би ээжид энэ тухай хэлээгүй.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол 31

Манай ээж энэ хүнтэй суугаад 2 хүүхэд гаргасан. Хойд эцэг надтай байнга бэлгийн харилцаанд ордог. Энэ нь бараг 5 жил болж байна. Ээжид хэлсэн ч ээж энэ хүнээс салаад, яаж амьдрах вэ гэж хэлдэг. Би тэр хүний хүүхдийг хүртэл гаргасан. Цагдаад хэлэх гэхээр ээжийгээ бодоод чаддаггүй.

Оюуны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн
ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол 32

Би гадуур гарахдаа байнга такси хөлсөлж явахаас өөр аргагүй байдаг. Манай нутгийн зүс мэдэх жолооч намайг нэг удаа гэрт минь буулгалгүйгээр аваачиж хүчирхийлсэн. Би “Цагдаад хэлнэ” гэхэд... тэр хүн “Тэг тэг ...цагдаа нар чам шиг хөгжлийн бэрхшээлтэй хүний үгэнд итгэхгүй, миний үгэнд илүү итгэнэ. Би чамайг өөрөө дагаж явсан гэж хэлнэ” гэсэн. Олон хоног бодсоны эцэст хэнд ч хэлэхгүй байхаар шийдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй болж төрж ээж, аавыгаа зовоочихоод дахин муухай хэргээр нэрийг нь гутаагаад яахав гэж бодсон. Би тэр явдлаас хойш эрэгтэй хүнд итгэхээ больсон.

Одой эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Энэ мэтчилэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан хүчирхийлэх явдал гэр бүлийн гишүүд, ойр дотны хүрээллийн дотор түгээмэл бөгөөд тэднийг хамгаалах, мэдээллээр хангах, сэтгэл зүйн, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний тогтолцоо бий болоогүй байна. Нөгөөтээгүүр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ихэнхдээ гэр бүлийн хүрээнд үйлдэж байгаа тул илрэх нь бага байна.

Иймээс хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, нуугдмал, далд гэмт хэргийг илрүүлэхэд чиглэсэн хяналтын механизмыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, бие даан нийгмийн харилцаанд оролцох боломжгүй охид, эмэгтэйчүүдэд хүрч ажиллахад баг, хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багийн үйл ажиллагааг чиглүүлэхэд анхаарах хэрэгтэй юм.

Дүгнэлт

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд батлагджээ. Тодруулбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах талаар баримтлах зарчим, төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, оролцоог тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боломждоо тулгуурлан хөдөлмөр эрхлэх, онцлог хэрэгцээндээ нийцсэн нийгмийн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тэгш хамрагдах эрх зүйн орчныг үндсэнд нь бүрдүүлсэн байна.

Гэвч эдгээрийг хэрэгжүүлэх механизм бүрэн ажиллахгүй, төрийн удирдах болон гүйцэтгэх шатны байгууллагуудын чиг үүрэг ерөнхий, мөн хуулийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын мэдлэг хангалтгүй, хүний эрхэд суурилсан хандлага сайтар төлөвшөөгүйгээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийн хэрэгжилтэд бодитой ахиц гарахгүй байгааг Комиссын хийсэн хяналт шалгалт, судалгааны үр дүн харуулж байна.

Засгийн газар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд байгуулсныг Комисс сайшаахын зэрэгцээ цаашид энэхүү илтгэлд хөндсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлыг орхигдуулалгүйгээр анхаарал хандуулж ажиллахыг зөвлөж байна.

III

БҮЛЭГ

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРМТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

“Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалт)

“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, үнэ цэнэ, нэр төрийн хувьд тэгш эрхтэй. Энэ эрх чөлөөгөө яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч ялгаварлалгүйгээр эдлэх, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй. Хэнтэй ч нэр төрийг нь доромжлон харьцах ёсгүй”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 2 дугаар зүйл)

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын¹⁰⁹ 1 дүгээр зүйлд заасан “эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах гэсэн нэр томьёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ” гэж тодорхойлсон бол мөн Конвенцын 2 дугаар зүйлд “Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг буруушаан, эмэгтэйчүүдийг ялгаварлах үзлийг устгах бодлогыг зохистой бүхий л аргаар нэн даруй хэрэгжүүлэхээр тохиролцож, энэхүү зорилгоор арга хэмжээг авах” талаар заажээ.

Түүнчлэн Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах Хорооны “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” 19 дүгээр Ерөнхий зөвлөмжид “Хүйсэнд тулгуурласан хүчирхийлэл” нь ялгаварлан гадуурхах явдлын тодорхойлолтод багтах бөгөөд энэ нь эмэгтэй хүнийх нь хувьд түүний эсрэг чиглэсэн, эсвэл эмэгтэйчүүдэд тэнцвэргүй байдлаар нөлөөлж байгаа хүчирхийлэл юм. Үүнд бие махбод, сэтгэл санаа, эсвэл бэлгийн хор уршигт хүргэж буй үйлдэл, эсвэл иймэрхүү үйлдлийн аюул заналхийлэл, зовлон шаналгаа, албадлага болон эрх чөлөөг бусад байдлаар хязгаарлах явдлууд багтдаг” гэж тодорхойлжээ.¹¹⁰

¹⁰⁹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 34/180 дугаар тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1980 оны 7 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурж, 1981 оны 5 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталсан.

¹¹⁰ Хүний эрхийн хорооноос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжийн эмхэтгэл 2004 он.

Дэлхийн 130 гаруй улс ажлын байран дахь бэлгийн дарамтыг хүний эрхийн зөрчилд тооцон бие даасан хууль гарган, эсхүл холбогдох хуулиудад тусган буруутай этгээдэд хариуцлага оногдуулж байна.¹¹¹ Түүнчлэн улс орнууд соёлын хүчин зүйлээсээ шалтгаалан бэлгийн дарамтыг олон янзаар тодорхойлж иржээ.

Аль ч өнцгөөс нь тодорхойлсон “бэлгийн дарамт” гэдэг ойлголтыг дэлхий дахинаа 1) хүний эрхийн зөрчил, 2) хүйсээр ялгаварлан гадуурхах илрэл, 3) эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нэг хэлбэр 4) хувь хүний нэр төр, үнэ цэнэ, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэж үзэх хандлага давамгайлж байна.

Монгол Улсын хувьд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “...Бэлгийн дарамт гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.” гэж тодорхойлсон байна. Мөн тус хуульд ажлын байран дахь бэлгийн дарамтыг хориглож, ажил олгогч, ажилтны эрх үүргийг заасан боловч ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлсэн этгээдэд хэн, ямар хариуцлагыг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна.

Улсын Их Хурлаас 2015 онд баталсан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлыг гэмт хэрэгт тооцож хуульчилсан байв. Гэвч уг заалтыг 2017 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр

¹¹¹ Ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг авах арга хэмжээний талаарх олон нийтийн хандлага 2017, Ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын эвсэл.

хассанаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болжээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 23.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно”, мөн 24.1 дэх хэсэгт “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Харин Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх хэсэгт “албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах”-ыг төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглож, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсэгт “энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна. Тус хуулийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлыг хориглох, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болж байгаа нь сайшаалтай боловч төрийн улс төрийн

болон үйлчилгээний албан хаагчдад уг хуулийн зохицуулалт хамаарахгүй байгаа нь учир дутагдалтай байгаагаас гадна практикт асуудал дагуулж эхэлсэн байна.

Комисс 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 3/676 дугаар албан бичгээр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 21 дүгээр зүйлд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх Төрийн албаны зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс батлах дүрэм, журамд тодорхой тусгуулахаар дараах саналуудыг хүргүүлсэн байна. Үүнд:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой гомдлыг хүлээн авч, шийдвэрлэхэд тавих хяналт;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар авах арга хэмжээг заасны дагуу ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах асуудлыг төрийн байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд заавал тусгах зохицуулалтыг үүрэг болгох;
- Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага, төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах шалгуур үзүүлэлтэд жендэрт суурилсан хүчирхийлэл болон ажлын байран дахь бэлгийн дарамт үйлдсэн иргэнийг ажиллуулахгүй байх зохицуулалтыг журамд оруулан тусгах;
- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан

хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт сэдвийг заавал судлах сургалтын сэдэвт оруулан, шалгуур тавих;

Эдгээр саналууд нь Төрийн албаны тухай хуулийн хүрээнд мөрдөгдөх дүрэм, журмуудад тусгалаа олсон байна.

Комисс чиг үүргийнхээ хүрээнд сүүлийн гурван жилийн хугацаанд ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой найман гомдол хүлээн авч, шалгаж шийдвэрлэжээ.

Тохиолдол 33

....дугаарын утаснаас "...даргатайгаа хэзээ уулзах юм, санаа зоволтгүй, бид нас биед хүрсэн эр, эм хүмүүс. Би чамаас хайр халамж хүсч байна. Чи сэтгэл гаргавал би чадах бүхнээ хийнэ. Би чамайг маш их хүсдэг, ойлгооч муу даргыгаа. Хүүе! Чи даргатайгаа хэзээ уулзах юм? Чамайг 3 жил хүлээж байна. Би чамд татагдаж байна. Ганц удаа тэгэх үү, ахиж чамайг зовоохгүй...Чи халагдсан, коммунист зулбасга, ямар ч сэтгэл байхгүй чи муу баас ХУ намын хулгайч нарын хүүхэд, би чамайг ажилд авдаг буруудсан байна. Ямар ч байсан ажлаа ол, чамайг ажиллуулахгүй..." гэх зэргээр 46 мессежийг дарга С надад удаа дараа илгээж улмаар орон тоог цомхотгох үндэслэлээр ажлаас халсан.

Комисст ирүүлсэн иргэн А-гийн гомдлоос

...дарга С нь ажилтан А-д ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлж, улмаар түүнийг ажлаас чөлөөлсөн нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдсон тул С-д хариуцлага тооцуулахаар дээд шатных нь удирдлагад Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу шаардлага хүргүүлж, шаардлагын дагуу С-д сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Тохиолдол 34

Иргэн Ү Комисст хандан гаргасан гомдолдоо “...Миний бие 2017 онд ...байгууллагад диспетчерээр ажилд орсон бөгөөд ажилд орсон өдөр инженер Ш “чамайг дарга нартай танилцуулж өгье, чи ахиж дэвшиж ажиллая гэвэл надтай уулзах хэрэгтэй” гэж хэлсэн. Тэгээд маргааш өдрөөс эхлэн миний гар утас руу байнга залгаж эхэлсэн. Намайг шөнийн ээлжтэй үед ажил дээр ирж “хайр аа, ядарч байна уу” гээд гараас барьж, гуя, нуруу илэх зэргээр миний биеийн эмзэг хэсэгт хүрэхэд нь намайг уурлаж дургүйцэхээр “чам дээр ирээд гацна гэж байхгүй шүү, хөгийн муу хүүхэн” гэж харааж загнаад юм өшиглөж, хана цохиж, над руу нулимж доромжилдог. Инженер Ш нь надад байнга ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлж, хэвийн ажиллах нөхцөл боломжгүй болгосон тул энэ асуудлаар байгууллагын удирдлага болон ёс зүйн хороонд өргөдөл гаргасан боловч шийдвэрлэхгүй байна” гэжээ. Баримтуудаар инженер Ш нь диспетчер Ү-д ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлж, түүний эрхийг ноцтой зөрчсөн болох нь тогтоогдсон тул Ш-д хариуцлага тооцуулахаар тус байгууллагын даргад Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу шаардлага хүргүүлж, шаардлагын дагуу түүнийг ажлаас халах сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Тохиолдол 35

...байгууллагын дарга Н нь эмэгтэй албан хаагчдад байнга ажлын байрны бэлгийн дарамт учруулдаг талаар албан болон албан бусаар яригддаг боловч ямар нэг хуулийн арга хэмжээ авдаггүй, тэр байтугай албан тушаал байнга дэвшиж байдаг. Дарга Н нь эмэгтэй хүнийг ...зөвхөн дур хүслийг нь хангагч мэтээр авирлаж харилцдаг...

Жишээлбэл: тухайн байгууллагын ажилтан Э Комисст

хандаж гаргасан гомдолд “албан үүргээ гүйцэтгэж байх үед шөнийн 22 цагийн үед намайг дуудаж өрөөндөө оруулсан юм. Тухайн үед Н дарга архи уучихсан байсан. Тэгээд миний толгой өвдөөд байна. Толгой бариад өг гэхээр нь толгойг нь бариад гарах гэтэл миний гараас бариад намайг үнсэх гэсэн. Би гарыг нь тавиулах гэтэл тавихгүй байхаар нь дарга аа, би гарчихаад ороод ирье гэж хэлээд гарсан. Тэгтэл өглөө 6 цагийн үед дахин намайг дуудаж өрөөндөө оруулаад дахин үнсэх гэж дайрсан” гэжээ.

“Мөн ...байгууллагын ажилтан Б, түүний эхнэр Т нар хамт ажилладаг бөгөөд дарга Н шөнийн 3 цагийн үед эхнэр Т руу нь “хаана байна, би одоо л орж ирж байна” гэж мессэж бичсэн бөгөөд үүнээс болж Б эхнэр Т-тай маргалдаж улмаар Б цагдан хоригдож, цагдаагийн байгууллагад шалгагдсан” гэжээ.

Комисст ...байгууллагын эмэгтэй албан хаагчдаас
ирсэн гомдол, мэдээллээс

Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогч гомдлоо шийдвэрлүүлж чадахгүй байгаа гол шалтгаан нь хохирогчоос нотлох баримт шаарддаг, хохирогч хамгаалал, аюулгүй байдал баталгаагүй, хувийн нууцлал, мэдээлэл алдагддаг, тухайн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгадаггүй, ёс зүйн зөрчил болон байх ёстой зүйл мэтээр үзэх хандлага зэрэг хүчин зүйлс юм.

Ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах, хохирогч хамгаалах болон үйлчилгээ үзүүлэх механизмыг бий болгох, энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн 3.1.1-д “хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлж нэвтрүүлэх”, 3.5.4-т аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байран дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж заасныг дагаж мөрдөж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Монгол Улсад ажлын байран дахь бэлгийн дарамтыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар иргэний нийгмийн байгууллагууд хүчтэй дуу хоолой болж, тандалт судалгаанууд хийж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Монголын эмэгтэйчүүдийн сангаас 2016 онд хийсэн цахим судалгаагаар ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчдын 97.5 хувийг эмэгтэйчүүд, 2.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байсан бөгөөд ажлын байран дахь бэлгийн дарамт үйлдэгчдийн 97.5 хувь нь эрэгтэйчүүд, 87.4 хувь нь дээд боловсролтой, 69.2 хувь нь удирдах албан тушаалтнууд байна гэжээ.

Мөн боловсролын салбарт ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, илэрсэн дарууд таслан зогсоох талаар бодит ажил хийх шаардлагатай байна. Их, дээд сургуулиудад бэлгийн дарамт ноцтой асуудал болоод байгаа ч байгууллагын зүгээс ямар нэг үр дүнтэй арга хэмжээ авахгүй байна.

Тохиолдол 36

Хууль, дүрэм, журам тус сургууль дээр хэрэгждэггүй. Ажлын байран дээр архидах, завхайрах явдал хэрээс хэтэрч байгаа. Ажлын байран дээр байнга сэтгэл зүйн дарамт үзүүлдэг. Жишээ нь: Ажлаасаа гар, зайл. Оронд нь ажиллах хүн байна гэх мэтээр хувийн үзэл бодол таарахгүй хүмүүсийг удирдлагууд дарамталдаг. Захиргааны ажилтнууд эмэгтэй багш нар болон оюутнуудад уулзах санал хүчээр тавьж, шахалт үзүүлдэг. Уулзахгүй бол элдэв хов живэнд оруулна гэж дарамталдаг. Сургууль нийтээрээ энэ асуудлыг мэддэг ч зоригтой дуугарч хэлж чаддаггүй. Захиргааны залуу эмэгтэй ажилтнууд энэ асуудлаас болоод ажлаасаа гардаг ч юм бил үү гэсэн бодолтой болсон.

...их сургуулийн багш ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс¹¹²

Тохиолдол 37

Энэ талаарх мэдлэг муу. Энэ хуулийн хэрэгжилт ч гэсэн маш муу. Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой асуудал гарч байсан талаар сонсож байсан. Тухайлбал манай сургуулийн багш эмэгтэй оюутнуудад бэлгийн дарамт хэд хэдэн удаа учруулж байсан гэж дуулсан. Мөн өргөдөл өгсөн оюутнуудаа дарамталж өргөдлийг нь буцаан татуулсан учраас уг асуудлыг ёс зүйн хороогоор хэлэлцээгүй орхисон. Манай захирлын талаар ийм асуудал гарсан гэж сонссон.

...их сургуулийн оюутнуудын фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс¹¹³

¹¹² Монгол Улс дахь Ажлын байрны бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаа” 2018 он ХЭҮК, Шихихутуг их сургууль.

¹¹³ Мөн тэнд.


Театр, урлаг, спорт, соёлын газруудад тайзны ард буюу бэлтгэлийн үеэр охид, эмэгтэйчүүд бэлгийн дарамтад өртөж, авьяас чадвараа олон нийтэд хүргэж чадахгүй орхиход хүрч байна. Мөн ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын сүлжээнээс хийсэн цахим судалгааны дүнгээс үзэхэд нийт бэлгийн дарамтад өртсөн 18–24 насны эмэгтэйчүүдийн 25 хувь нь, эрэгтэйчүүдийн 13 хувь нь урлаг, спортын болон цахим орчинд бэлгийн дарамтад өртсөн байна.¹¹⁴

“Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын эвсэл”¹¹⁵–ээс 2017 онд ажлын байран дахь бэлгийн дарамтын талаар 17–70 насны 654 эмэгтэй, 99 эрэгтэй нийт 753 хүнээс судалгаа авахад 79.6 хувь нь “ажлын байрны бэлгийн дарамт их байдаг” гэжээ.

¹¹⁴ Н.Чинчулуун. Ажлын байран дахь бэлгийн дарамт гэж юу вэ? Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, соёлын талбарт хэрхэн урьдчилан сэргийлж таслан зогсоох вэ? 2017 он

¹¹⁵ Ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг авах арга хэмжээний талаарх олон нийтийн хандлага, 2017 он, Ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын эвсэл. /Судалгаанд нийт 17–70 насны 753 хүн оролцсон бөгөөд 654 буюу 86.8 хувь нь эмэгтэйчүүд, 13.2 хувь нь эрэгтэйчүүд/

Бүдүүвч 10. Таны бодлоор доорх үйлдлүүдийн аль нь ажлын байран дахь бэлгийн дарамт вэ?



- Бэлгийн сэдэлтэй онигоо, хошин яриа ярих
- Биеийн эмзэг хэсгийг анхаарч ярих, ширтэх
- Бэлгийн харилцааг янз бүрээр илэрхийлсэн зураг, дүрс бичлэг үзүүлэх
- Зөвшөөрөлгүй үнсэх, тэврэх, базах, хувцас тайлах гэж оролдох
- Бэлгийн харилцаанд орохыг янз бүрийн байдлаар санал болгох
- Хүсээгүй халамж тавих
- Зөвшөөрөөгүйн төлөө заналхийлэх, шахалт дарамт үзүүлэх
- Хүч хэрэглэж бэлгийн харилцаанд оруулахыг завдсан, оруулсан
- Дээрх бүгд

Дээрх бүдүүвчээс харахад 35 хувь нь дээрх үйлдлүүд бүгд ажлын байран дахь бэлгийн дарамт байна гэж хариулснаас үзэхэд бэлгийн дарамтын тухай мэдлэг, ойлголт харьцангуй нэмэгдэж байгаа мэт харагдаж байна. Гэвч судалгаанд оролцогчдын 67.8 хувь нь бэлгийн харилцаанд орохыг янз бүрийн байдлаар санал болгох, 70.6 хувь нь зөвшөөрөөгүйн төлөө шахалт дарамт үзүүлэх, заналхийлэх хүч хэрэглэж бэлгийн харилцаанд оруулах гэсэн хариултыг сонгосон байгаа нь ажлын байран дахь бэлгийн дарамт түгээмэл, далд ноцтой хэлбэртэй байгааг харуулж байна.

Ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт ямар байгааг есөн байгууллагын 1,120 хүнийг (407 оролцогч буюу 36.6 хувь нь эмэгтэйчүүд) хамруулан санал, асуулга авч судалгаа¹¹⁶ хийлээ.

Уг судалгаанд ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой үйлдэл, эс үйлдэхүй гарч байсан эсэхийг тодруулахад:

¹¹⁶ “Монгол Улс дахь Ажлын байрны бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаа” 2018 он ХЭҮК, Шихихутуг их сургууль.

Хүснэгт 6. Ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх нөхцөл байдал

№	Салбар	Судалгаанд хамрагдсан байгууллага	Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой үйлдэл, эс үйлдэхүй гарч байсан эсэх			
			Тийм		Үгүй	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Батлан хамгаалах салбар	Зэвсэгт хүчний ... анги	28	14.3	168	85.7
		Зэвсэгт хүчний ... анги				
2	Хууль сахиулах байгууллага	ШШГ Хорих ... анги	15	14.2	91	85.8
		ШШГ хорих ... анги				
3	Мэргэжлийн хяналтын байгууллага	МХЕГ	20	23.3	66	76.7
4	Боловсролын байгууллага	АШУУИС	113	19.1	480	80.9
		ҮБХИС				
		ХААИС				
		МУБИС	176	17.9	805	82.1
Дүн						


Ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой үйлдэл, эс үйлдэхүй гарч байсан гэж 176 хүн буюу 17.9 хувь, үгүй гэж 805 хүн буюу 82.1 хувь нь хариулснаас үзэхэд ажлын байран дахь бэлгийн дарамт байгаа төдийгүй боловсролын байгууллагад хамгийн олон 113 хүн ажлын байран дахь бэлгийн дарамт гарсан гэж хариулсан байна. Ажлын байран дахь бэлгийн дарамт нь нууц, далд үйлдэгддэг төдийгүй тухайн хүний нэр төр, алдар хүнд,

хувийн нууцтай холбоотой байдаг учир хохирогч ил гаргаж мэдээлэх дургүй байдаг байна.

Комисс 2018 онд ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхэд дүн шинжилгээ¹¹⁷ хийхээр 21 аймагт асуулга хүргүүлэхэд Дорноговь, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл аймгууд хариу ирүүлээгүй байна. Бусад 16 аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Биеийн тамир спортын газар, Статистикийн хэлтэс, Гаалийн газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Татварын хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба зэрэг нийт 246 захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.


¹¹⁷ 21 аймгийн төрийн байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, ХЗҮК, 2018 он.

Бүдүүвч 11. Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт тусгасан эсэх



Дээрх 246 байгууллагын 179 нь ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй буюу хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй, 65 нь хөдөлмөрийн дотоод журамдаа тусган хэрэгжүүлж байна, 2 нь тусгахаар хэлэлцэж байгаа гэсэн хариулт өгчээ.

Бүдүүвч 12. Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх заалт тусгаагүй шалтгаан



Хөдөлмөрийн дотоод журамд өнөөдрийг хүртэл ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх заалтыг тусгаж хэрэгжүүлээгүй шалтгааныг тодруулахад 246 байгууллагын 75 хувь нь 2019 онд хийхээр төлөвлөсөн, 17 хувь нь хуулийн сурталчилгаа хангалтгүй учир, 7 хувь нь удирдлагууд энэ асуудалд ач холбогдол өгдөггүй, 1 хувь нь ажлын байран дахь бэлгийн дарамт байхгүй гэсэн хариултыг өгчээ.

Мөн “Монгол Улс дахь ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаа”-нд хамрагдсан дараах байгууллагуудын хүрээнд авч үзэхэд¹¹⁸:

¹¹⁸ Монгол Улс дахь Ажлын байрны бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаа” 2018 он ХЭҮК, Шихихутуг их сургууль

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан байгууллагууд

Д/д	Судалгаанд хамрагдсан байгууллагуудын нэрс	Хөдөлмөрийн дотоод журамд ¹¹⁸ тусгагдсан байдал		Ёс зүйн дүрэмд ¹¹⁹ тусгагдсан байдал	
		Ерөнхий байдлаар	Тусгай байдлаар	Ерөнхий байдлаар	Тусгай байдлаар
1	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	-	-	+	-
2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	-	-	-	+
3	Үндэсний батлан хамгаалахын их сургууль	+	-	-	-
4	Зэвсэгт хүчний 2 анги	-	-	-	-
5	Хорих анги	-	-	-	-


¹¹⁹ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн №187 тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн захирлын 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн №А/96 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам, Үндэсний Батлан Хамгаалах Их Сургуулийн захирлын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/196 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам.

¹²⁰ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн № 253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм”, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн захирлын 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дүрэм”.

Эндээс үзэхэд 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлсэн заалтын хэрэгжилт хангалтгүй, төрийн байгууллагууд хууль хэрэгжүүлэхгүй байгаа нь харагдаж байна. Мөн дээрх байгууллагууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.4.2-т “бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, жендэрийн талаар сургалт явуулаагүй байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан байгууллагуудын ажилтан, албан хаагчидтай хийсэн уулзалт ярилцлага, санал асуулгаас харахад ажлын байран дахь бэлгийн дарамтын талаар төсөөлөлтэй байгаа боловч Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.7-д заасан ойлголтын талаар мэдэхгүй байна. Өөр хоорондоо хийсэн тоглоом наадам, наргиа болон хүний эрхийг зөрчсөн үйлдлийг ялгаж, салгаж ойлгохгүй байх нь түгээмэл байна.

Бүдүүвч 13. Ажлын байран дахь бэлгийн дарамт голчлон үйлдэгддэг газар (хувиар)



	Ажлын байрнаас гадуур	Үдийн цайны цагаар	Сургууль дээр	Тэмдэглэлт баярын өдрүүд	Тусгай өрөөнд	Баар, буудал	Даргын өрөөнд	Ажил дээр
■ 2004	48.2	0	0	21.3	0	31.7	13.7	24.3
■ 2017	0	0.7	1.4	14.4	19.4	31.7	20.9	46

Ажлын байран дахь бэлгийн дарамт үйлдэгдэж байгаа газар, байршлыг судалгаанаас¹²¹ харахад удирдах албан тушаалтнууд бэлгийн дарамт үзүүлдэг байдал 18.9 хувиар, хамтран ажиллагсад бэлгийн дарамт үзүүлэх байдал 15.6 хувиар нэмэгджээ. Ажлын байран дахь бэлгийн дарамт үйлдэгддэг газрын тоо, төрөл нэмэгдсэн бөгөөд 2004 онд таван нөхцөлийг нэрлэж байсан бол 2017 онд хийсэн судалгаагаар тэмдэглэлт баярын өдөр, сургууль дээр, үдийн цайны цагаар гэсэн гурван нөхцөл нэмэгджээ.

Тэгэхээр ажлын байр гэдгийг ажил, сургуулийн өрөө, тасалгаа, анги танхим, шат хонгил, орц, ажил, амралтын өрөө, тасалгаа, хонгил, ажилчдын нийтийн байр, байгууллагын унаа, тээврийн хэрэгсэл, ажилдаа ирэх очих замд, ажлын байранд хамаарах гадаад талбай, амралт зугаалгаар явсан газар, байрласан байр, байгууллагын чанартай тэмдэглэлт өдөр, баяр цэнгээн болж буй газар, томилолтоор ажиллах үед зочид буудал, унаа тээврийн хэрэгсэл, хурал, зөвлөгөөн, семинар явуулж байгаа байр, түүний орчин, харилцагч байгууллагын албаны болон бусад өрөө, унаа, тээврийн хэрэгсэл, үйлчилгээ үзүүлж буй бүхий л газар, ажилтан дадлагажуулах байр, талбай, ургацын талбай, гэрээгээр гүйцэтгэж буй малчны малын бэлчээр, ажилчин хөлсөлж байгаа газар, айл гэх мэт хүрээнд авч үзэж болох ч үүгээр хязгаарлагдахгүй өргөн талбар юм.

¹²¹ Охид, эмэгтэйчүүдийн ажлын байран дахь бэлгийн дарамтын төлөв байдал, хандлага” харьцуулсан судалгаа (2004, 2017), “Эмэгтэйчүүдийн эвсэл” төрийн бус байгууллага 2018 он.

Тохиолдол 38

Жендэрийн талаар ерөнхий ойлголттой байдаг боловч энэ хуулийн талаар мэдээлэл байхгүй. Энэ чиглэлийн сургалт, хэлэлцүүлэгт оролцож байгаагүй. Манай байгууллага дээр зохион байгуулагдаагүй. 2018 онд хүчингийн хэрэг гарч байсан. Хэрэгт холбогдсон этгээд одоо ажлаа үргэлжлүүлж хийгээд явж байгаа нь сэтгэл зүйн хувьд хэцүү байдаг. Ийм явдал дахин гарахыг үгүйсгэхгүй. Ажлын байран дээр бэлгийн харьцаанд орж байсан, түүнийг нь мэдсэн хүмүүс байдаг ч арга хэмжээ авч байгаагүй. Дээрх шалтгаанаар ажлын бус цагаар ялангуяа оройн цагаар сууж ажиллахад түгшүүртэй байдаг.

...их сургуулийн багш, ажилтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс.¹²²

Монгол Улс дахь Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаанд¹²³ хамрагдсан батлан хамгаалах, хууль сахиулах, мэргэжлийн хяналтын, боловсролын байгууллагуудаас авсан санал асуулгын дүнгээр ажлын байран дахь бэлгийн дарамтыг хэн нэгэн этгээд үзүүлж байсан гэж 96, үгүй гэж 824 хүн хариулсан бөгөөд тийм гэж хариулсан хүмүүсийн хариултын дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харна уу.

¹²² Монгол Улс дахь Ажлын байрны бэлгийн дарамтын нөхцөл байдлын судалгаа” 2018 он, ХЭҮК, Шихихутуг их сургууль.

¹²³ Мөн тэнд.

*Хүснэгт 8. Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл
байдлын судалгаа*

Таныг болон хамт ажиллагчдыг тань хүсээгүй байхад ажлын
хамтрагчийн зүгээс ажлын байранд бэлгийн дарамт үзүүлж байсан
эсэх

Тийм – 96

Үгүй – 824

“Тийм” гэж хариулсан хариултын задаргаа:		Давхардсан тоогоор
	Үг хэлэх, үзүүлэх, харуулах байдлаар:	
1	Эротик, порнографи зураг, бичлэг үзүүлэх, илгээх	33
2	Эротик нийтлэл, өгүүллэг уншиж өгөх	13
3	Бэлгийн харилцаатай холбоотой доог тохуу хийх	18
4	Бусдын бие галбир, бэлгийн харилцааны тухай ярих	18
5	Халуухан, секси, тачаангуй гэх зэрэг хоч өгөх	16
6	Янз бүрийн дуу авиа гаргах, сонсгох	12
7	Харж үзнэ, тушаал дээшлүүлнэ, гадаадад сургана, цалин нэмэх гэх зэргээр амлах	26
8	Шалтгаангүйгээр уулзах, болзох санал тавих	28
9	Бусад	43
	Биеийн үйлдлээр:	
1	Зохисгүйгээр байнга ширтэх	37
2	Өдөж хоргоох, татаж чангаах	36
3	Биеийн нууц, онцгой хэсгүүдэд хүрэх	20
4	Тэврэх, үнсэх, базах	28
5	Хувцас тайлахыг оролдох	46
6	Бэлэг эрхтнээ шүргүүлэх	4
7	Шалтгаангүйгээр уулзах, болзох санал тавих	33
8	Бэлгийн харьцаанд орохыг тулгах, хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулах	28
9	Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр завдах	44
10	Бусад байдлаар	9

Ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлж буй хэлбэрээс хамгийн өндөр тоо хэмжээ эзэлж байгаа нь “эротик, порнографи зураг, бичлэг үзүүлэх, илгээх, шалтгаангүйгээр уулзах, болзох санал тавих, архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бэлгийн хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр завдах, хувцсыг нь тайлахыг оролдох, зохисгүйгээр байнга ширтэх” зэрэг үйлдэл байна. Эндээс харахад ажлын байран дахь бэлгийн дарамтыг үг хэлээр, харуулах байдлаар мөн үйлдлээр зэрэг бүхий л хэлбэрээр үзүүлж байна.

Тохиолдол 39


Санамсаргүй бөгөөд санаатайгаар хөх, өгзөг гэх мэт эрхтэнд хүрч, баздаг...

...төрийн байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагаас

“Охид, эмэгтэйчүүдийн ажлын байран дахь бэлгийн дарамтын төлөв байдал, хандлага” харьцуулсан судалгаагаар¹²⁴ ажлын байран дахь бэлгийн дарамтыг ихэвчлэн хэн үйлдэж байна вэ? гэсэн асуултад оролцогчид дараах байдлаар хариулжээ.

¹²⁴ Охид, эмэгтэйчүүдийн ажлын байран дахь бэлгийн дарамтын төлөв байдал, хандлага” харьцуулсан судалгаа (2004, 2017), “Эмэгтэйчүүдийн эвсэл” төрийн бус байгууллага 2018 он.

Бүдүүвч 14. Ажлын байран дахь бэлгийн дарамтыг ихэвчлэн хэн үйлдэж байна? (Хувиар)




	Дарга	Удирдах албан тушаалтан	Хэлтэс, тасаг, цехийн дарга нар	Хамт ажиллагсад	Харуул, жижүүр, слесарь, манаач	Багш, сурган хүмүүжүүлэгчид	Бусад
■ 2004 он	17.7	42.4	5.61	4.77	.3	75	.3
■ 2017 он	23.7	61.1	10.8	30.3	2.83	.5	8.6

Эндээс үзэхэд удирдах албан тушаалтан ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлэх байдал 2004 онтой харьцуулахад 18.9 хувиар өссөн хандлагатай байна. Мөн хамтран ажиллагчдын хувь хэмжээ 14.7 хувиас 30.3 хувь болж өссөн байгаа нь ажлын байран дахь бэлгийн дарамт нь хүний эрхийн анхаарал татсан асуудал хэвээр байгааг харуулж байна. Харьцуулсан судалгааны үр дүнд үндэслэн ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх механизм, эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь чухал ач холбогдолтой юм. Мөн байгууллагын дарга болон удирдах, шийдвэр гаргах албан тушаалтныг “Хүний эрх ба Жендэр” сургалтад заавал хамруулах, хууль дүрэм, журмын биелэлтийг хангуулж ажиллуулах шаардлагатай байна.

байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдах, хүсээгүй байхад биед нь хүрэх, өөрийн нууц хэсэгтээ хүчээр хүргүүлэх зэрэг үйлдлүүдийг хамааруулна. Харин хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл гэдэгт хүчээр бэлгийн харьцаанд орох, архи, мансууруулах бодис хэрэглэсэн үед бэлгийн харьцаанд орох, нэгээс дээш хүнтэй нэгэн зэрэг бэлгийн харьцаанд хүчээр оруулах зэрэг үйлдлүүдийг хамааруулсан байна.¹²⁵

Амьдралдаа бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг давтамжаар нь авч үзвэл 64.1 хувь нь нэг удаа, 30.7 хувь нь цөөн удаа, 5.2 хувь нь олон удаа өртсөн гэжээ. Бусдын зүгээс үйлдсэн хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 68.7 хувь нь нэг удаа, 21.8 хувь нь 2–5 удаа, 9.5 хувь нь 5–аас дээш удаа өртсөн байна.¹²⁶

Бүдүүвч 15. Амьдралдаа бусдын зүгээс үйлдсэн дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд



¹²⁵ Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан Үндэсний Статистикийн Хороо, 2018 он.

¹²⁶ Мөн тэнд.

Бэлгийн хүчирхийлэлд долоон эмэгтэй тутмын нэг нь (14 хувь) амьдралдаа наад зах нь нэг удаа өртсөн байхад 2.6 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд өртсөн гэж хариулжээ. Дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдийн 8.1 хувь нь үйлдэгч хүсээгүй байхад биед нь хүрсэн, 6.6 хувь нь хүсээгүй байхад бэлгийн хавьталд хүчээр оруулахыг завдсан, 1.2 хувь нь өөрийн нууц хэсэгтээ хүчээр хүргүүлсэн гэж тус тус хариулжээ. Судалгаанаас үзэхэд дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд 13.6 хувь буюу ихэнх нь ажлын байрандаа өртсөн байна.

Хүснэгт 9. Ажлын байран дахь бэлгийн дарамтаас болж ямар бодит хохирол учирсан талаар

Танд болон таны мэдэх хүнд ажлын байран дахь бэлгийн дарамтаас болж ямар бодит хохирол учирсан бэ?			
Д/д	Хариултын төрөл	Хувь	Тоо
1	Нэр төр хохирсон	21.2	80
2	Хамт олныхоо дунд нүүр хийх газаргүй болсон	14.6	55
3	Хичээлээ тасалсан	3.7	14
4	Сургуулиа орхисон	4.8	18
5	Ажлын бүтээмж муудсан, ажлаа хэвийн хийж чадахгүй болсон	20.4	77
6	Цалин буурсан	2.9	11
7	Ажилгүй, орлогогүй болсон	8.8	33
8	Өөр ажилд шилжсэн	20.7	78
9	Бэлгийн замын болон халдварт өвчин авсан	1.9	7
10	Жирэмсэлсэн	3.2	12
11	Эрүүл мэндтэй холбоотой зардал гаргасан	5.6	21
12	Гэр бүлийн харилцаанд өөрчлөлт орж, гэр бүлийн хүчирхийлэл гарсан	6.9	26
13	Гэр бүл салсан	5.6	21
14	Амиа хорлох сэдэл төрж байсан	2.7	10
15	Бусдын амийг бүрэлгэх сэдэл төрж байсан	1.6	6

ГУРАВДУГААР БҮЛЭГ
АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

16	Ямар ч хүндрэл учраагүй	23.6	89
17	Бусад	23.1	87
18	Хариулт өгсөн	-	645
19	Асуултыг алгассан	-	108


Эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлоос гадна бусад хохирол ямар хувь хэмжээ эзэлж байгааг, ажлын байран дахь бэлгийн дарамт ямар үр дагавар, хор уршигтайг дээрх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 10. Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртөж байсан талаараа дээд шатныхаа байгууллага, албан тушаалтан, бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргасан эсэх

Тийм-58 хүн	
Үгүй-446 хүн	
Хариулаагүй-190 хүн	
Үгүй гэж хариулсан хариултын задаргаа	Тоо
Хаана хандахаа мэдэхгүй	75
Хандсан ч нэмэргүй эрх зүйн орчин байхгүй	68
Гомдол гаргах боломжгүй дарамт шахалт ирнэ	68
Нууц алдагдана	64
Хамт олны дунд нэр хүндгүй болно	90
Ажилгүй болохоос айсан	31
Бусад шалтгаанаар	50

Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн талаар гомдол гаргаагүй гэсэн 446 хүний хариултаас харахад “хаана хандахаа мэдэхгүй, хамт олны дунд нэр хүндгүй болно, гомдол гаргах боломжгүй дарамт шахалт ирнэ, хандсан ч нэмэргүй, эрх зүйн орчин байхгүй” гэсэн хариултууд хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь уг асуудлыг зохицуулах хууль эрх зүйн орчин хангалтгүй байгаатай холбоотой байна.

Бүдүүвч 16. Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгасан эвсэл



Хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг 220 байгууллага тусгаагүй, 25 байгууллага тусгасан, 1 байгууллага нь тусгахаар хэлэлцэж байгаа гэжээ. Уг дүн шинжилгээгээр¹²⁷ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт “ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар авах арга хэмжээ” авах заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

“Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын эвсэл”-ээс 2017 онд хийсэн ажлын байрны бэлгийн дарамтын талаарх тандалтын судалгаанд¹²⁸

¹²⁷ 21 аймгийн төрийн байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ ХЭҮК, 2018 он.

¹²⁸ Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг авах арга хэмжээний талаарх олон нийтийн хандлага 2017 он. Ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх төрийн бус байгууллагуудын эвсэл. /Судалгаанд нийт 17-70 насны 753 оролцогч оролцсон бөгөөд 654 буюу 86.8 хувь нь эмэгтэйчүүд, 13.2 хувь нь эрэгтэйчүүд/

Ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн хохирогч ямар арга хэмжээ авч, хэнд хандсан талаарх асуулгад хариулсан хариултыг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 11. Ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн хохирогчид ямар арга хэмжээ авсан бэ?

Ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн хохирогчид ямар арга хэмжээ авсан бэ?		
Хариултын төрөл	Хувь хэмжээ	Тоо
Даргадаа хэлсэн	3.5	10
Найз нөхөдтэйгөө зөвлөсөн	18.3	52
Байгууллагынхаа зохих шатны байгууллагад гомдол гаргасан	3.5	10
Шүүхэд гомдол гаргасан	1.4	4
Хүний эрхийн Үндэсний Комисст хандсан	0.7	2
Үйлдвэрчний Эвлэл, Эмэгтэйчүүдийн зөвлөл болон Хүний эрхийн төрийн бус байгууллагад хандсан	-	-
Ямар нэг алхам хийгээгүй	45.1	128
Мэдэхгүй	27.5	78
Хариулт өгсөн	-	284
Асуултыг алгассан	-	469

“Ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн хохирогч ямар арга хэмжээ авсан бэ?” гэсэн асуултад 45.1 хувь буюу 128 хүн ямар нэг алхам хийгээгүй, 27.5 хувь буюу 78 хүн мэдэхгүй, 18.3 хувь буюу 52 хүн найз нөхөдтэйгөө зөвлөсөн гэж хариулснаас харахад хохирогч юу хийхээ, хаана хандахаа мэдэхгүй, чимээгүй өнгөрүүлдэг байна. Энэ нь хохирогчид ажилгүй болох, нэр төрөө сэвтүүлэхээс эмээдэг, ажлын байранд сэтгэл санааны дарамт шахалтад өртөхөөс айдагтай холбоотой байна.

Дүгнэлт

Ажлын байран дахь бэлгийн дарамт нь далд үйлдэгдэж, давтагдах тусам даамжирч байдаг хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд үүнээс улбаалан хувь хүн, байгууллага, нийгэм бүхэлдээ хохирдог. Ажлын байран дахь бэлгийн дарамт нь хүн бүрт биеийн болон сэтгэл санааны хүнд дарамт учруулах, хөдөлмөрийн бүтээмж, амьдралын чанарт нь сөргөөр нөлөөлөх, ажил, албан тушаалаа орхихоос өөр аргагүй байдалд хүргэх, хохирогчийн нэр төрийг сэвтээх, улмаар амь нас нь хохироход хүргэх зэрэг хор уршигтай байна.

Бэлгийн дарамтад өртөж түүнийг даван туулж байгаа хүмүүст зайлшгүй тусламж, дэмжлэг, зөвлөгөө, хамгаалалт хэрэгтэй бөгөөд бэлгийн дарамтад өртсөн хүн зохих байгууллагаас туслалцаа авах, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх нь өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, гэм буруутай этгээдэд ял завшуулахгүй байх, цаашид энэ төрлийн хэрэг зөрчил гарч хэн нэгэн хохирохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, төрийн болон хувийн салбарын ажил олгогчид хуулийг хэрэгжүүлэх хүсэл сонирхолгүй, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрүүдийг тууштай авч хэрэгжүүлэхгүй байгаагаас хүний эрхийн ноцтой зөрчил гарсаар энэ төрлийн хүчирхийлэл буурахгүй, хүчирхийлэл үйлдэгч нь хуулийн хариуцлага хүлээхгүй үлдэж байна.

Төрийн улс төрийн болон үйлчилгээний алба, төрийн бус байгууллага, бизнесийн буюу хувийн хэвшлийн байгууллагад ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлсэн этгээдэд хэн, ямар хариуцлагыг хэрхэн тооцох нь тодорхойгүй, хуулийн ямар нэгэн зохицуулалтгүй байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2015 онд баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын 5 дахь зорилгод заасан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” талаар “Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах, бүх түвшинд жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, бүх охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх хүчирхэгжүүлэх зохистой бодлого, хэрэгжиж болох хууль тогтоомжийг батлан сайжруулах...” зорилтуудыг хэрэгжүүлэх хүчин чармайлтын хүрээнд холбогдох хууль тогтоомжид ажлын байран дахь бэлгийн дарамтыг таслан зогсоох, хориглох, түүнд хариуцлага тооцох зохицуулалт оруулах шаардлагатай байна.

IV

БҮЛЭГ

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны шүүхийн болон бусад арга хэмжээг авна.”

(Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээнэ.

(Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг)

4.1 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилт

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцоор оролцогч улсуудад эрүү шүүлттэй тэмцэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтэд өртсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байдаг.

Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц¹²⁹-д 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталснаас хойш 19 жил болжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос 2010 онд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн 11-д “Оролцогч улс нь эрүү шүүлтийн талаар гомдол хүлээн авч, шуурхай хянан шийдвэрлэх хараат бус, үр дүнтэй механизмыг амьдралд нэвтрүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн ял завших байдалд шүүмжлэлтэй хандаж, эрүү шүүлт тулгах, зүй бусаар хандах аливаа үйлдэлд буруутай нь тогтоогдсон этгээдийг цаг алдалгүй яллаж байх хэрэгтэй¹³⁰...” гэж, 2016 онд өгсөн зөвлөмжийн 15-д хороо нь дараах зүйлийг авч үзнэ: “[а] 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийн 10,

¹²⁹ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

¹³⁰ 2010 оны 11 дүгээр сарын 1-нээс 19-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайланг хэлэлцээд өгсөн зөвлөмж.

45 дугаар зүйлүүдэд нэмэлт, өөрчлөлт орсноор Мөрдөн байцаах албыг татан буулгахад хүргэсэн. Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны орон тоо, чиг үүргийн зарим хэсэг нь Авлигатай тэмцэх газарт, зарим чиг үүрэг нь Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албанд шилжсэн. Энэ нь ашиг сонирхлын зөрчилд хүргэх, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзахад хүргэж болзошгүй. Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны хийсэн мөрдөн байцаалтын үр дүнгийн талаарх мэдээлэл хангалтгүй байх, мөн Авлигатай тэмцэх газар нь эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг мөрдөн шалгах харьяалалгүй байх зэрэг нөхцөл байдал үүсч болзошгүй¹³¹ гэж зөвлөсөн байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Хороо нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаар Монгол Улсаас ирүүлсэн зургаа дахь удаагийн ээлжит тайлантай танилцаад 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Засгийн газарт дараах зөвлөмжийг ирүүлжээ. Үүнд:

Зөвлөмжийн 21-д “...Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Авлигатай тэмцэх газар эрүү шүүлт тулгасан хэргийг мөрдөн шалгахад бие даасан байдал хангалтгүй байгаад анхаарал хандуулахыг Хорооны зүгээс хүсч байна”. Мөн 22-д “...Оролцогч улс нь эрүү шүүлт тулгасан үйлдлийн талаар мөн зүй бус харьцааны талаар гаргасан бүх гомдол, мэдээллийг шуурхай, үр дүнтэйгээр шийдвэрлэж байгаа эсэхийг нягтлах, ийм төрлийн хэрэг

¹³¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2016 оны 8 дугаар сарын 2, 3-ны өдөр Монгол Улсын 2 дахь удаагийн илтгэл (CAT/C/MNG/2)-ийг 1443, 1445 дахь хуралдаанаар хэлэлцээд 2016 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 1453 дахь хуралдаанаар Монгол Улсад өгсөн зөвлөмж

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 18 ДАХЬ ИЛТГЭЛ

үйлдэгсдийг яллах, хэрэв шүүгдсэн тохиолдолд зохих ёсоор ял шийтгэгдсэн эсэх, хохирол нөхөн сэргээгдэх боломжтой эсэх, нөхөн төлбөр бүрэн авах боломжтой эсэхийг нягтлах ёстой” гэж тус тус зөвлөжээ.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний 2 дугаар илтгэлтэй холбогдуулан дараах зөвлөмжүүдийг Монгол Улсын Засгийн газарт өгчээ.

Хүснэгт 12. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас өгсөн зөвлөмж

Д/д	Өгсөн зөвлөмж	Улс
1	108.7 “Эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт протоколд нийцүүлэн зохих чадамж, нөөц бололцоотой үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах”	Бүгд Найрамдах Чех Улс
2	108.72 “Эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх хэргийг мөрдөн шалгах, хорих байрны болон шоронгийн барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогчдод олгох эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх”	
3	108.73 “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үүднээс цагдаагийн албан хаагчдын ойлголтыг нэмэгдүүлэх, мөн энэ хэрэгт ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх үүднээс мөрдөн шалгах үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох”	Франц
4	108.75 “Соёрхон батлаад удаагүй байгаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд заасан шаардлагын дагуу эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэргийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог байгуулах”	Австрали
5	108.76 “Эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцсан төрийн албан хаагчийн үйлдлийг үл тэвчих, эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх сэжигтэй этгээдийг мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэх”	Зүүн Тимор

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6	108.77 “Цагдаагийн албан хаагчийн эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг нь доромжлон харьцсан байж болзошгүй үйлдлийг мөрдөн шалгах бие даасан тогтолцоог бий болгож, төрийн албан хаагч ийм төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх”	Швейцар
7	108.78 “Эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй талаарх бүх гомдол, мэдээллийг бие даасан агентлаг бүрэн гүйцэд мөрдөн шалгадаг байх, тухайн үйлдлийг үйлдсэн этгээд хариуцлага хүлээдэг байх, түүнчлэн мөрдөн шалгалтыг зохих эрх мэдэлтэй, хараат бус болон сэжиглэгдэж байгаа этгээд, тэдгээрийн ажилладаг байгууллагад хамааралгүй бие даасан этгээд хийх нөхцөлийг бүрдүүлэх”	Швед
8	108.79 “Төрийн албан хаагч эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх үүднээс үйлдсэн байж болзошгүй бүх хэргийг цаг алдалгүй, бүрэн гүйцэт шалгах нөхцөлийг хангах арга хэмжээг эрчимжүүлэх”	Итали
9	108.80 “Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах бусад үйлдлийг халах арга хэмжээнүүд, түүний дотор хууль сахиулах эрх бүхий албан тушаалтнуудыг сургах, боловсрол олгох зэрэг арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэх”	Коста-Рика
10	108.82 “Хорих ял эдэлж байгаа хүмүүстэй харьцах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зохих алхмыг авч хэрэгжүүлэх”	Япон
11	108.126 “Ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцөлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх”	Герман
12	108.127 “Бүх гэмт этгээдэд ял оногдуулах, хохирогчид цаг алдалгүй эрхээ сэргээлгэх, хамгаалалт авах нөхцөлийг бүрдүүлэх”	Литва

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны удаа дараагийн зөвлөмжөөс үзэхэд эрүүдэн шүүсэн гэх алба хаагчдын үйлдлийг шалгах бие даасан байгууллага байгуулах, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн төлөх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцын Нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ биелүүлж, практикт хэрэгжүүлж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны тусгай илтгэгч Манфрэд Новак 2005 онд Засгийн газрын урилгаар ирж ажиллахдаа "...сэжигтнүүдийг эрүүдэн шүүх, тэдэнтэй хүнлэг бусаар харьцах явдал байнга гарч, үйлдэгчид шийтгэл хүлээлгэхгүй байх, түүний хохирогчдыг хамгаалах хууль эрх зүйн хамгаалалт, нөхөн олговор төлөх, нөхөн сэргээх зохистой үр нөлөө бүхий тогтолцоо практикт үгүйлэгдэж байна" гэж дүгнэснийг дахин сануулах нь зүйтэй.

Тэрээр Монгол Улсын Засгийн газарт дараах зөвлөмжийг өгчээ:

- Өмгөөлөгчийг байлцуулалгүйгээр цагдан хорих байранд байхдаа хийсэн болон шүүхийн өмнө нотлогдоогүй хэрэгт хэрэг хүлээх явдлыг хэрэг хүлээсэн хүний эсрэг нотлох баримт болгон хүлээн авахгүй байх;
- Мөрдөн байцаалтын өрөөнд явуулсан байцаан шийтгэх ажиллагааны үеэр бүх хүмүүсийг байлцуулан хийсэн видео болон аудио бичлэгийг давуу байдлаар авч үзэх хэрэгтэй;
- Эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бусаар харьцсан тухай бүх мэдээллийг шуурхай, няхуур шалгах, хараат бус эрх бүхий этгээд мэдээлэл өгсөн хохирогчийн эсрэг хэргийг мөрдөн байцаах болон шалгах явдалтай

аливаа холбоо хамааралгүй байдлаар мөрдөн шалгаж байх, Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар Хүний эрхийн Үндэсний Комисст энэ чиг үүргийг даалгаж болох;

- Төрийн албан хаагчаас хүч хэрэглэн эрүүдэн шүүж ял хүлээлгэх явдал байгаа бөгөөд эрүүдэн шүүн хуйвалдах, нотлох баримтыг үл ойшоох явдалд оролцсон прокурор, шүүгч нарыг шүүх хуралдаан явуулах болон яллах үүргийг даруй түдгэлзүүлэх;
- Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус харьцах явдалд өртөж хохирсон хохирогчид бодитой нөхөн олговор болон шаардлагатай эмчилгээ, нөхөн сэргээлтийг авах нөхцөл бүрдүүлэх.

Гэвч Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хороод, Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийг өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаагийн улмаас эрүү шүүлтээс ангид байх эрх хангагдахгүй байна.

Жишээлбэл, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох тухай хуулийн төслийг нэр бүхий гишүүд өргөн барьсны дагуу Монгол Улсын Их хурал 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийн 10, 45 дугаар зүйлийг хүчингүй болгосноор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг татан буулгаж, тус албаны харьяалан шалгаж байсан гэмт хэргийг Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэргийн харьяалалд шилжүүлжээ. Ингэснээр Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, тухайн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр урьд хүрсэн ололт амжилтаасаа ухарсан төдийгүй хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш байх зарчим алдагдахад хүрчээ.

Комисс нь байгуулагдсан цагаасаа хойш хүний халдашгүй дархан байх болон эрүү шүүлтээс ангид байх эрхийн зөрчлийг таслан зогсоох, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, цагдан хорих, эрүүлжүүлэх, баривчлах байр, хорих ангиудын нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, хуулийн байгууллагын ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр олон удаагийн хяналт шалгалт, сургалтыг тасралтгүй зохион байгуулж байна.

Комиссоос Улсын Их Хуралд өргөн барьсан Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 удаагийн илтгэлийн 12–т нь эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар илтгэж, тодорхой арга хэмжээ авахуулахаар санал, зөвлөмж хүргүүлсэн бөгөөд 2015 оны 14 дэх илтгэлд Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг татан буулгасан нь буруу болохыг тодорхой жишээгээр харуулж, мөн 2017 оны 16 дахь илтгэлд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар, үр дүнтэй мөрдөн шалгах байгууллагыг байгуулах, бүтэц, орон тоог нь шийдвэрлэх талаар санал хүргүүлж байсан боловч өнөөдрийг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Комиссоос өгсөн удаа дараагийн санал, зөвлөмж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын зөвлөмжүүдийг хэрэгжүүлж 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр” хуульчилсан нь Эрүүдэн

шүүхийн эсрэг конвенцтой нийцсэн гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 13. Эрүүгийн хуулийн холбогдох зүйлийг харьцуулан харуулав.

ХАРЬЦУУЛАН ХАРУУЛБАЛ	
Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл (2002 он)	Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл (2015 он)
“Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан санаатай үйлдэл...”	“Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол.. ”

Мөн шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулсан ч бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцын нэмэлт протокол¹³²-ын 3 дугаар зүйлд “Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага (цаашид “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага”) байгуулах, томилох,

¹³² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 57/199 дүгээр тогтоолоор баталж, 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

эсхүл хэвээр ажиллуулах үүрэг хүлээнэ” гэж заасан бөгөөд оролцогч улсуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүргийг хүлээлгэсэн байна.

Нэмэлт протоколд Монгол Улс 2014 оны 12 дугаар сарын 11–ний өдөр нэгдэн орсноос хойш 4 жилийн хугацаа өнгөрсөн ч эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг өнөөдрийг хүртэл байгуулаагүй байна. Мөн энэ талаар Комиссоос 2015 онд Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгож, төсөв, орон тоог шийдвэрлэх талаар санал, зөвлөмжийг удаа дараа өгч байсан болно.

Иймд Засгийн газар эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагыг байгуулж, Конвенцын нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ нэн даруй биелүүлэх хэрэгтэй байна.

4.2 Монгол Улс дахь эрүү шүүлтийн өнөөгийн нөхцөл байдал

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 6 дугаар сарын 30–ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” журмыг баталжээ.

Энэхүү журмаар Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт, Цагдаа, Авлигатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Тагнуулын ерөнхий газарт, Шүүх, Прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагчдын

үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Мөрдөн байцаах албаны Тусгай субьектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөх хэлтэст, Тагнуулын байгууллагын алба хаагчийн Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн алба шалгахаар тус тус харьяалал тогтоосон нь оновчтой шийдэл биш бөгөөд мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд харилцан нэгнээ шалгах нөхцөлийг бүрдүүлжээ.

Бүдүүвч 17. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгаж буй байдал



Ийнхүү хэрэг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд харилцан бие биенээ шалгаж байгаа нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бүрэн дүүрэн, бодитой шалгах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж, энэ төрлийн гэмт хэргийг хараат бус, бие даасан зарчмаар мөрдөн шалгах нөхцөлийг алдагдуулжээ. Улмаар эрүү шүүлттэй холбоотой гомдол, мэдээлэл, гэмт хэргийг субъектээр нь ангилан мөрдөн шалгахаар зохицуулсан нь энэ ажлын зорилго, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагааг цалгардуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял завшуулахгүй байх зарчим алдагдаж байгаа нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллээс харагдаж байна.

Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас ирүүлсэн мэдээлэл¹³³-д Прокурорын байгууллагад 2016 онд Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй нийт 54 гомдол, мэдээлэл ирсэн бөгөөд үүнээс 10 гомдол, мэдээлэл буюу 18.5 хувьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 33 гомдол, мэдээлэл буюу 61 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 11 буюу 20.4 хувьд нь прокурор гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Харин тус байгууллага 2017 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй нийт 82 гомдол, мэдээлэл хүлээн авсан байна. Үүнээс 6 гомдол, мэдээлэл буюу 7.3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол 61 гомдол, мэдээлэл буюу 74.3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэжээ.¹³⁴


¹³³ Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/793 дугаар албан бичиг.

¹³⁴ Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/793 дугаар албан бичиг.

Мөн 2018 онд Прокурорын байгууллагад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 69 гомдол, мэдээлэл ирснээс 22 гомдол, мэдээлэл буюу 31.9 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 46 буюу 66.7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн мөрдөгчийн 1 тогтоолыг хүчингүй болгосон байна.¹³⁵

Бүдүүвч 18. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл

Прокурорын байгууллага



¹³⁵ Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/793 дугаар албан бичиг.

Тохиолдол 40

“...аймгийн прокурорын газар нь тус аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байранд хоригдож байсан хоригдогч Ч.Ш, М.Э, нарыг цагдан хорих байрны албан хаагч Д.Б, Л.Э, Д.Р нар нь зодсон, мөн тус цагдан хорих байранд цагдан хоригдож байсан хоригдогч Ц.Н-ийг цагдан хорих байрны албан хаагч Г.С нь зодсон үйлдлийг прокурорын хяналтаар илрүүлж, аймгийн цагдаагийн газарт шилжүүлсэн боловч Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар цагдан хорих байрны албан хаагч Д.Б, Л.Э, Д.Р, Г.С нарыг тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 100.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан” байна.¹³⁶

Комисст УЕПГ-аас ирүүлсэн мэдээллээс 2019 он

Тохиолдол 41

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ... дугаар ангид ял эдэлж буй хоригдол Т.Б-г тус хорих ангийн албан хаагч Д нь хэл үгээр доромжилж, зодож биед нь гэмтэл учруулсан үйлдлийг ...аймгийн цагдаагийн газар шалгасан боловч тодорхойгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Комисст ирүүлсэн хоригдол Т.Б-ийн гомдлоос...

Харин Авлигатай тэмцэх газар 2017 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй нийт 16 гомдол, мэдээллийг шалгаснаас 3 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 12 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна.¹³⁷

¹³⁶ Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/793 дугаар албан бичиг.

¹³⁷ Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 06/1886 дугаар албан бичиг.

Мөн тус газраас 2017 онд 4 эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 1 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 2 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн бол 2018 онд эрүү шүүлт тулгах 42 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 1 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 34 эрүүгийн хэргийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 7 эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.¹³⁸

Бүдүүвч 19. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл Авлигатай тэмцэх газар




Мөн тус газар нь 2018 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 41 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд үүнээс 20 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол 21 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлжээ.¹³⁹

¹³⁸ Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 06/1886 дугаар албан бичиг.

¹³⁹ Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 06/1886 дугаар албан бичиг.


Бүдүүвч 20. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, Авлигатай тэмцэх газар



Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 2016 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 21 гомдол, мэдээлэл ирүүлснээс 2 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бөгөөд 19 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Харин 2017 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 13 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан бөгөөд бүх гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байх ба 2018 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 1 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан боловч эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн байна.

Бүдүүвч 21. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл



Тохиолдол 42

Комисст хандаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид хоригдож байсан яллагдагч М.Э, О.О, Э.М нар нь ирүүлсэн гомдолдоо “...дүүрэг дэх цагдаагийн ...дүгээр хэлтсийн мөрдөн байцаагч Б нь хэргээ хүлээ хэмээн дарамт шахалт үзүүлж, зодож, эрүү шүүлт тулгасанд гомдолтой байна” гэжээ.

Комиссоос уг гомдлыг шалгахад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй байсан тул харьяаллын дагуу Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн боловч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлсэн бөгөөд прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж хаасан.

Комисст ирүүлсэн М.Э нарын гомдлоос

Тохиолдол 43

Комисст хандаж ...аймгийн оршин суугч Х.Г нар нь ирүүлсэн гомдолдоо "...аймгийн Цагдаагийн газрын мөрдөгч Д.Х, Г.З, Г.С нар "...чи ямар хэрэг хийснээ мэдэж байгаа биз дээ гээд хэл үгээр доромжилж, дарамт шахалт үзүүлж байтал мөрдөгч Х орж ирээд наадах чинь хэргээ хүлээсэн үү, нөгөө 2 нь хэргээ хүлээчихээд байхад чи яагаад хүлээдэггүй юм гээд миний дух, мөр рүү цохиод хэл үгээр доромжилж, дарамталсан. Тэгээд мөрдөгч Х биднийг зам шалгалтаар авч явах үедээ машинд гавтай хонуулж, хөл нүцгэн гол гатлуулж, хамт явсан хүмүүсийг үүрч, гол гарга гээд 5 хүнийг нэг нэгээр нь үүрч гол гатлуулсан. Түүнээс болж миний хөл мөсөнд зүсэгдсэн, гавлуулснаас болж баруун гар хавдсан, дух руу цохисны улмаас дух хавдсан байсан" гэжээ.

Комисс уг гомдлыг шалгахад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал тогтоогдсон тул шалгуулахаар Цагдаагийн ерөнхий газарт шаардлага хүргүүлсэн боловч Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн албан бичиг¹⁴⁰ "... Хэрэг бүртгэлтийн ...дугаартай хэргүүдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасны дагуу өөр мөрдөгчид шилжүүлж, прокурорт мэдэгдэв. ...албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг чанд сахих, удирдлагаас тавих хяналтыг сайжруулах үүргийг ...аймгийн цагдаагийн газарт хүргүүлээ" гэх хариу ирүүлжээ.

Гэтэл Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба 2002 оноос 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллахдаа гэмт хэргийн талаарх 6,109 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж прокурорт

¹⁴⁰ Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн З/7156 дугаар албан бичиг.

шилжүүлсэн 3,344, харьяаллын дагуу шилжүүлсэн 1,256, эрүүгийн хэрэг үүсгэсэн 2,109, эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт 2,972 гомдол, мэдээлэл байна. Үүнээс шүүхэд шилжүүлсэн 1,370 хэрэгсэхгүй болгосон 988, түдгэлзүүлэх 138, харьяаллын дагуу шилжүүлэх санал гаргаж прокурорт шилжүүлсэн 417, өөр хэрэгт нэгтгэн шалгасан 59 хэрэгт тус тус мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ. Мөн гэмт хэргийн улмаас бусдад учирсан нийт 3,541,798.4 төгрөгийн хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, 6,171,861.0 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж байжээ.¹⁴¹

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс эрүү шүүлт тулгах гэмт хэргийг 2017, 2018 онд хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг авахад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017, 2018 онд Эрүүгийн хуулийн (2002 он) 251 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн (2015 он) 21.12 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлээгүй байна.¹⁴²

Мөн Улсын Дээд шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд “Шүүх эрүүгийн хэрэг, иргэний болон захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн, дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтгүй, Үндсэн хуульд харшлаагүй, үндэсний

¹⁴¹ Улсын Ерөнхий Прокурорын туслах прокурор МБАХТХ-ийн дарга Е.Сагсайн илтгэлээс, Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл 145 дугаар хуудас.

¹⁴² Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 04/259 дугаар албан бичиг.

эрх зүйн харилцааны оролцогч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ” гэж заажээ.

Үүний дагуу Улсын Дээд Шүүхийн 2017 оны эрүүгийн танхимын хуралдааны 350 тогтоолд дүн шинжилгээ хийхэд 14 тогтоолд олон улсын гэрээ, конвенцыг хэрэглэж шийдвэр гаргасан байх бөгөөд 1 тогтоолд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг хэрэглэж шийдвэрлэсэн байна. Мөн шүүхийн 2018 оны хуралдааны 517 тогтоолын 26-д нь олон улсын гэрээ, конвенцыг хэрэглэсэн боловч Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг хэрэглээгүй байна.

Тохиолдол 44

Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн ханалтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 84 дугаартай тогтоолын тодорхойлох хэсэгт “...Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ”, мөн Олон улсын гэрээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж тус тус заасан байхад хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хууль тогтоомжийн эрэмбэ, түүнийг хэрэглэх үндсэн зарчмын дагуу дотоодын хууль тогтоомж нь олон улсын гэрээний заалттай зөрчилдөж байгаа эсэхэд дүгнэлт өгөөгүй байна.

1984 оны “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...эрүүдэн шүүх гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүний буюу гурав дахь этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухай хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдийг хэлнэ...” гэж эрүүдэн шүүлт явуулах

субъектэд хэн хамаарч болох талаар өргөн агуулгаар тусгажээ. Уг зүйлийн 2 дахь хэсэгт “олон улсын болон бусад дотоодын хуулинд уг ойлголтыг илүү өргөн утгаар хэрэглэдэг бол энэ зүйл нь тэдгээрт хохирол учруулахгүй гэж тодорхойлсон бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд уг гэмт хэргийн субъект нь зөвхөн “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч” гэж дээрх конвенцын заалтыг илтэд явцууруулан зохицуулсан тул олон улсын гэрээ, конвенцын заалт, түүний ойлголтыг энэхүү хэрэгт баримтлах үндэслэл болж байна.”

...Хойшлуулшгүй ажиллагааны үед Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлийн 172.3 дахь хэсэгт “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагын ажилтан эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхийн тулд дараах хойшлуулшгүй арга хэмжээ явуулж болно” гэж заасан байгааг үндэслэн Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн субъектын шалгуурыг тогтоохоос гадна “төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалга, ил, далд зөвшөөрлөөр гэмт хэрэг үйлдсэн гэх этгээдийн бие мэхбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоосон этгээд”-ийг хамруулан ойлгож, Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн “мэдүүлэг өгөхийг албадсан” гэдгийг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын “эрүүдэн шүүх” тодорхойлолтын дагуу “гэмт хэрэгт холбогдсон этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, түүнчлэн аливаа байдлаар алагчлах зорилгоор” гэж ойлгоно.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлийн 172.4 дэх хэсэгт заасан субьектээр хязгаарлалгүйгээр тухайн харилцааг зохицуулсан олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн тайлбарлан хэрэглэх нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хүлээлсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх хууль зүйн үндэслэл болно гэж дүгнэлээ.¹⁴³

¹⁴³ Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 2/1573 дугаар албан бичгээр ирүүлсэн Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 84 дугаар тогтоол

Ийнхүү эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байхгүйн улмаас эрүү шүүлттэй тэмцэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.

Нөгөөтээгүүр энэ нь прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой, зохион байгуулалттай, үр дүнтэй арга хэмжээ авдаггүй, ажилтан, албан хаагчдын эрүү шүүлтийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажил хангалтгүй байгаатай холбоотой юм.

Комисст 2017 онд ирүүлсэн хууль сахиулах байгууллагын албан хаагчидтай холбоотой гомдол, мэдээллийг субъектээр нь ангилбал, шүүх, шүүгчийн үйл ажиллагааны талаар 53, прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаар 54, цагдаагийн байгууллагын алба хаагчдын үйл ажиллагааны талаар 121, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар 44 гомдол, мэдээлэл ирүүлснээс эрүү шүүлтээс ангид байх эрх зөрчигдсөн тухай 25 гомдол иржээ.

Мөн 2018 онд хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 119 гомдол ирснээс шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой 26, прокурорын үйл ажиллагаатай холбоотой 40, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай холбоотой 20 гомдол, мэдээлэл байна. Харин эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчсөн тухай 35 гомдол ирүүлжээ.

Шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагаа гэдэгт “...эрүүдэн шүүгдэж, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж, сэтгэл санаа, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамруулж үзнэ”, “эрүүдэн шүүгдсэн гэдэгт Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу

хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлийн 1-д заасан хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн гэмт хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийг бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдэл”-ийг ойлгоно¹⁴⁴ гэж Улсын Дээд шүүх тайлбарлажээ.

Мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, прокурор, шүүгч нар гэмт хэрэг илрүүлэх, мэдээлэл олж авах, хэрэг хүлээлгэх зорилгоор гэмт хэрэгт холбогдсон этгээдийг эрүүдэн шүүх, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах, ар гэрийнхэнтэй нь зүй бус харьцах, дарамт шахалт үзүүлэх явдал байсаар байна.


Тохиолдол 45

Комисст хандаж яллагдагч М.Э нь ирүүлсэн гомдолдоо “Мөрдөн байцаагч Б нь хилс хэрэг хүлээлгэх зорилгоор миний элэг бөөр болон шанаа руу хэд хэдэн удаа цохиж, залгуурны утсаар ороолгосон бөгөөд шал долоолгож, толгой дээр гишгэж, баруун гарын долоовор хурууг бахиар хавчиж байгаад төмрөөр цохисон юм. Мөн өмгөөлөгчтэй байцаалт өгмөөр байна гэж хэлэхэд “Чи өмгөөлөгчөөрөө харуулж байгаад хэрэг хийхгүй яасан юм” гэж доромжилсонд гомдолтой байна” гэжээ.

Комисст ирүүлсэн М.Э-ийн гомдлоос...

¹⁴⁴ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоол

Бүдүүвч 22. Хууль сахиулах байгууллагын алба хаагчтай холбоотой гомдол



Дээрхээс үзэхэд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх тодорхой, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, хуулийн байгууллагуудын алба хаагчдад эрүү шүүлтийн талаарх олон улсын гэрээ, конвенцыг хууль, шүүхийн практикт хэрэглэх дадал олгох шаардлагатай байна.

4.3 Эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Хууль бусаар баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй”, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн

сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй.” гэж тус тус заасан байна.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын 3.3-т “Төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна” гэж заажээ.

Олон улсын эрх зүйн зохицуулалтаар эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг шударгаар, хангалттай нөхөн төлөх үүргийг Засгийн газар хүлээдэг. Өөрөөр хэлбэл, эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” эрхийг баталгаажуулсан боловч эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх талаар тусгайлсан эрх зүйн зохицуулалтгүй байна.¹⁴⁵

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах талаар хуульчилсан ч шүүх бүрэн ашиглахгүй байна.

¹⁴⁵ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, 20 дугаар хуудас.

Тиймээс эдийн бус хохирлыг үнэлэх, тооцох аргачлал, эрх зүйн зохицуулалт өнөөдрийг хүртэл дутмаг, мөн олон улсын гэрээ, конвенцыг бүрэн ойлгож хэрэглэхгүй байгаагаас эрүү шүүлтийн хохирогч өөрт учирсан хохирлоо бодитой нөхөн төлүүлэх боломжгүй байна.

Тохиолдол 46

Комисст хандаж иргэн М.Б нь ирүүлсэн гомдолдоо: “Миний бие ...шүүхийн шийтгэх тогтоолоор 15 жилийн хорих ялаар шийтгүүлсэн бөгөөд ялаа эдэлж байх хугацаанд 2008 онд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт орж, шүүхээс надад оногдуулсан хорих ялын хэмжээг 10 жил хүртлэх хугацаагаар багасгаж хуулийн тэгшитгэлд хамруулах боломжтой болсон. Гэтэл дээрх Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу намайг 2016 он хүртэл хуулийн тэгшитгэлд хамруулахгүй хохироосон юм. Өөрөөр хэлбэл 10 жил хорих ял эдлээд миний хорих ялын хугацаа дуусах ёстой атал 13 жил 7 сар 4 хоногийн хорих ялыг биечлэн эдэлсний дараа Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 541 дүгээр магадлалаар хуулийн тэгшитгэлд хамруулж, хорих ангиас сулласан юм. Ингээд миний бие 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу хуулийн тэгшитгэлд хамрагдаж, 10 жилийн хорих ялаа эдлээд хорих ангиас суллагдах байтал миний эрх зүйн байдлыг дордуулж, халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчиж, 3 жил 7 сар 4 хоногийн хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлж бие махбод, сэтгэл санааны хувьд ноцтой хохироосонд гомдолтой байгаа тул төрөөс хохирлыг барагдуулахад намайг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж өгнө үү. Сэтгэл санаа, бие махбодын хохиролд 100,000,000 төгрөгийг нэхэмжилж байна” гэжээ.

Комисс иргэн М.Б-г төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд түүнийг хууль бусаар илүү хугацаагаар буюу 3 жил

7 сар 4 хоног ял эдэлсний улмаас учирсан хохиролд нийт 351,712,000 төгрөгийн хохирлыг төрөөс нэхэмжилсэн боловч Шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ нийт нэхэмжилсэн үнийн дүнгээс 16,512,000 төгрөгийг хангаж шийдвэрлэжээ. Үүнээс сэтгэл санааны санааны хохиролд 8,256,000 төгрөгийг нөхөн төлөхөөр шийдвэрлэсэн байна.

Тохиолдол 47

Талийгаач А.Б-нь бусдыг санаатайгаар галдан шатааж, онц хэрцгий аргаар амь насыг нь хороосон гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдож, 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн цагдан хоригдож байх хугацаандаа хатги өвчнөөр өвчилж хүндэрсэн ба түүнийг 1995 оны 2 дугаар сарын 25-ны өдөр аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасагт шилжүүлж эмчлүүлсэн гэх боловч 1995 оны 3 дугаар сарын 16-ны өдөр нас барсан байна. Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний 1995 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 5 дугаартай актаар “А.Б-ын нүүрний дээд хэсэгт идээт үрэвсэл үүсэж улмаар цусан үржлээр хүндрэн уушгины буглаанууд үүсч хордлого амьсгалын дутагдлаар” нас барсан болохыг тогтоожээ.

Түүнийг нас барснаас хойш 21 жилийн дараа Дорнод аймгийн Прокурорын газраас 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 5/33 дугаар тогтоолоор түүнд холбогдох эрүүгийн хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

...дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 102/ШШ2019/00552 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийг “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 “зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх,

цуглуулах үүрэгтэй” гэж зааснаар сэтгэл санааны хохирол 500,000,000 төгрөг гаргуулах шаардлагад холбогдох нотлох баримтаа гаргаж өгөөгүй, оршуулгын тэтгэмжийг тухайн үед авах эрх нь нээлттэй байсан” гэх үндэслэлээр А.Б-ын цагдан хоригдсон хоногт авах цалин 210,000 төгрөг, оршуулгын зардалд 300,000 төгрөг, нийт 710,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгож, үлдсэн 503,604,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож сэтгэл санааны хохирлыг огт барагдуулалгүй шийдсэн байдаг.

4.4 Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцын 10 дугаар зүйлд “Оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, байцаах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг бүрэн тусгана” гэж заажээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Засгийн газарт “Олон улсын эрх зүйн баримт бичиг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ Хороо эдгээр баримт бичгийн талаарх шүүгчдийн мэдлэг хязгаарлагдмал талаарх төлөөлөгчдийн мэдэгдэлд санаа зовинож байна. Энэ талаар Хүний эрхийн зөвлөлийн эрүү шүүлтийн асуудал хариуцсан тусгай илтгэгч эрүүдэн шүүхийг хориглосон олон улсын стандартуудын талаарх прокурор, өмгөөлөгч болон шүүгч нарын суурь мэдлэг дутмаг гэж дүгнэсэн байдаг. Ялангуяа олон улсын гэрээ конвенцыг хэрэглэж үйлчлүүлэгчээ өмгөөлбөл шүүгч илүү хүнд ял өгдөг гэсэн мэдээллийг хороо авсан хэмээн дурдаад Конвенц

буюу ялангуяа эрүүдэн шүүхийг хориглосон заалтын талаар шүүгч, прокурор, хуульч, өмгөөлөгч болон холбогдох бусад албан хаагчдын сургалтад заавал хамруулах шаардлагатай байна. Сургалт зохион байгуулахдаа оролцогч улс олон улсын дэмжлэг авч болно. Төрийн албан хаагч баривчилгаа, цагдан хорих асуудал хариуцдаг эрүүл мэндийн ажилтан болон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдад Станбулын протокол гэж нэрлэгдсэн Эрүүдэн шүүхийн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэсэн үйлдлийг мөрдөн шалгаж, баримтжуулах гарын авлагаар мэргэшүүлэх сургалтад хамруулах хэрэгтэй байна¹⁴⁶ гэж зөвлөжээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга зам нь эрүү шүүлтийг хориглох болон мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх тухай олон улсын гэрээ, баримт бичгийн талаарх хуулийн байгууллагын ажилтны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хүндэтгэх, зөрчихгүй байх хандлагыг төлөвшүүлэх явдал юм. Энэ үйл ажиллагаа нь хуульчдын давтан сургалтаар биеллээ олох учиртай. Тиймээс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 10 дугаар зүйлд оролцогч улсад тусгайлан үүрэг болгосон байдаг.¹⁴⁷

Комисс 2015 онд Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлдээ Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг байгууллагуудын бүтэн жилийн сургалтын

¹⁴⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2010 оны 11 дүгээр сарын 1–19-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайланг хэлэлцээд өгсөн зөвлөмжийн 14 дэх хэсэг.

¹⁴⁷ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, 28 дугаар хуудас.

хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд дээрх байгууллагуудын ажилтан, албан хаагчдад зориулсан давтан болон мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт багтаагүй талаар дурдаж байв.


Иймээс Комисс Улсын Их Хуралд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу шүүх, прокурор, хуулийн байгууллагын давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх сургалтыг тогтмолжуулж, хуульчдын давтан сургалтын багц цагт хамруулах, сургалтын цогц хөтөлбөртэй болгох”¹⁴⁸ тухай санал хүргүүлж, Хууль зүйн байнгын хороо 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 29 дүгээр тогтоолоороо “Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу шүүх, прокурор, хуулийн байгууллагын давтан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх болон эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх сургалтыг тогтмолжуулж, хуульчдын давтан сургалтын багц цагт хамруулах, сургалтын цогц хөтөлбөр батлуулах”-ыг Засгийн газарт чиглэл болгосон боловч өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээгүй байна.

Комиссоос Цагдаагийн байгууллагын хүсэлтээр “Эрүү шүүлтээс ангид байх эрх”-ийн талаарх сургалтыг 2017 онд 7 удаагийн 7 цагийн сургалтыг 364 албан хаагчид, 2018 онд 3 удаагийн 8 цагийн сургалтыг 116 албан хаагчид, мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүсэлтээр 2017 онд 16 удаагийн 30 цагийн сургалтыг 442 албан хаагчид, 2018 онд 7 удаагийн 14 цагийн сургалтыг 167 албан хаагчид тус тус явуулжээ.

¹⁴⁸ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, 186 дугаар хуудас.

Прокурорын байгууллагын хувьд 2017 онд Хөвсгөл аймгийн Прокурорын газраас “Эрүү шүүлтээс ангид байх эрх”-ийн хүрээнд 1 цагийн сургалтыг авсан бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Авлигатай тэмцэх газраас 2017, 2018 онуудад огт сургалт аваагүй байна. Үүнийг тоон үзүүлэлтээр харуулбал;

Бүдүүвч 23. Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд сургалт авсан байдал



Үүнээс үзэхэд хууль сахиулах байгууллагууд нь алба хаагчдынхаа эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон бусад олон улсын гэрээг практикт хэрэглэх, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг хангалтгүй зохион байгуулж байгаа нь харагдаж байна.



БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

*“Хүн бүр хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах,
цалин хөлс авах, амрах ...эрхтэй.”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн
4 дэх заалт)

*“Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн
шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах
эрхтэй.”*

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн¹⁴⁹ 3 дугаар зүйлийн 3.1.8-д “цэргийн байгууллага” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн цэргийн байгууллагын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ”, мөн зүйлийн 8.3 дахь хэсэгт “Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын бүтэц, эрх, чиг үүргийг хуулиар зохицуулна.” гэж тус тус хуульчилжээ.

Онцгой байдлын байгууллага нь хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих¹⁵⁰ чиг

¹⁴⁹ Улсын Их Хурлаас Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийг 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр шинэчлэн баталсан.

¹⁵⁰ Гамшгаас хамгаалах тухай хууль. /Шинэчилсэн найруулга/ 2017 он.

үүргийг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд тус байгууллагын төв, орон нутагт ажиллаж буй ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хууль¹⁵¹, Төрийн албаны тухай¹⁵², Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай¹⁵³, Хөдөлмөрийн тухай¹⁵⁴ хууль болон бусад хууль тогтоомжоор тус тус зохицуулж байна.

Комисс нь Онцгой байдлын байгууллагад ажиллаж буй албан хаагчдын Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, мэргэшэх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалт, судалгааны ажлыг 2018 онд зохион байгуулав.

Энэхүү хяналт шалгалт, судалгаанд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа аймгууд дахь Онцгой байдлын газрууд болон Үндэсний аврах бригадыг хамруулсан бөгөөд нөхцөл байдалтай газар дээр нь танилцлаа.

Хяналт шалгалтын санал асуулгад түүврийн аргаар нийт 840 алба хаагчийг хамруулахад 758 алба хаагч буюу 90.2 хувь нь үр дүнгийн гэрээгээр, 74 алба хаагч буюу 8.8 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байна.

5.1 Хөдөлмөрийн аятай, таатай нөхцөлөөр хангагдах эрх

Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнууд хөдөлмөрийн

¹⁵¹ Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

¹⁵² Төрийн албаны тухай хууль. /Шинэчилсэн найруулга/ 2017 он.

¹⁵³ Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. /Шинэчилсэн найруулга/ 2016 он.

¹⁵⁴ Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он.

аятай таатай, аюулгүй, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын байр, орчин нөхцөлд ажиллах ёстой.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын¹⁵⁵ 23 дугаар зүйлийн 1–д “Хүн бүр хөдөлмөрлөх, ...хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ...эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын¹⁵⁶ 7 дугаар зүйлийн (b)–д “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “Монгол Улсын иргэн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах ...эрхтэй.”; Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч дараахь нийтлэг баталгаагаар хангагдана”, 61.1.2–д “албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.”; Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1–т “хөдөлмөр эрхэлж


¹⁵⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/АIII/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10–ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан.

¹⁵⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16–ны өдрийн 2200 (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3–ны өдөр хүчин төгөлдөр болсон.

байгаа иргэн, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах” гэж ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийг тус тус хуульчилжээ.

Дээрх хууль тогтоомжид заасан эрхийн хэрэгжилтийн талаарх санал асуулгын “Таны ажлын байрны нөхцөл ямар вэ” гэсэн асуултад 442 алба хаагч буюу 53.3 хувь нь сайн, 332 алба хаагч буюу 40 хувь нь дунд, 49 алба хаагч буюу 5.9 хувь нь муу гэж хариулсан байна.

Бүдүүвч 24. Таны ажлын байрны нөхцөл ямар вэ?



Онцгой байдлын байгууллагын хэмжээнд нийт 108 албаны байр, ажилчдын 214 орон сууц, агуулах, тавиулан, харуулын байр зэрэг бусад 277 барилга ашиглагдаж байна.¹⁵⁷

¹⁵⁷ Комисст Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/175 дугаар албан бичиг.

Хүснэгт 14. Онцгой байдлын алба, хэлтэс, ангийн үйл ажиллагаа явуулж буй байр, ажилчдын орон сууцны талаарх мэдээлэл

Д/д	Аймаг, нийслэл	Албаны байрны тоо (контор)	Орон сууц	Бусад барилга (Агуулах, тавиулан, харуулын байр)
1	Нийслэл	16	84	52
2	Архангай	3	8	4
3	Баян-Өлгий	5	–	31
4	Баянхонгор	6	–	28
5	Булган	2	–	–
6	Говь-Алтай	1	–	7
7	Говьсүмбэр	2	–	9
8	Дархан-Уул	7	18	15
9	Дорноговь	5	20	–
10	Дорнод	4	–	6
11	Дундговь	3	6	9
12	Завхан	4	9	12
13	Орхон	4	–	4
14	Өвөрхангай	4	2	9
15	Өмнөговь	7	5	15
16	Сүхбаатар	3	8	4
17	Сэлэнгэ	8	24	8
18	Төв	8	8	20
19	Увс	6	–	23
20	Ховд	4	13	2
21	Хөвсгөл	3	–	8
22	Хэнтий	3	9	11
Нийт		108	214	277

Онцгой байдлын байгууллагын зарим газар, хэлтэс нь өнөөдрийг хүртэл зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулж байх бөгөөд тус байрууд нь агааржуулалт, гэрэлтүүлэг хангалтгүй, албан өрөө, тасалгааны орчин нөхцөл нь стандартын¹⁵⁸ шаардлага хангаагүй, ашиглалтын хугацаа

¹⁵⁸ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2000.

дууссан, хуучирч муудсан, хана тааз нь мөөгөнцөртсөн, ан цав үүсэж нурах аюултай болох нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байна.

Тохиолдол 48

Манай байгууллагын байр 1970 онд баригдаж, ашиглалтад орсон бөгөөд 2013 онд урсгал засвар хийж өргөтгөсөн. Гэвч байрны ашиглалтын хугацаа дууссан, дээврээсээ байнга дусаал гоождог, их хүйтэн учир албан хаагчид эрүүл мэндийн хувьд хохирох эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна...

Судалгаанд хамрагдсан алба хаагчтай хийсэн ярилцлагаас

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээллийг улсын нууцад хамааруулна” гэж заасан байна. Мөн Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг баталсан бөгөөд уг жагсаалтад Онцгой байдлын салбарын объектийг нууцлахаар журамласан байна. Иймд Онцгой байдлын газар, хэлтэс, ангиудын байршил, объектын хүчин чадал, чанар, ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулах боломжгүй байна.

5.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал

Онцгой байдлын албаны хэмжээнд ашиглагдаж байгаа автомашин, техникийн 29.3 хувь нь шуурхай албаны автомашин, 37.3 хувь нь гал унтраах үндсэн болон туслах

албаны, 7.4 хувь нь аврах албаны, 39.2 хувь нь тусгай зориулалтын, 15.6 хувь нь хүн, ачаа тээврийн зориулалтаар ашиглагдаж байна.

Дээрх автомашин, техникийн 12 хувь нь 20 хүртэл жил, 17 хувь нь 30 хүртэл жил, 13 хувь нь 30-аас дээш жил ашиглагдаж байх бөгөөд нийт автомашин, техникийн 42 хувь нь 20 жилээс дээш ашиглагдсан байгаа нь онцгой албаны үүргийг бүрэн гүйцэтгэх боломжгүйг харуулж байна.

“Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага MNS:6412-2013 стандарт”-ын дагуу гал унтраах тусгай зориулалтын 9 нэр төрлийн 480 автомашин байхаас 6 нэр төрлийн 225 автомашиныг ашиглаж байгаа бөгөөд гал унтраах зориулалтын автомашины хангалт улсын хэмжээнд 37.5 хувьтай байна.

Онцгой байдлын байгууллагад албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд үндсэн албаны 43, ус тээвэрлэгч 85, автомеханик шат 36, хорт хий утаанаас хамгаалах зориулалтын автомашин 7, гэрэл холбооны автомашин 47, ой, хээрийн түймэр унтраах зориулалтын автомашин 36, шуурхай удирдлагын байр болон ухуулга сурталчилгааны зориулалттай автомашин 51, шуурхай үйлчилгээний зориулалттай 7, нийт 312 нэгж машин, техник нэн шаардлагатай байна.

Онцгой байдлын байгууллагад 2019 оны эхний гурван сарын байдлаар аврах багаж хэрэгслийн хангалт 43.5 хувь, гал унтраах тоног төхөөрөмжийн хангалт 50 хувь, тусгай зориулалтын хувцас, хэрэгслийн хангалт 35 хувьтай байна.

Тус байгууллагын хэмжээнд стандартад¹⁵⁹ заасны дагуу нийт 2,657 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж

¹⁵⁹ “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6412-2013.

шаардлагатай боловч одоогоор нийт 713 ширхэг төхөөрөмжийг хэрэглэж байна. Эдгээрийн 49.7 хувийг нь 2004–2009 оноос, 50.3 хувийг нь 2010–2016 оноос хэрэглэж эхэлсэн ба 35.1 хувь нь ашиглалтын шаардлага хангахгүй болжээ .

Мөн дээрх стандартад гал түймэр унтраах, аврах ангид суурин цэнэглэгч 1, зөөврийн цэнэглэгч 1 буюу 67 ангид нийт 134 ширхэг байхаар заасан байдаг. Гэвч суурин цэнэглэгч 13, зөөврийн цэнэглэгч 55, нийт 68 ширхэг цэнэглэгч ашиглагдаж байна. Үүнээс 55 ширхэг нь 180–220 бар¹⁶⁰ хүртэл цэнэглээд хүчин чадлаа даахгүй, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь албаны бэлтгэл, бэлэн байдал алдагдахад хүргэж байгаа тул гал түймэр унтраах, аврах ангийг нэн шаардлагатай 111 ширхэг суурин цэнэглэгч төхөөрөмжөөр хангах нь зүйтэй байна.

Гал түймэр унтраах, аврах ангийн хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох галын дуулга малгай, хүрэм, өмд, галын гутал, галын бээлий, аврах бүс, гэрэлтүүлэх хэрэгсэл, бага оврын сүх, гал сөнөөгчийн карбин, хоолойн дэгээ, хэт дулаанаас хамгаалах мөнгөлөг хувцасны хангалт 22.6 хувь, аврах ажиллагааны хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох аврах ажиллагааны дуулга малгай, нүдний шил, бээлий, өвдөг, тохойн хамгаалалт аврах ажлын бүс, аврах ажиллагааны гутал, хошуувч малгайн гэрэл зэргийн хангалт 36.5 хувь, цацраг, химийн хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох А, В, С зэрэглэлийн хувцас, тусгаарлах баг, шүүгч баг зэргийн хангалт 4.6 хувь, ой хээрийн түймэр унтраах ажиллагааны хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох биеийн дулаан хадгалах, галын цоонолтоос хамгаалах зориулалттай хувцас, нүдний шил, бээлий, гутал, бүс, жижиг сүх, эвхдэг хүрз зэргийн хангалт 28.2 хувьтай байна.

¹⁶⁰ Физик болон техникт ихэвчлэн хэрэглэх даралтын нэгж юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 18 ДАХЬ ИЛТГЭЛ

Мөн эрэн хайх, аврах нэгжийн гүний усны шумбагчийн хувцасны хангалт 29.3 хувь, усны гүний хүндрүүлэгчийн хангалт 19.3 хувь, өндөр барилгаас хүн аврах хоолойн хангалт 3.5 хувь, химийн бодис төрөл тодорхойлох багаж, драйгер хангалт 20 хувь, химийн С зэрэглэлийн хувцасны хангалт 28 хувь, цацраг, химийн бодисоос хамгаалах иж бүрдэл хувцасны хангалт 3.7 хувьтай байна.

Хүснэгт 15. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хангалт

№	Анги	Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	Хангалтын хувь
1	Гал түймэр унтраах ажиллагаа	Галын дуулга малгай	22.6
		Хүрэм	
		Өмд	
		Галын гутал	
		Галын бээлий	
		Аврах бүс	
		Гэрэлтүүлэх хэрэгсэл	
		Бага оврын сүх	
		Гал сөнөөгчийн карбин	
		Хоолойн дэгээ	
Хэт дулаанаас хамгаалах мөнгөлөг хувцас			
2	Аврах ажиллагаа	Аврах ажиллагааны дуулга малгай	36.5
		Нүдний шил	
		Бээлий	
		Өвдөг, тохойн хамгаалалт	
		Аврах ажлын бүс	
		Аврах ажиллагааны гутал	
3	Цацраг, химийн аврах ажиллагаа	Хошуувч малгайн гэрэл	4.6
		А зэрэглэлийн хувцас	
		В зэрэглэлийн хувцас	
		С зэрэглэлийн хувцас	
		Тусгаарлах баг	
Шүүгч баг			

4	Ой хээрийн түймэр унтраах ажиллагаа	Биеийн дулаан хадгалах, галын цоонолтоос хамгаалах зориулалттай хувцас	28.2	
		Нүдний шил		
		Бээлий		
		Гутал		
		Бүс		
		Жижиг сүх		
5	Эрэн хайх, аврах ажиллагаа	Эвхдэг хүрээ	29.3	
		Гүний усны шумбагчийн хувцас		19.3
		Усны гүний хүндрүүлэгч		3.5
		Өндөр барилгаас хүн аврах хоолой		20
		Химийн бодис төрөл тодорхойлох багаж, драйгер		28
		Химийн С зэрэглэлийн хувцас		3.7
	Цацраг, химийн бодисоос хамгаалах иж бүрдэл хувцас			

Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн нөхөн хангалт нийтдээ 30 хувьтай байгаа бөгөөд богино долгионы радио станц 40 хувь, богино долгионы үүргэвчин радио станц 29.5 хувь, хэт богино долгионы радио станц 38 хувь, гар радио станц 32 хувь, дахин дамжуулах станц 25.2 хувь, иридиум сансрын холбоо 16 хувь, байршил тодорхойлогч 6 хувь, зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхаг 11 хувьтай байна.

Тохиолдол 49

Хөдөлмөр хамгааллын хувцасны хувьд хэмжээ таардаггүйгээс гадна зарим нэг хэрэглэгдэхүүн нь ховор байдаг. Хөдөлмөр хамгааллын хувцас 4 ширхэг байдаг тул гал сөнөөгч нар тухайн хувцсаа ээлжлэн өмсөж үүрэг гүйцэтгэж байгаа нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна. Ялангуяа даралтын хоолойг дамжуулан хэрэглэснээр ээлжинд гардаг алба

*хаагч нар нэг нэгэндээ амьсгалын замын өвчнүүд халдаах
магадлал ихтэй юм...*

Судалгаанд хамрагдсан алба хаагчийн ярилцлагаас

Онцгой байдлын ерөнхий газраас 2017 онд “Онцгой байдлын байгууллагын Аврах, гал унтраах техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах дунд хугацааны дэд хөтөлбөр 2018–2030” төсөл боловсруулж, Монгол Улсын Шадар сайдад танилцуулсан байна. Уг хөтөлбөрийн төсөл, судалгаагаар онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалтыг дунджаар 90 хувьд хүргэх, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд нийт 313.5 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарсан бөгөөд үүнээс агаараас эрэн хайх, аврах, ой хээрийн болон өндөр барилга, байгууламжид гарсан гал түймрийг унтраах хэрэгсэлд 113.4 тэрбум, гал унтраах тусгай зориулалтын автомашинд 78.1 тэрбум, аврах зориулалтын автомашинд 47.6 тэрбум, аврах ажлын зориулалттай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд 26.7 тэрбум, 7 нэр төрлийн хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн иж бүрдэлд 7.6 тэрбум төгрөг зарцуулах тооцооллыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Тохиолдол 50

“Эко Алтан Заамар” компанийн уурхайд 2019 оны 3 дугаар сард гарсан ослын газарт уурхайчдыг аврах ажиллагааны гамшгийн нөхцөл байдал, орчин маш хүнд байсан. Бид гамшгийн нөхцөл байдалтай танилцаад 8 усчин аврагчийг нэмж дуудсан боловч аврагч тус бүрт аврах ажиллагааны усны иж бүрэн хувцас байгаагүй. Бидэнд усны иж бүрэн хувцас 4 ширхэг л байсан бөгөөд мөстэй орчинд зүсэгдэж,

хөлдөж байсан. Мөн шумбалт хийх үед аврагчдын амьсгалын аппарат шавартай усанд бөглөрөх зэрэг хүндрэл гарч байсан боловч үүргээ зохих ёсоор биелүүлсэн...

Онцгой байдлын ерөнхий газрын удирдах
албан тушаалтантай хийсэн ярилцлагаас, 2019 он

Алба хаагчдын ажиллах орчин нөхцөл, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийн хэрэгжилтийг сайжруулах, тэдний амь насыг болзошгүй эрсдлээс хамгаалах үүднээс аврах ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангахад шаардагдах төсвийг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна.

5.3 Эрүүл мэндээ хамгаалуулах эрх


Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалтад “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.”, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д “Цэргийн алба хаагч эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна, эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.” гэж тус тус заажээ.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний

даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.” гэж заасны дагуу жил бүрийн эхэнд онцгой байдлын байгууллагын нийт алба хаагчдыг гэнэтийн ослын болон мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд нэгдсэн журмаар хамруулдаг байна.

“Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт үнэ төлбөргүй хамруулдаг уу” гэсэн асуултад нийт 840 албан хаагч оролцоноос 512 буюу 61 хувь нь тийм, 294 буюу 35 хувь нь үгүй гэж хариулжээ.

Бүдүүвч 25. Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт үнэ төлбөргүй хамруулдаг уу?



Онцгой байдлын ерөнхий газрын Давтан сургалт, сэргээн заслын төвийн эмч нарын ажлын хэсэг 2016 онд Зүүн бүсийн Онцгой байдлын газрын 321, 2017 онд Хойд бүсийн Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын 807, Объект-3 салбарт 37, Нийслэлийн Онцгой байдлын газрын 660, Аврах тусгай ангийн 225 алба хаагчдад тус тус урьдчилан сэргийлэх

үзлэг, оношилгоо хийжээ. Мөн 2018 онд Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэнгийн 152 алба хаагчдыг “Улаанбаатар Сонгдо” эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.

Тус газрын Давтан сургалт сэргээн заслын төвийн эмч нарын ажлын хэсэг Баруун бүсийн¹⁶¹ Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Завхан, Увс аймгийн Онцгой байдлын газрын 476 алба хаагчид, Өмнөд бүсийн¹⁶² Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын 223 алба хаагчдад тус тус эрүүл мэндийн үзлэг, оношилгоог хийжээ. Үүнээс үзэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд орон нутгийн Онцгой байдлын байгууллагын 2,789 алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, оношилгоонд хамруулжээ.

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2010 онд 3, 2012 онд 4, 2013 онд 1, 2014 онд 7, 2017 онд 1 алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан бөгөөд холбогдох хуульд заасны дагуу ар гэрт нь 60 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгосон байна.

Мөн 2014 онд 11, 2015 онд 28, 2016 онд 50, 2017 онд 38, 2018 онд 16 алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж, бэртсэний улмаас эрүүл мэндээрээ хохирсон байна.

¹⁶¹ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/294 дугаар тушаал.

¹⁶² Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/343 дугаар тушаал.

Хүснэгт 16. Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан алба хаагчдын судалгаа

№	Овог, нэр	Цол	Албан тушаал	Бүртгэлээс хассан тухай тушаалын огноо, дугаар	Тэтгэмж олгосон тушаалын огноо, дугаар	Шалтгаан
2017 он						
1	Ш.Ө	д/а	Дорноговь аймгийн ОБГ-ын шуурхай албаны жолооч	2017.3.10 №Б/129	2017.3.10 Б/129	Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас нас барсан.
2014 он						
2	Г.Э	а/а	Архангай аймгийн ОБХ-ийн ЭХАС-ын аврагч		2014.1.24 А/29	Үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан.
3	М.Г	а/а	Говьсүмбэр аймгийн ОБХ-ийн АГУ 37-р ангийн гал унтраах автомашины жолооч	2014.1.24 №Б/29	2014.1.24 Б/29	Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас амь насаа алдсан.
4	С.Ц	х/а	БНД-ийн ОБХ-ийн дарга	2014.9.10 №Б/441	2014.9.10 Б/441	Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас амь насаа алдсан.
5	Ж.Э	х/ч	БНД-ийн ОБХ-ийн ахлах мэргэжилтэн	2014.9.10 №Б/441	2014.9.10 Б/441	Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас амь насаа алдсан.
6	Ч.Г	а/х	БНД-ийн ОБХ-ийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч	2014.9.10 №Б/441	2014.9.10 Б/441	Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас амь насаа алдсан.

ТАВДУГААР БҮЛЭГ
ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН
ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

7	Б.Н	а/х	БНД-ийн ОБХ-ийн нягтлан бодогч	2014.9.10 №Б/441	2014.9.10 Б/441	Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас амь насаа алдсан.
8	С.Б	д/х	Автобаазын ачаа хэсгийн дарга	2014.12.4 №Б/653	2014.12.4 Б/653	Албан үүргээ гүйцэтгэж яваад зурраар нас барсан.

2013 он

9	Б.Н	х/ч	Орхон УНС-ын дарга	2013.9.3 № Б/636	2013.9.3 № Б/636	Албан үүргээ гүйцэтгэх явцад ослын улмаас нас барсан
---	-----	-----	--------------------	---------------------	---------------------	--

2012 он

10	Ч.Н	д/ч	Дорнод аймгийн ОБХ-ийн ЭХАС-ийн бүлгийн дарга	2012.5.17 №264		Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.
11	Ж.О	а/ч	Дорнод аймгийн ОБХ-ийн ЭХАС-ийн Эмнэлгийн зааварлагч	2012.5.17 №264		Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.
12	С.Б	а/ч	Дорнод аймгийн ОБХ-ийн ЭХАС-ийн аврагч	2012.5.17 №264		Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.
13	Г.Б	а/а	Дорнод аймгийн ОБХ-ийн ЭХАС-ийн аврагч	2012.5.31 №304		Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.

2010 он

14	З.Б	т/д	Нийслэлийн онцгой байдлын газрын харьяа Налайх дүүргийн ОБХ-ийн Аврах гал унтраах дугаар ангийн салаан захирагч	2010.4.7 №119	2010.4.7 №119	Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.
----	-----	-----	---	------------------	------------------	--

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 18 ДАХЬ ИЛТГЭЛ

15	Х.Б	ш/а	Говьсүмбэр аймаг дахь Улсын нөөцийн салбарын дарга	2010.7.29 №331	2010.7.29 №331	Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.
16	Б.Ц	ш/т	Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн шатахууны салбарын механик – засварчин	2010.9.8 №358	2010.9.8 №358	Албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан.

Дорнод аймгийн Баяндун сумын Шивэртийн аманд 2012 онд гарсан хээрийн түймрийг унтраах үед тус аймгийн Онцгой байдлын газрын аврагч А.Б нь албан үүргээ гүйцэтгэж яваад толгой, нүүр, хөл, гар зэрэг биеийн 65 хувь нь түлэгдэж, хөдөлмөрийн чадвараа 90 хувь алдсан байна. Тэрээр тухайн ондоо Засгийн газрын санхүүжилтээр Бүгд Найрамдах Солонгос Улсад арьс нөхүүлэх мэс ажилбар хийлгэж, эмчлүүлсэн байна. Улмаар 2013–2015 онд гурван удаа өөрийн зардлаар тус улсад дахин эмчлүүлжээ. Гэвч биеийн байдал дээрдэхгүй, өвчин нь бүрэн эдгэрэхгүй байгаагаас дахин мэс ажилбар хийлгэхэд 90 сая төгрөг шаардлагатай байна.

Цаашид албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирсон алба хаагчид нэг удаагийн тусламж олгоод орхилгүй эрүүл мэндээ нөхөн сэргээхэд нь шаардлагатай эмчилгээ, оношилгооны зардлыг төрөөс бүрэн хариуцдаг болох шаардлагатай байна.

5.4 Ажлын цаг, цалин хөлс

Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын цалин, нэмэгдэл хөлс, тэтгэвэр тэтгэмж авах, амрах эрхийг дараах хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцоор баталгаажуулжээ.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 23 дугаар зүйлд “Хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.” Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлийн (a)–д “бүх хөдөлмөр эрхлэгчдэд наад зах нь цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ тухайлбал эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгох, энэхүү пактын заалтын дагуу хөдөлмөр эрхлэгч, түүний гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох”, (c)–д “гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох”, (d)–д “амрах зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгохыг хамаарна.” Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3–т “тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.” гэж тус тус заажээ.

Мөн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Цэргийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн ба цэргийн цолны цалингаас гадна байлдааны жижүүрлэлтийн болон тусгай үүргийн, удаан жил ажилласны, онцгой нөхцөлийн, хилийн, цэргийн мэргэжлийн зэргийн, төрийн нууцад хамаарах

мэдээ мэдээлэл хариуцсаны болон боловсролын эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.” гэжээ.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг¹⁶³ албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиас доошгүй, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг¹⁶⁴ мэргэшлийн зэргээс хамаарч албан тушаалын сарын үндсэн цалингийн 5–15 хувь, тусгай албан тушаалын цолны нэмэгдлийг¹⁶⁵ үндсэн цалингийн 20–40 хувь, тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг¹⁶⁶ төрийн тусгай алба хаасан хугацаанаас хамаарч 5–30 хувь, эрдмийн зэргийн нэмэгдлийг¹⁶⁷ боловсролын зэргээс хамаарч 5–20 хувиар тооцон олгож байна.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 118 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталж, мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлэх хэмжээний төгрөгөөр тооцож олгох нөхцөлийг бүрдүүлсэн байна. Хяналт шалгалт, судалгааны явцад онцгой байдлын алба

¹⁶³ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 380 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ын хавсралт.

¹⁶⁴ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 374 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хавсралт.

¹⁶⁵ Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Цолны нэмэгдлийн хувь хэмжээг тогтоож, журам батлах тухай” 77 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

¹⁶⁶ Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Цолны нэмэгдлийн хувь хэмжээг тогтоож, журам батлах тухай” 77 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.


¹⁶⁷ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.

хаагчийн цалин, хөлстэй холбоотой ямар нэгэн гомдол, санал гараагүй болно.

Судалгааны санал асуулгад нийт 840 алба хаагч оролцсоноос “Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ” гэсэн асуултад 194 оролцогч буюу 23.4 хувь нь 8 цаг хүртэл, 131 оролцогч буюу 15.8 хувь нь 8–10 цаг, 45 оролцогч буюу 5.4 хувь нь 10–12 цаг, 423 оролцогч буюу 51 хувь нь 12 цагаас дээш гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд 599 оролцогч буюу 72.2 хувь нь 8–аас дээш цагаар ажилладаг байна.

Бүдүүвч 26. Онцгой байдлын алба хаагчийн ажлын үеийн үргэлжлэх хугацааны талаар хариулсан байдал

Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?



	8 цаг хүртэл	8–10 цаг хүртэл	10–12 цаг хүртэл	12 цагаас дээш	Хариулаагүй
■ Хувь	23.4	15.8	5.4	51.0	5.7
■ Тоо	194	131	45	42.3	47

Иймд хуульд зааснаас илүү цагаар ажиллаж байгаа алба хаагчдын илүү цагийн болон нийтээр амрах баярын өдөр, амралтын өдрүүдэд ажилласны нэмэгдэл хөлсийг 2019 оноос мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуульд заасны дагуу тухай бүр олгож хэвших шаардлагатай байна.

5.5 Дүрэмт хувцасны хангалт

Тусгай чиг үүрэг гүйцэтгэж буй онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангах нь төрийн үүрэг бөгөөд түүнийг дараах хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах эрхтэй.”, 2008 онд батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.”, мөн зүйлийн 15.2 дахь хэсэгт “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 79 дүгээр тушаалаар баталсан Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцас хэрэглэх журамд заасны дагуу алба хаагч бүр дулааны болон хүйтний улирлын хувцастай байх ёстой. Гэтэл онцгой байдлын байгууллага жил бүр алба хаагчдын хувцас, хэрэглэлийн хангалтыг тухайн жилийн төсөвтөө багтаадаг тул жилийн хангалтын 20–30 хувь нь хийгддэггүй байна.

Мөн гэнэтийн осол аваар, түймэр, үер усны аюул зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүд болсон үед алба хаагчдын хувцас, хэрэглэл гандаж муудах, урагдах, элэгдэх зэргээр эдэлгээний хугацаанаас өмнө хэрэглэх боломжгүй болдог тул тухайн нөхцөлд олгох хувцас хэрэглэлийн нөөцгүй байна.

Алба хаагчдын хувцас, хэрэглэлийн хангалтын байдлыг дараах хүснэгтээр харуулав.¹⁶⁸

Хүснэгт 17. Алба хаагчдын хувцас, хэрэглэлийн хангалтын байдал

№	Албан хаагчдын хувцас хэрэглэл	Хангалтын байдал (хувиар)
1	Ёслолын хувцас	72
2	Албаны хувцас	90
3	Хээрийн хувцас	88
4	Тусгай зориулалтын хувцас	30
5	Савхин дээл	77
6	Зуны гутал	55
7	Өвлийн гутал	78
8	Ноосон цамц	50
9	Албаны цамц	41
10	Ёслолын цамц	51
11	Зуны малгай	84
12	Өвлийн малгай	37
13	Чимэг хэрэгсэл	92
14	Энгийн ажилчдын хувцас	50

Хяналт шалгалт, судалгаанд хамрагдсан зарим алба хаагч дүрэмт хувцасны хангалт, чанар, хүртээмжийн талаар цөөнгүй санал, гомдол гаргаж байв.

Тохиолдол 51

Хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцасны хувьд тухайн алба хаагчийн биеийн хэмжээнд тохирсон, чанарын шаардлага хангасан хувцсаар хангахгүй байна. Жишээлбэл: 2018 онд бүх алба хаагчдад 53 размерын дүрэмт хувцас олгосон.


¹⁶⁸ Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/175 дугаар албан бичиг.

Манай аймаг алслагдмал учир дүрэмт хувцасны хангалт хугацаандаа ирдэггүй. Хувцасны хангалтыг нийслэлийн хүрээнийхэн, төвийн бүсийн аймгууд түрүүлээд авчихдаг тул бидэнд хэмжээ нь том, жижиг, үлдсэн хувцас л ирдэг...

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын ярианаас


Санал асуулгад оролцсон алба хаагчдаас “Дүрэмт хувцасны чанар, хүртээмж хэр вэ” гэж асуухад 155 оролцогч буюу 18.5 хувь нь сайн, 459 оролцогч буюу 54.6 хувь нь дунд, 214 оролцогч буюу 25.5 хувь нь муу гэж хариулснаас үзэхэд 673 оролцогч буюу 80.1 хувь нь хангалтгүй үнэлгээ өгчээ.

Бүдүүвч 27. Дүрэмт хувцасны чанар, хүртээмж хэр вэ?



“Дүрэмт хувцасны хангалтыг хугацаандаа олгодог уу?” гэсэн асуултад 266 оролцогч буюу 31.7 хувь нь тийм, 547 оролцогч буюу 65.1 хувь нь үгүй гэж хариулжээ.

Бүдүүвч 28. Дүрэмт хувцасны хангалтыг хугацаандаа олгодог уу?



Тохиолдол 52

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу аливаа сонгон шалгаруулалтыг зарлахдаа хамгийн бага үнийн дүнтэй санал ирүүлсэн аж ахуй нэгжийн саналыг шалгаруулдаг. Гэвч бодит байдал дээр хямд үнийн саналаа дагаад чанар муутай бараанууд ирдэг.

Онцгой байдлын ерөнхий газрын удирдах албан тушаалтантай хийсэн ярилцлагаас, 2019 он

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн “Дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг батлах тухай” 41 дүгээр тогтоолд заасан хугацаанд дүрэмт хувцсыг олгох, дүрэмт хувцасны чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

5.6 Сурч боловсрох эрх

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай 5 дугаар зүйлийн 5.1.4-т “эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах эрхтэй.” гэж заажээ.

Онцгой байдлын ерөнхий газраас Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуульд 2016 онд 255 сонсогч элсэн суралцсанаас аврагч-гал сөнөөгчөөр 123, гал унтраах автомашины жолоочоор 48, холбооны бага мэргэжилтнээр 84, 2017 онд 356 сонсогч элсэн суралцсанаас аврагч-гал сөнөөгчөөр 214, гал унтраах автомашины жолоочоор 53, холбооны бага мэргэжилтнээр 89, 2018 онд 433 сонсогч элсэн суралцсанаас аврагч-гал сөнөөгчөөр 242, гал унтраах автомашины жолоочоор 56, холбооны бага мэргэжилтнээр 135 алба хаагч тус тус бэлтгэгджээ.

Гамшиг судлалын чиглэлээр 2018 оны байдлаар дотоодын их, дээд сургуульд нийт 148 алба хаагч боловсролын зэргээ дээшлүүлэхээр суралцаж байсан бөгөөд гадаад улсад зохион байгуулагдсан нийт 26 удаагийн сургалт, семинар, уулзалтад 45 алба хаагчийг хамруулсан байна.

Мөн Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад болон АНУ-ын Номхон далайн командлал, Аляскийн үндэсний гвард зэрэг олон улсын байгууллагуудын 600 гаруй алба хаагчдыг хамруулсан хамтарсан сургалтад онцгой байдлын байгууллагаас 98 алба хаагч оролцжээ.


Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/325 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын 2018 оны сургуулийн

жилийн бие бүрэлдэхүүний сургалтыг төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага, хэлтэс, анги, салбарт зохион байгуулж 3,189 алба хаагч хамрагдсан байна.¹⁶⁹

Тус газраас 2018 оны байдлаар мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 45 удаа зохион байгуулж, 1,857 алба хаагчийг хамруулсан боловч сургалтын төлөвлөгөөнд алба хаагчдын наад захын мэдвэл зохих хүний эрхийн ойлголт, хандлагын талаарх сургалт тусгагдаагүй байна.

“Та сүүлийн гурван жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан уу?” гэсэн асуултад 284 оролцогч буюу 33.8 хувь нь тийм, 518 оролцогч буюу 61.7 хувь нь үгүй гэж хариулсан, 98 оролцогч буюу 4.5 хувь нь огт хариулаагүй байна.

Бүдүүвч 29. Та сүүлийн 3-н жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан уу?



Иймээс онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүний эрхийн сургалтыг тусгах, алба хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг үр дүнтэй, тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай байна.

¹⁶⁹ Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/175 дугаар албан бичиг.

VI

БҮЛЭГ

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРИЙН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

“Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт)

“Энэхүү пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй эмэгтэйчүүдэд тэгш эдлэх нөхцөлийг хангах”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактын 3 дугаар зүйлд)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар Комисс “жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын шийдвэрлэлтийн талаар хоёр жил тутамд Улсын Их Хуралд тайлагнах” үүргийг хүлээсэн юм.

Энэ удаагийн илтгэлийг Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ тусгасан жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар 2 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, олж авсан ололт амжилт, ахиц дэвшил, зөрчил, дутагдлыг судлан бэлтгэв.

Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба, яамд, нийслэлийн болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг нийт 61 төрийн байгууллагаас асуулгаар мэдээлэл авч дүн шинжилгээ хийв.

6.1 Монгол Улсын Их Хурал

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1–т Улсын Их Хурал нь “төрийн бодлого, хууль тогтоомжийг хүний эрхэд суурилсан жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байхаар тодорхойлох”, мөн зүйлийн 15.1.2–т “ энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон жендэрийн тэгш байдлын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Улсын Их Хурал 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бий болгож, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлснээс хойш энэ чиглэлээр дараах бодлогыг батлан хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70/1 дүгээр тогтоолоор баталсан “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”-ийн “жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх” 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 2016 онд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийг баталж “нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх” үндэс суурийг тавьжээ.

Мөн онд Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж, тус хөтөлбөрт “жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэж төрийн бодлого, хууль тогтоомжийг жендэрийн тэгш байдлыг хангахад чиглүүлсэн нь Дэлхийн Эдийн засгийн Форумаас жил бүр гаргадаг жендэрийн тэгш байдлыг хангах үзүүлэлтээр Монгол Улс 2018 оны байдлаар дэлхийн 149 улсаас 58 дугаар байр¹⁷⁰, зүүн өмнөд Азийн бүс нутгийн түвшинд 5 дугаар байранд манлайлан ажиллахад зохих хувь нэмрээ оруулсан байна.

¹⁷⁰ <https://www.weforum.org/reports/the-global-gender-gap-report-2018>.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т зааснаар Улсын Их Хурал нь “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эмэгтэй, эрэгтэй хүний тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон төрийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүнгийн хэрэгжилтийг хангахуйц хөрөнгө батлах” бүрэн эрхтэй юм. Улсын Их Хурлаас Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөв батлахдаа Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017–2021)-ийн хэрэгжилтэд зориулж 300 сая төгрөгийн санхүүжилтийг шийдсэн байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2019 оны жилийн төсвийг 706 сая төгрөгөөр баталсан¹⁷¹ нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эмэгтэй, эрэгтэй хүний тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна. Үүнд Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн бүлэг хүчин чармайлт гаргасныг дурдах нь зүйтэй.

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлдээ жендэрийн асуудал нь нийгмийн бүх салбарыг хамарсан цогц асуудал тул салбар дундын жендэрийн асуудлыг зохицуулах бие даасан үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх үүднээс Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг бие даасан бүтэцтэйгээр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх зөвлөмжийг өгсөн билээ. Үүний дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоол гарсан юм. Уг тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Жендэрийн үндэсний хорооны

¹⁷¹ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан, 2019 он.

2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит хуралдаанаар тус хороо, түүний Ажлын албаны статус, бүтэц, зохион байгуулалтыг илүү оновчтойгоор өөрчлөх шаардлагатай байгаа асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн ам хөгжлийн газрын харьяалалд байсныг өөрчилж, Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэжээ. Ингэснээр Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба бие даасан байдлаар ажиллах нөхцөл бүрдсэн байна.

6.2 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ.” гэж заасан байна.

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлд “Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй эмэгтэйчүүд, хүүхдийн эрх”, “Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал, ажлын байран дахь бэлгийн дарамт”, 16 дахь илтгэлд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагаа”-ны талаар тусгаж Улсын Их Хуралд өргөн барьсан билээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн албаны зөвлөлөөс 2018–2021 онд

хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд Шихихутуг судалгааны хүрээлэнгийн судлаач-багш нарын багтай хамтран “Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал” судалгааны ажлыг 2018 онд хийж гүйцэтгэлээ. Уг судалгааны зорилго нь ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал, төлвийн талаар олон нийтийн санаа бодолд тулгуурлан тандалт судалгаа хийх, ажлын байран дахь бэлгийн дарамтыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргахад чиглэсэн болно.

Мөн төслийн хүрээнд Хууль сахиулахын их сургуультай хамтран Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан төрийн захиргааны албан тушаалд тогтоосон жендэрийн квотын хэрэгжилтэд дүн шинжилгээ, судалгааны ажлыг хийлээ. Энэхүү судалгаагаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан төрийн захиргааны албан тушаалд тогтоосон жендэрийн квотын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохыг зорьсон юм.

Комисс 2017, 2018 онд жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөнтэй холбоотой нийт 14 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд эдгээр гомдлын дийлэнх нь ажлын байран дахь бэлгийн дарамт, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой байна. Энэ нь Комисст ирүүлсэн нийт гомдлын хоёр хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд иргэд жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамтын тухай ойлголт, мэдээлэл дутмаг байгаагаас хаана хандахаа мэдэхгүй, мэдсэн ч хувь хүний нэр төр, нууцтай холбоотой асуудал тул төдийлөн гомдол гаргахгүй байна. Нөгөөтэйгүүр хуульд ялангуяа ажлын байран дахь бэлгийн дарамт үйлдэгчид оногдуулах хариуцлагыг тодорхой заагаагүйгээс хохирогч нь гэр бүл,

хамт олныхоо дунд нэр төр, байр сууриа алдахаас эмээх явдал нөлөөлж байна.

Комисс жендэрийн эрх тэгш байдал зөрчсөн тухай гомдлын дагуу холбогдох хүмүүсээс тайлбар авах, баримт материал гаргуулан авах зэргээр шаардлагатай ажиллагааг хийж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, тухайн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Комиссын гишүүний зөвлөмж, хүний эрхийн зөрчил тогтоогдсон тохиолдолд буруутай этгээдэд хариуцлага тооцуулах, зөрчлийг арилгуулахаар Комиссын гишүүний шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.

Гэвч Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхээр заасан байдаг тул хувь хүн жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль зөрчсөнтэй холбоотой гомдлыг шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.

Тохиолдол 53

...эмэгтэй сэтгүүлч Э-г зохиол бүтээл туурвисных нь төлөө нас, хүйс, бие эрхтнээр нь доромжлон, алдар хүндэд нь халдсан “шүүмж” нэртэй бичвэрийг Sonin.mn, URLag.mn, Amjilt.com зэрэг олон нийтийн портал сайтуудаар тараасан тухай Иргэн Б-д холбогдох гомдол Комисст ирсэн. Гомдлыг шалгахад иргэн Б нь иргэн Э-г соёл урлаг, боловсролын салбарт эмэгтэй гэдгээр нь илтэд хүйсээр нь ялгаварлан гадуурхаж, доромжилсон болох нь тогтоогдсон. Гэвч хүний эрхийг зөрчсөн иргэнд Комисс шаардлага, зөвлөмж хүргүүлэх хуулийн зохицуулалтгүй учир тухайн асуудлыг шалгуулахаар Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтэст шилжүүлсэн юм. Гэтэл тус хэлтсээс эрүүгийн хэрэг үүсгэх

үндэслэлгүй гэж үзээд зөрчлийн хэрэг үүсгэж, шалгуулахаар шилжүүлсэн байна. Гэтэл Зөрчлийн тухай хуульд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт байхгүй гэх үндэслэлээр зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэж, иргэн Э-д нэр төр, алдар хүндэд учирсан хохирлоо иргэний журмаар нэхэмжилж, шүүхэд хандах нь зүйтэй гэсэн хариуг өгчээ.

Дээрхээс үзэхэд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт Зөрчлийн тухай хуульд байхгүй байх тул уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хариуцлагын хэм хэмжээг тусгах зайлшгүй шаардлагатай байна.

Комисст ирүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчсөнтэй холбоотой гомдлын дийлэнх хувь нь төрийн байгууллагын удирдах албан тушаалтантай холбоотой байсан. Иймээс Комисс төрийн албан хаагчдын жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол явуулж байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн албаны зөвлөлөөс 2018–2021 онд хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн “Төрийн захиргаан дахь жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх” 3 дахь үр дүнгийн ажлыг хариуцан гүйцэтгэж, 2018 онд 21 аймгийн төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтыг явуулж, нийт 420 сургагч багш бэлтгэсэн байна.

Түүнчлэн төрийн албан хаагчдад “Жендэр ба хүний эрх”, “Ажлын байр-Бэлгийн дарамтгүй орчин” гарын авлагууд, “Жендэр ба хүний эрх” сэдэвт брошур, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангая”, “Ажлын байран дахь бэлгийн дарамтаас

сэргийлье”, “Ялгааг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооё” зэрэг шторк, сурталчилгааны ажлуудыг зохион байгууллаа.

Мөн Гадаад харилцааны яамтай хамтран 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь: Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт онол, практикийн бага хурлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, тус байгууллагуудын жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хийж буй үйл ажиллагаа, энэ төрлийн хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд тулгамдаж буй бэрхшээл, ололт амжилтын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, жендэрээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Комиссын гишүүний Зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4.б хэсэгт Улсын Их Хурал “жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал...”-ын талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргахаар заасан байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, тайлагнах нь Засгийн газар, тэр дундаа Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн Жендэрийн үндэсний хорооны эрх үүрэг байх тул хуулийн дээрх заалтаас “жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал” гэсэн хэсгийг хасч, нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

6.3 Төрийн албаны зөвлөл

Жендэрийн тэгш байдлыг хангах талаарх Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан байна. Тус байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хуулийн заалтуудыг төрийн албанд мөрдлөг болгон хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн албыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгахад голлох үүрэгтэй байгууллага юм.

Төрийн албаны зөвлөл нь жил бүрийн 1 дүгээр улиралд төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний нэгдсэн статистик мэдээг төрийн албан хаагчдыг хүйсээр нь ангилан гаргаж, өөрийн цахим хуудаст байршуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлдэг байна. Ингэхдээ улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албанд ажиллагчдын эзлэх хувь хэмжээг албан тушаалын зэрэглэлээр гаргахын зэрэгцээ төрийн нийт албан хаагчдыг хүйсээр нь эзлэх харьцааг мөн тусгаж, төрийн албаны ангилал болон албан тушаалын ангилал зэрэглэлээр ялган харьцуулж, хүйсийн харьцааг гаргадаг¹⁷² болсон нь сайшаалтай юм.

Комисс ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт сэдвийг заавал судлах сургалтын сэдэвт оруулан, шалгуур тавих зэрэг саналуудыг Төрийн албаны зөвлөлөөс батлах дүрэм, журамд тодорхой болгон тусгуулахаар санал хүргүүлсэн болно.¹⁷³ Үүний дагуу Төрийн албаны зөвлөл

¹⁷² Монгол Улсын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, 2018 он.

¹⁷³ Комисс 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 3/676 дугаар албан бичиг.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлуулахдаа 3.1.3.в. хэсэгт “жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх” гэсэн заалтыг тусгажээ.

Төрийн албаны зөвлөл Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан төрийн албан дахь улс төрийн, төрийн захиргааны, төсөвт байгууллагын албан хаагчдын дунд аль нэг хүйсийн эзлэх хувь хэмжээний доод хязгаарыг заасан заалтын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээсэн болно. Жишээ нь уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т “томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас ...доошгүй байх” гэжээ.

Харин доорх хүснэгтэд үзүүлсэн үзүүлэлтээр бол эдгээр албан тушаал дахь эмэгтэйчүүдийн хувь хуульд заасан зохих хувь хэмжээнд хүрэхгүйг харуулж байна.

Хүснэгт 18. Төрийн улс төрийн албан тушаалтнуудын хүйсийн харьцаа¹⁷⁴

Албан тушаал	Нийт	Хүйс			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		тоо	хувь	тоо	хувь
Засгийн газар	29	22	75.86	7	24.13
Аймаг, нийслэл	59	54	91.52	5	8.47

Харин Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т “төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл

¹⁷⁴ Монгол Улсын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан. 2018 он.

яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх” гэж заасан байна.

Хүснэгт 19. Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн харьцаа¹⁷⁵


Албан тушаал	Нийт	Хүйс			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		тоо	хувь	тоо	хувь
Яамдын Төрийн нарийн бичиг	13	12	92.3	1	7.7
Агентлагийн дарга	30	29	96.7	1	3.3
Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга	22	18	81.8	4	18.2
Аймаг нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга	22	22	100	–	–
Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга	22	18	81.8	4	18.2

Дээрх хүснэгтээс харвал яамдын төрийн нарийн бичгийн даргын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ байх ёстойгоос даруй 2 дахин бага, агентлагийн даргын түвшинд 100 хувь байхгүй, аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын түвшинд 22.8 хувиар бага байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний

¹⁷⁵ Монгол Улсын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан. 2018 он.

нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ...” гэж заасан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын байдлаар төрийн албан хаагчдын тоо нийт 193,557 байгаагаас 76,564 албан хаагч буюу 39.6 хувь нь эрэгтэй, 116,993 албан хаагч буюу 60.4 хувь нь эмэгтэй байв.¹⁷⁶

Бүдүүвч 30. Төрийн нийт албан хаагчдын тоо¹⁷⁷



Дээрхээс үзвэл Төрийн албаны зөвлөл хэдийгээр төрийн албан дахь аль нэг хүйсийн эзлэх хувь хэмжээнд хяналт тавьж байгаа мэт боловч бодлого тодорхойлох, шийдвэр гаргах буюу удирдах түвшний албан тушаал эрхлэх эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахад хяналт тавьж чадахгүй байна. Нийт төрийн албан хаагчдын дундах аль нэг хүйсийн эзлэх хувь хэмжээ 40 хувиас доошгүй байх гэсэн харьцаа хангагдсан мэт харагдах боловч төрийн байгууллага, албан тушаалын ангилал, зэрэглэл бүр дээр хуульд заасан зохистой

¹⁷⁶ Монгол Улсын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, 2018 он.

¹⁷⁷ Мөн тэнд.

харьцаа алдагдсан дүр зураг нийтлэг байна. Ялангуяа дунд буюу түүнээс дээш түвшинд, тэр дундаа шийдвэр гаргах түвшний албан тушаалд эрэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ давамгайлсан байхад эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ 0–26 хувь байгааг анхаарах нь зүйтэй юм.

Төрийн албаны удирдах албан тушаалтны томилгоо хийх, сонгон шалгаруулах үйл явцад жендэрийн мэдрэмжтэй ханддаг байх нь нэр дэвшүүлж буй холбогдох төрийн байгууллага, мөн төрийн албаны төв байгууллага Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд түлхэц болох тул Төрийн албаны зөвлөлийн зүгээс хяналт тавих чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс тухайн цаг үе дэх жендэрийн статистикт тулгуурлан холбогдох зөвлөмж, зааврыг нэр дэвшүүлж, сонгон шалгаруулалт явуулах байгууллагуудад өгч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Төрийн албаны зөвлөл нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4.в хэсэгт заасан төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээнийхээ явц, үр дүнгийн талаарх тайланг хоёр жил тутам Улсын Их Хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулах хуулийн заалтыг 2011 онд уг хууль батлагдсанаас хойш нэг ч удаа хэрэгжүүлээгүй байна.

6.4 Үндэсний статистикийн хороо

Үндэсний статистикийн хороо нь хүйсээр ангилсан статистик мэдээлэл боловсруулах, жендэрийн асуудлаарх статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн хөгжүүлэх, улмаар энэхүү статистик мэдээллийг бүх шатны бодлого

төлөвлөлтөд ашиглах боломжийг бий болгоход чухал үүрэгтэй байгууллагын нэг юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1-т “жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах програм хангамжийг нэвтрүүлэх”, мөн төлөвлөгөөний 2.2-т “жендэрийн статистикийг бодлого төлөвлөлт үйл ажиллагаандаа ашиглах, аргачлал боловсруулж хуулиар хүлээсэн үүрэг хүлээгчдэд хүргүүлэх”-ийг Үндэсний Статистикийн хороонд үүрэг болгосон байна.

Үндэсний статистикийн хороо нь статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-д жендэрийн эрх тэгш байдлын бүлгийн 45 төрөл хүснэгтийг бий болгож, жендэрийн статистик мэдээллийг сайжруулах, хэрэглэгчдэд хүргэх арга зүйг нэвтрүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Тухайлбал Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт заасан хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах, жендэрийн мэдээллийн санг хөгжүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах, салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн статистикийн мэдээллийг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулах зорилгоор Жендэрийн үндэсний хороотой “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулжээ.¹⁷⁸

Санамж бичгийн хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1–10.1.4-т заасны дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй

¹⁷⁸ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан, 2019 он.

байдлын судалгаа авах маягтыг Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөн, статистик мэдээллийн маягттай нэгтгэх, уг статистик мэдээллийг Жендэрийн үндэсний хороо татан авч танилцах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.¹⁷⁹

Түүнчлэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хянах мэдээллийн сангийн нэн хэрэгцээт захиргааны болон албан ёсны статистик үзүүлэлт боловсруулж, холбогдох тушаал, шийдвэр журам, маягтын загваруудыг Үндэсний статистикийн хороогоор батлуулан албажуулахаар ажиллаж байна.¹⁸⁰

Үүнээс гадна Үндэсний статистикийн хорооноос жендэрийн чиглэлээр үндэсний хэмжээнд хийсэн төрөлжсөн судалгаануудын нэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 2017 онд зохион байгуулсан жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх “Тэгш байдлын төлөө аниргүйг эвдэхүй” судалгаа юм. Энэ нь Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний хэмжээний томоохон тоон болон чанарын судалгаа болсон тул цаашид судалгааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Цаашид Үндэсний статистикийн хороо нь үндэсний статистикийн системийн мэдээллийн санд байгаа болон бий болгох шаардлагатай жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүдийг тодорхойлж, тооцох аргачлалыг боловсруулах, албан ёсны болон захиргааны статистикийн үзүүлэлтүүдийг хүйсээр ангилан гаргаж хэвших, мэдээллийг түгээх, ашиглах, жендэрийн мэдрэмжтэйгээр тайлбарлах

¹⁷⁹ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан, 2019 он.

¹⁸⁰ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан, 2019 он.

тусгай аргачлалтай болох арга хэмжээг авахаар төлөвлөж¹⁸¹, энэ чиглэлээр Жендэрийн үндэсний хороотой хамтран ажиллаж байна.

Төрийн байгууллагууд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөх, боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах болон хүний нөөцөө бүрдүүлэхэд байнга ашиглаж эргэлтэд оруулах шаардлагатай байна.

6.5 Монгол Улсын Засгийн газар

Энэ хэсэгт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16–19 дүгээр зүйлд заасан Засгийн газар, яамд, Жендэрийн үндэсний хорооны чиг үүргийг хамруулан авч үзлээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1–т Засгийн газар нь “жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, эдгээрийн хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг батлуулах” талаар заажээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дээрх заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас сүүлийн 2 жилийн хугацаанд бодлогын түвшинд анхаарч ажилласан байна. Тухайлбал, Засгийн газар 2017 оны 4 дүгээр сарын 26–ны өдрийн 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017–2021), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 8 дугаар сарын 7–ны өдрийн А/132

¹⁸¹ Үндэсний Статистикийн хорооноос ирүүлсэн мэдээлэл.

дугаар тушаалаар “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус батлан хэрэгжүүлж эхэлжээ. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулж 2019 оны улсын төсөвт 300 сая төгрөг, 2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад 127 сая төгрөг тус тус тусгасан байна.¹⁸²

Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанд 2018 онд Азийн хөгжлийн банкны “Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” төсөл хэрэгжиж 597,2 сая төгрөг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд 281,6 сая төгрөгийг зарцуулсан байна.¹⁸³ Мөн үндэсний хөтөлбөрийн 2017 оны зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 80 хувийн гүйцэтгэлтэй байна гэж үнэлжээ.¹⁸⁴

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах чиглэлээр Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба 2016–2018 онд жендэрийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, форум, үндэсний болон бүсийн чуулганыг давхардсан тоогоор 40 орчим удаа зохион байгуулж, 4,000 орчим төрийн албан хаагчдад мэдээлэл, танилцуулга хийж, чадавхыг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны даргын ивээл дор төр, төрийн бус иргэний нийгмийн, олон улсын байгууллага,

¹⁸² Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас ирүүлсэн 2019 оны 03/036 дугаар албан бичиг.

¹⁸³ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас ирүүлсэн 2019 оны 03/036 дугаар албан бичиг.

¹⁸⁴ Мөн тэнд.

нутгийн захиргааны байгууллагын 600 гаруй төлөөллийг хамруулсан “Жендэр ба хөгжил” үндэсний чуулганыг 2018 оны 2 дугаар сарын 1–ний өдөр зохион байгуулж, чуулганаас гарсан зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлсэн байна.¹⁸⁵

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан бөгөөд мөн зүйлийн 19.1.1–т төрийн захиргааны төв байгууллага нь салбарынхаа хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Энэ хүрээнд яамд салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөртөө жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхийг зорьж ажиллаж эхэлсэн нь сайшаалтай байна. Жишээлбэл, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендэрийн стратеги (2016–2024), Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого (2018–2021), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017–2024), Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018–2025), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018–2024), Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018–2024), “Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014–2030)”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө (2017–2020)”-г тус тус хэрэгжүүлж эхэлжээ.

¹⁸⁵ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан 2019 он.

Үүнээс үзэхэд сүүлийн 2 жилийн хугацаанд Засгийн газар хуулиар хүлээсэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого боловсруулах чиг үүргээ хэрэгжүүлж, ажиллаж байна.

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба нь салбар, орон нутгийн жендэрийн бодлогыг боловсруулахад яамдын салбар зөвлөл, аймаг, нийслэлийн салбар хороог мэргэжил арга зүй, удирдлагаар ханган ажиллаж байна. Ялангуяа салбар зөвлөл, салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулахад анхаарч, жендэрийн бодлого баталсан долоон салбарын болон нийслэл, дүүргийн 540 орчим төрийн албан хаагчдын дунд бүсийн сургалт зохион байгуулжээ.¹⁸⁶

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т заасны дагуу яамдад жендэрийн орон тооны бус салбар зөвлөл ажиллаж байна. Яамдаас ирүүлсэн мэдээллээр салбар зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжсон, жил бүр төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна гэх боловч үйл ажиллагаанд нь мониторинг, үнэлгээ хийсэн эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т төрийн захиргааны төв байгууллага нь тухайн салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх талаар заажээ. Ихэнх яамд харьяа байгууллагуудаасаа хүйсээр ангилсан статистик мэдээллийг авч байгаа гэх боловч ихэнх тохиолдолд тухайн салбарын боловсон хүчний хүйсийн харьцаа, хэрэглэгчид, ажиллагчдаас авах

¹⁸⁶ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан 2019 он.

судалгаанд нас, хүйсийн үзүүлэлтийг оруулах төдийгөөр хязгаарлагдаж байна. Харин салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийн сан бүрдүүлж, бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад ашиглаж хэвшээгүй, энэ төрлийн аргачлалгүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах” –ыг яамдад үүрэг болгожээ. Энэ хүрээнд зардлыг улсын төсвөөс гарган төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн талаар мэдээлэл ирүүлжээ. Тухайлбал, Гадаад харилцааны яам “Дипломат албаны жендэрийн бодлого” боловсруулах ажлын хүрээнд яамны бодлого, үйл ажиллагаа, оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийх зөвлөх багаар “Эмэгтэйчүүдийн Дипломат клуб” төрийн бус байгууллагыг сонгон ажиллуулж байгаа бөгөөд судалгааны ажил хийхэд зориулж 4 сая төгрөг төсөвлөсөн байна.¹⁸⁷

Харин зарим яамд олон улсын байгууллагын санхүүжилтээр салбартаа жендэрийн үнэлгээ хийх, бодлого боловсруулах ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6-д төрийн захиргааны төв байгууллага нь тухайн салбарын хэмжээнд жендэрийн сургалт, соён гэгээрлийн ажил явуулах талаар заажээ. Гэтэл ихэнх яамд Жендэрийн үндэсний хороо болон бусад байгууллагаас зохион байгуулдаг сургалт, хурал, уулзалтад холбогдох мэргэжилтнийг оролцуулах төдий үйл ажиллагаа явуулж байна.

¹⁸⁷ Гадаад харилцааны яамнаас 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 08/1336 дугаар албан бичиг.

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах, төрийн албаны манлайллыг бэхжүүлэхэд анхаарч ажилласан байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.9-д “Төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлэх”-ээр заасны дагуу тайланг ирүүлж байна.

Тайлан, мэдээллийн чанар хангалтгүй, хэт ерөнхий, зөвхөн харьяа байгууллага, нэгжүүдийн ажлын тайланг нэгтгэсэн байдалтай байсныг Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас анхаарч, тайлангийн загварыг шинэчлэн боловсруулж, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллажээ.

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлээрээ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг бие даасан бүтэцтэйгээр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх зөвлөмжийг өгсний дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоол гарч, уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн ам хөгжлийн газарт харьяалагдаж байсныг өөрчилж, Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэсэн нь үндэсний хэмжээнд салбар дундын бодлогыг хэрэгжүүлэх, бие даасан байдлыг хангахад чухал алхам болжээ.

Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 285 дугаар тогтоолоор Ажлын албаны орон

тоо нь дарга, 3 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй байсныг өөрчилж, 8 орон тоотой болгож, үйл ажиллагаагаа явуулах ажлын байрны асуудлыг шийдэж өгчээ. Цаашид бодлогын хувьд гарсан энэхүү ахиц дэвшлийг баталгаажуулж, бодлого, хөтөлбөрийн бодит хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаандаа *хэвшүүлэх, ялангуяа* яамдаас гарсан салбарын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусган шийдэх, хэрэгжилтэд Жендэрийн Үндэсний Хороо хуулийн дагуу хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Түүнчлэн Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг үндэсний хэмжээнд сурталчлан таниулах, жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгахад бүх нийтийн боловсролыг дэмжих, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, нийгмийг соён гэгээрүүлэх ажлыг улам эрчимжүүлэх шаардлагатай байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдаад найман жил болж байгаа ч хэрэгжилт хангалтгүй, зөвхөн энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудын үүрэг мэтээр хүлээн авдаг байдлыг мөн таслан зогсоох, хуулийг хэрэгжүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

6.6 Нутгийн захиргааны байгууллага

Нутгийн захиргааны байгууллагууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг дараах хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт 20. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай
холбогдох хуулийн заалт*

№	Холбогдох хуулийн заалт	Хэрэгжүүлсэн	Хэрэгжүүлээгүй
1	19.1.9 Жендэрийн тэгш байдлын тайланг ЖҮХ-д хүргүүлэх	21	
2	19.1.8 Ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг гарган хүргүүлэх	21	
3	19.1.7 Ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	16	5
4	19.1.7 Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах	14	7
5	19.1.6 Жендэрийн сургалт, гэгээрлийн ажил явуулах	21	
6	19.1.5 Жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх, зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах	17	4
7	19.1.4 Зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар хороо байгуулж, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах	20	1

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРИЙН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

8	19.1.2 Жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх	20	1
9	19.1.2 Жендэрийн мэдрэмжтэй статистик мэдээллийг бүрдүүлэх	19	2
10	19.1.1 Жендэрийн дүн шинжилгээ хийсэн тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах	17	4
11	19.1.1 Бодлогын төсөлд жендэрийн дүн шинжилгээ хийх	18	3
12	19.1.1 Орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх	14	7

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1–т зааснаар тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах үүрэгтэй юм. Баянхонгор, Баян–Өлгий, Завхан, Говь–Алтай, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ, Увс, Дорнод, Ховд, Өмнөговь, Дархан–Уул, Төв зэрэг 14 аймаг жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг баталж, бусад нь батлаагүй байна.

¹⁸⁸ Дэд хөтөлбөрийг батлаагүй шалтгаанаа тайлбарлахдаа жендэрийн асуудлаар мэргэшээгүй, дадлага, туршлага хангалтгүй, арга зүй нь тодорхой бус, орон нутагт энэ асуудлаар чадавхжсан төрийн албан хаагч байхгүй гэсэн байна. Хэдийгээр орон нутагт энэ чиглэлээр мэргэшсэн төрийн албан хаагч, боловсон хүчин дутмаг байгаа ч Комисс

¹⁸⁸ Сүхбаатар, Орхон, Өвөрхангай, Дундговь, Хөвсгөл, Архангай, Хэнтий аймаг

болон Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас энэ чиглэлээр аргачлал хүргүүлж, мэдээллээр хангасан тул аймгууд санаачлагатай ажиллах хэрэгтэй юм.

Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг Өвөрхангай, Баян-Өлгий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Төв, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь аймгууд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, нийслэл, нийслэлийн есөн дүүрэгт олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр төрийн бус байгууллагуудыг гэрээлэн тус тус гүйцэтгүүлжээ.¹⁸⁹ Үүнээс үзэхэд нутгийн захиргааны байгууллагуудад сүүлийн 2 жилд хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэхээр тодорхой ажлууд хийгджээ.

Цаашид нутгийн захиргааны байгууллагууд дээрх бодлогын баримт бичгийг бодит үйл ажиллагаа *болгон хэвшүүлэхэд анхаарах, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас түүнд шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавьж ажиллах* шаардлагатай.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2.-т нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх талаар заажээ. Комисст ирүүлсэн мэдээллээс үзвэл 19 аймаг хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг холбогдох салбар чиглэлээр бүрдүүлэн гаргаж байна гэх боловч энэхүү мэдээлэлд тулгуурлан бодлого, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлж, түүний үр нөлөөг үнэлж байгаа эсэх талаарх мэдээлэл хангалтгүй байна.

¹⁸⁹ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас ирүүлсэн 2019 оны ОЗ/ОЗ6 дугаар албан бичиг.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т заасны дагуу аймгуудад Жендэрийн хороо байгуулсан талаар мэдээлэл ирүүлсэн байна. Зарим сумдад болон Засаг даргын тамгын газрын харьяа байгууллагуудад мөн хороог байгуулжээ. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн 17 сум болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар; Боловсрол, соёл урлагийн газар; Хүнс, хөдөө аж ахуйн газар; Эрүүл мэндийн газар; Биеийн тамир, спортын газар; Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар; Нийгмийн даатгалын хэлтэс; Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд байна.¹⁹⁰

Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд 2018 оны байдлаар 11 аймгийн салбар хороонд орон нутгийн төсвөөс 189 сая төгрөгийг зарцуулсан бол 2019 онд Булган, Орхон, Сүхбаатар, Ховд, Говьсүмбэр, Увс аймгууд нийт 51,6 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Нийт салбар хороодын 50 орчим хувийг Засаг дарга, 20 орчим хувийг Засаг даргын орлогч, 10 орчим хувийг Засаг даргын тамгын газрын дарга, 20 орчим хувийг нь Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар ахалж байна.¹⁹¹

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-т нутгийн захиргааны байгууллага ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх талаар заасан байдаг.

¹⁹⁰ Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 1/223 дугаар албан бичиг.

¹⁹¹ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас ирүүлсэн 2019 оны 03/036 дугаар албан бичиг.

Хүснэгт 21. Тайлан ирүүлж буй байдлыг 2017–2018 оны байдлаар авч үзвэл

№	Тайлант он	Салбар хороо	
		Хугацаа хоцроосон	Тайлан ирүүлээгүй
1	2017	Говьсүмбэр Ховд Дорнод Төв	Баян-Өлгий Хөвсгөл
2	2018	–	Сэлэнгэ

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба нь Жендэрийн салбар хороодоос ирүүлсэн тайлан мэдээллийг нэгтгэн Жендэрийн үндэсний хорооны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, хорооны гишүүдээс ирүүлсэн саналыг 2018, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталжээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1–т “ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах”, мөн шинэчлэн найруулсан Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4–т “албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах”-ыг хориглоно гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг авч үзэхэд 14 аймгийн Засаг даргын тамгын газраас¹⁹² хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, гомдлыг барагдуулах хэм хэмжээг


¹⁹² Дархан-Уул, Баянхонгор, Сүхбаатар, Орхон, Говьсүмбэр, Өвөрхангай, Дундговь, Дорнод, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Говь-Алтай аймаг

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРИЙН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

тусгасан талаарх мэдээллийг ирүүлжээ. Иймд Комиссоос тухайн аймгуудад хяналт шалгалт, мониторинг хийх замаар мэдээллийг бататгах нь зүйтэй гэж үзлээ.

Комисс 21 аймгийн 246 төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн ажилтнуудаас хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгасан эсэхийг асуухад ердөө 65 байгууллага нь тусгасан гэж хариулжээ. Үүнээс үзэхэд дээрх асуудал нь зарим төрийн байгууллагуудын хувьд эхлэл төдий байна.


Бүдүүвч 31. Ажлын байран дахь бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх хуулийн заалтыг дотоод журамдаа тусгаагүй байдал



Хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй шалтгааныг тодруулахад 75 хувь нь 2019 онд хийхээр төлөвлөсөн, 17 хувь нь хуулийн сурталчилгаа хангалтгүй, 7 хувь нь удирдлагууд хуульд ач холбогдол өгдөггүй, 1 хувь нь ажлын байранд бэлгийн дарамт байхгүй гэж хариулжээ. Иймээс төрийн захиргааны байгууллагууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасныг хөдөлмөрийн дотоод журамдаа

тусгаж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн байгууллагуудад хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгч, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2-т заасан ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг 246 байгууллагаас 32 нь л төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж байна.

Бүдүүвч 32. Бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх



Иймд төрийн захиргааны байгууллагууд сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөндөө энэ чиглэлийн сургалтыг жил бүр тусгаж, сурталчилгааг эрчимжүүлэх, байгууллагын түвшинд гомдол шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт танай байгууллагын түвшинд ямар байгаа талаар орон нутгийн захиргааны байгууллагын 246 хүний нөөцийн ажилтнаас авсан асуумжид 134 нь сайн, 87 нь дунд, 16 нь муу гэж хариулсан бол 9 нь огт хариулаагүй байна. Хуулийн хэрэгжилт дунд, муу гэсэн хариулыг

тодруулахад “энэ талаар ойлголт мэдээлэл хангалтгүй, ялангуяа удирдах ажилтнууд мэдээлэл муугаас энэ төрлийн ажлыг дэмждэггүй, жендэрээр мэргэшсэн ажилтан орон нутагт байхгүй” гэсэн шалтгааныг голчлон дурджээ.

Мөн дээрх ажилтнуудаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар тодруулахад 86 хувь нь удирдлагын түвшинд сайн ойлгуулах, нийт төрийн захиргааны ажилтнуудыг сургалтад хамруулж, тогтмол мэдээллээр хангаж байх шаардлагатай гэж хариулжээ.

Иймээс төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд нь байгууллагын жендэрийн хуулийн хэрэгжилтийн талаар тодорхой ажлыг тусгаж, гүйцэтгэлийг нь үнэлдэг байх нь чухал байна.

6.7 Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд


Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод жендэрийн асуудлыг тусгах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, дүнг нийтэд мэдээлэх;
- Жендэрийн тэгш байдлыг хангах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх;
- Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр олон талт түншлэлийг хөгжүүлэх, дэмжих эдгээр болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 18 ДАХЬ ИЛТГЭЛ

Дээр дурдсан үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар мэдээллийг Монгол Улсын 21 аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагаас асуулгаар авахад нийт 19 аймаг хариу ирүүлснээс үзвэл дараах үзүүлэлт гарч байна.

Бүдүүвч 33. Аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт



	20.1.1 Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгах	20.1.1 Хэрэгжилтийг хянах	20.1.2 Төсөв, санхүү	20.1.3 Хамтын ажиллагаа	20.1.4 Тайлан хүргүүлэх	20.2 ЗД-ын тайлан хэлэлцэх, дүгнэх
■ хэрэгжүүлсэн	18	18	18	19	17	17
■ хэрэгжүүлээгүй	1	1	1	0	1	2
■ Хариулаагүй	1	1	1	1	2	1

Комисст мэдээлэл ирүүлсэн аймгуудаас Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Завхан, Төв, Ховд, Баян-Өлгий, Булган, Увс, Орхон, Өмнөговь, Дундговь, Архангай, Говьсүмбэр, Өвөрхангай, Хэнтий, Хөвсгөл, Дорноговь, Сүхбаатар, Говь-Алтай зэрэг 18 аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн зорилт, үйл

ажиллагааны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тодорхой заалт тусган оруулжээ.

Мөн аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь жендэрийн тэгш байдлыг хангах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд уг чиг үүргийн хэрэгжилтийн талаар Архангай, Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Завхан, Төв, Ховд, Баян-Өлгий, Булган, Увс, Орхон, Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Дорноговь, Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Комисст мэдээлэл ирүүлсэн байна.

Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Завхан, Төв, Баян-Өлгий, Булган, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Дорноговь, Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас жил бүрийн орон нутгийн төсөвт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар заалтыг хэрэгжүүлэх тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө суулгаж үйл ажиллагаандаа зарцуулдаг гэсэн бол Увс болон Дундговь аймгууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх болон жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааны зардлыг төсөвт суулгалгүй аймгийн орон нутгийг хөгжүүлэх сан болон аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлсэн гэсэн мэдээлэл өгчээ. Харин Комисст мэдээлэл ирүүлсэн аймгуудаас Архангай аймаг жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ямар нэгэн санхүүжилт орон нутгийн төсөвт тусгаагүй, Сүхбаатар аймаг энэ талаар хариулаагүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасан “Жендэрийн тэгш

байдлыг хангах чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах” чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Завхан, Төв, Ховд, Баян-Өлгий, Булган, Увс, Орхон, Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Дорноговь, Сүхбаатар, Говь-Алтай зэрэг 19 аймаг авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл ирүүлсэн бөгөөд Архангай аймаг энэ талаар хариулаагүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан “Жендэрийн тэгш байдлыг хангах тайлангаа Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх” чиг үүргийн хүрээнд Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Завхан, Төв, Ховд, Баян-Өлгий, Булган, Увс, Орхон, Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал тус бүр Жендэрийн үндэсний хороонд тайлан хүргүүлж ирсэн байна. Харин Хэнтий, Сүхбаатар аймаг энэ талаар хариулаагүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т зааснаар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх Засаг даргын тайланг хурлаараа хэлэлцэж, дүнг нийтэд мэдээлэх” үүрэгтэй юм. Энэ заалтыг хэрэгжүүлсэн талаарх асуулгад Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Завхан, Төв, Ховд, Баян-Өлгий, Булган, Увс, Орхон, Өмнөговь, Говьсүмбэр, Хэнтий, Хөвсгөл, Дорноговь, Говь-Алтай гэсэн 17 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх аймгийн Засаг даргын тайланг, хэлэлцэж дүгнэн, дүнг орон нутгийн радио, телевиз, хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд мэдээлсэн гэж хариулсан байхад

Архангай, Дундговь, Сүхбаатар аймгууд энэ талаар ямар нэг ажил зохион байгуулаагүй байна.

Цаашид Нутгийн өөрөө удирдах байгууллага Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилтийг тухайн орон нутгийнхаа төсвөөс санхүүжүүлэхэд анхаарч ажиллах, нутгийн захиргааны байгууллага жендэрийн дэд хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж буйд хяналт тавих улмаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Дээрх үзүүлэлт буурахад аймаг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тайлангийн ирц голлон нөлөөлжээ. Иймд нутгийн өөрөө удирдах байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, хуулийг нэг мөр дагаж мөрдөх шаардлагатай байна.

Дүгнэлт

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээр 2015 онд Монгол Улсын илтгэлийг хэлэлцээд гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх талаар хүчин чармайлт гаргах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг ямар нэг тайлбар, шалтгаан тоочихгүйгээр бүрэн хэрэгжүүлэх, нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн төлөөллийн оролцоог нэмэгдүүлэхийг зөвлөсөн билээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа үндэсний болон орон нутгийн түвшинд 2017–2018 онуудад идэвхжиж, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, салбарын болон орон нутгийн хөтөлбөр, баримт бичгүүд батлагдаж, бодлогын түвшинд ахиц гарсан байна. Мөн улсын болон орон нутгийн төсөвт холбогдох санхүүжилтийг тусгасан нь төдийлэн хангалтгүй байна.

Мөн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн шийдвэр гаргагч, удирдах албан тушаалтнуудын жендэр, хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах нь зүйтэй байна.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 16 ДАХЬ ИЛТГЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ГАРГАСАН УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд илтгэлд дурдсан санал, зөвлөмжийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон байна.

Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдлыг тогтоолын заалт тус бүрээр авч үзвэл:

Тогтоолын 1.1 дэх заалт

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгаж, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах арга хэмжээ авах;

Тогтоолын 1.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас ирүүлсэн албан бичигг¹⁹³ дурдсанаар “Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдэхэд 2017 онд 1.2 тэрбум төгрөг, 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 8.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгасан байна.

¹⁹³ Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 3/375 дугаар албан бичиг

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүнд холбогдох журмуудын хэрэгжилтийг хангах, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдэвт бүсийн зөвлөгөөнийг 2018 оны 3–10 дугаар сард 4 удаа зохион байгуулжээ. Тус зөвлөгөөнд сумдын Засаг дарга, цагдаагийн албан хаагчид, нийгмийн ажилтан нийт 305 хүнийг хамруулж, хамтарсан багийн ажлын үр дүнг дээшлүүлэх, хүүхэд хамгааллын тохиолдлыг шийдвэрлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нөлөөлөх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх талаар болон хүчирхийллийн харилцаатай гэр бүл, хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөмжүүдийг өгч ажиллажээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүнд холбогдох журмын хэрэгжилтийг эрчимжүүлж, тайлан мэдээ ирүүлэх тухай 01/433 дугаар албан бичгийг орон нутгийн байгууллагуудад хүргүүлж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний мэдээллийг ГБХОЗ маягтын дагуу сар бүр хүлээн авч нэгтгэн, үр дүнг тооцон ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, журмуудын хэрэгжилтийн байдалтай танилцах, цаашид авах арга хэмжээг төлөвлөх зорилгоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр www.zoom.us цахим сургалтын талбарыг ашиглан 19 аймаг, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дарга, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нийт 106 хүнийг оролцуулан цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Цахим хэлэлцүүлгээс гарсан саналуудыг нэгтгэн салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах, үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, хяналт тавих болон холбогдох журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжүүлэх талаар

санал, мэдээлэл солилцож, энэ талаарх зөвлөмжийг орон нутагт хүргүүлж ажиллажээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 16 аймаг, 5 дүүргийн хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд нь сургаж, чадавхжуулах, сайн туршлага судлах сургалт, уулзалтыг Улаанбаатар хот болон Төв, Архангай, Орхон, Дорнод, Хөвсгөл аймгуудад 2018 оны 4–6 сард зохион байгуулжээ.

Улсын хэмжээнд хамтарсан багууд 2018 онд гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлтэй 2,958 гэр бүлтэй ажиллаж, 2948 хүнд сэтгэл зүйн үйлчилгээ, 784 хүнд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ, 1,253 хүнд нийгмийн халамжийн үйлчилгээ, 2,066 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ, 933 хүнд эмнэлгийн тусламж, 2,511 хүнд эрх зүйн зөвлөгөө өгч, 1,297 хүнд холбон зуучлах үйлчилгээ үзүүлж, тохиолдол шийдвэрлэлт өмнөх онтой харьцуулахад 1.7 хувиар нэмэгдсэн байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн нийт дуудлагын шийдвэрлэлт 77.6 хувьтай хэрэгжсэн гэж Комисст ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна.¹⁹⁴

Тогтоолын уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгаж, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах талаар зарим арга хэмжээг хэрэгжүүлж байна гэж үзлээ.

¹⁹⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 2 дугаар сарын 1–ний өдрийн 3/375 дугаар албан бичиг

Тогтоолын 1.2 дахь заалт

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, шүүхэд сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлал, нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх зэргээр хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах;

Эрүүгийн хуульд¹⁹⁵ биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар, хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр хариуцлагыг чангаруулж тогтоосон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд уг хуулийн төсөлд “Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд

¹⁹⁵ Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

хүрээгүй хүнийг хүчиндсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх”-ээр тусгасан байна¹⁹⁶.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс 2018 оны байдлаар нийт 65 иргэнд хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсний 16 нь насанд хүрээгүй(эрэгтэй-9, эмэгтэй-7) хүн байжээ.

Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас илрүүлсэн мэдээлэлд “Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар; Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар; Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2018 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/37, А/61, А/67 дугаар хамтарсан тушаалаар баталж, хэрэгжүүлж байна гэжээ. Дээрх төлөвлөгөөний гурван зорилтын хүрээнд нийт 28 арга хэмжээг төлөвлөснөөс, 2018 онд 23 арга хэмжээг хэрэгжүүлжээ. Үүнд:

Нэгдүгээрт: цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс дөрөв нь бүрэн хэрэгжиж, дараах хоёр арга хэмжээг 2019 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- а) Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 410 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, батлуулах;

¹⁹⁶ Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 1-4/437 дугаар албан бичиг

- b) Интернет кафе, цахим тоглоомын үйлчилгээний байранд тавигдах шаардлага MNS 6430:2014 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, батлуулах.

Хоёрдугаарт: цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох, эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах зорилтын хүрээнд нийт таван арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хоёр нь бүрэн хэрэгжиж, дараах гурван арга хэмжээг 2019 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна гэжээ. Үүнд:

- a) Хэрэглэгчийн шүүлтүүрийн программыг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, хүүхдэд сөрөг нөлөөтэй, садар самууныг сурталчилсан цахим хуудсуудыг хаасан, эцэг, эхийн хяналттай программ хангамжийг хөгжүүлэх судалгаа хийхээр Харилцаа холбооны зохицуулах хороо төлөвлөж, 2019 онд “Фильтер программ хөгжүүлэх” ажлыг НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр эхлүүлнэ.
- b) Цахим орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах зорилгоор үүрэн холбооны хэрэглэгч, түүний дотор хүүхдийн эзэмшиж, ашиглаж байгаа утасны дугаарыг бүртгэлжүүлэх ажлыг 2018 онд эхлүүлжээ.
- c) Цахим орчны хүүхдэд сөрөг нөлөөтэй контентийг тодорхойлох, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг хийх тогтолцоог боловсронгуй болгох, холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо зохион байгуулан ажиллаж байна.

Гуравдугаарт: цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах зорилтын хүрээнд нийт найман арга хэмжээг төлөвлөж, бүрэн хэрэгжүүлжээ.

2017 оны 12 дугаар сард Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулж, 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр “Орон тооны бус зөвлөл”-ийн ээлжит хурлаар 41 төрийн бус байгууллагад магадлан итгэмжлэл олгосон байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл авсан 19 төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 2018 онд нийт зардлын 70 хувь болох 231,579,623 төгрөгийн санхүүжилт олгожээ.¹⁹⁷ Эдгээр байгууллага нь бэлгийн хүчирхийллийн хохирогч, хараа хяналтгүй, гуйлга гуйж буй, хөдөлмөр эрхэлж байгаа, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа зэрэг хүүхдэд үзүүлэх найман чиглэлийн үйлчилгээнд 397 хүүхдийг хамруулсан байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай байна. Харин шүүхээс гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд учирсан сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг

¹⁹⁷ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/174 дүгээр тушаал

бий болгох, хохирол нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх зэргээр хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх талаарх заалтыг хэрэгжүүлсэн эсэх тухай мэдээлэл ирүүлээгүй болно.

Тогтоолын 1.3 дахь заалт

Өсвөр насны охид бэлгийн харилцаанд эрт орох, хүүхэд төрүүлэх, үр хөндүүлэх, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвдөх нь жилээс жилд нэмэгдэж байгааг онцгойлон анхаарч, энэ чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

Эрүүл мэндийн яамнаас нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартад өсвөр үеийн эрүүл мэндийн кабинет байгуулахаар тусгаж, өнөөгийн байдлаар 27 кабинетад өсвөр үеийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ажиллаж байна¹⁹⁸.

2018 онд Булган, Архангай, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Увс зэрэг аймаг, нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх, Баянгол дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Өсвөр үеийн төв, Оюутны эрүүл мэндийн төвийн Өсвөр үеийн эрүүл мэндийн кабинетийн тусламж, үйлчилгээнд үнэлгээ хийжээ.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/437 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг байгуулж, мөн 224 дүгээр тушаалаар “Өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийн маягт, мэдээлэх журам”-ыг батлан аймаг, нийслэлийн дүүрэг бүр өсвөр насныхны эрүүл мэнд, жирэмслэлт, төрөлт, сэтгэцийн тулгамдсан асуудлуудын талаар мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгожээ.

¹⁹⁸ Эрүүл мэндийн яамны 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2/544 дугаар албан бичиг

Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын 2.4.1.8-д гэр бүл төлөвлөх, эмэгтэйчүүд эсэн мэнд амаржих, эх хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын зорилтын хүрээнд “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлан өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр”-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд баталж, тус хөтөлбөрийг 2018–2019 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү хөтөлбөр нь амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хандлагыг өөрчлөхөд анхаарч оролцооны аргаар хичээлийг зохион байгуулахын зэрэгцээ эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг өрнүүлэхийг чухалчилсан байна. Тус сургалтын хөтөлбөрт нийцсэн сурах бичгийг 2019 онд боловсруулах зорилгоор 2009–2015 онд ашиглаж байсан эрүүл мэндийн боловсролын сурах бичгүүдэд үнэлгээ шинжилгээ хийж, шинэчилсэн хөтөлбөрт нийцүүлэн сайжруулах талаар санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/62 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байгаа ажээ.

Мөн халдварт өвчнөөс сэргийлэх, хүний дархлал хомсдлын вирус, дархлалын олдмол хомсдол, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дунд, ахлах ангийн эрүүл мэнд, биологи болон химийн сургалтын цөм хөтөлбөрт тусгаж, ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн 2018–2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөний 1.2.2, 1.2.3-т заасан “Өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжиж, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх”; “Нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг аймаг, дүүргийн түвшинд бэхжүүлэх”; “Өсвөр үеийн кабинетийн эмч нарын нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнд 2018 онд 11.5 сая төгрөг зарцуулжээ.

Өсвөр насны охид эрт бэлгийн харилцаанд орох, хүүхэд төрүүлэх, үр хөндүүлэх, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвдөх нь жилээс жилд нэмэгдэж байгаад эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн эрхийн чиглэлээр ажиллаж буй байгууллагууд онцгойлон анхаарч салбар дундын уялдаа холбоог хангаж, тодорхой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тогтоолын 1.4 дэх заалт

Баян–Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг төрийн албан ёсны хэл дээр явуулах;

Боловсролын хүрээлэнгээс 2013, 2017 онд хийсэн Баян–Өлгий аймгийн багш нарын монгол хэлний сургалтыг тандах судалгааны дүнг харьцуулан үзэхэд багш нарын монгол хэлний гүйцэтгэл буурсан, монгол хэлний мэдлэг маш доогуур хувьтай, ялангуяа унших чадварын сорил 10 хувиар буурсан байна. Иймд багш нарын монгол хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлж, улмаар багшлах арга зүйг хөгжүүлэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр сургалтын хөтөлбөр боловсруулсан байна.

Хөтөлбөрийн үр дүнд Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нарын монгол хэлээр ярих, өөрийгөө илэрхийлэх чадвар дээшилж, сургалтын чанар сайжрах нөхцөл бүрдэнэ гэсэн мэдээллийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас ирүүлжээ.

Дээрх мэдээллээс үзэхэд Хууль зүйн байнгын хорооны тогтоолд заасан Баян-Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг төрийн албан ёсны хэл дээр явуулах нөхцөл, боломж өнөөг хүртэл бүрдээгүй байна.

Тогтоолын 1.5 дахь заалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг хангах үүднээс Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын барилга байгууламжийг шинэчлэн ашиглалтад оруулах, төсөв, хөрөнгийг шийдвэрлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувиллын цогцолбор гэх хуулийн нэр томъёог өөрчлөн Баянзүрх дүүргийн сувиллын цэцэрлэг, яслийн барилга хэмээн өөрчлөн 2019 онд 5.7 тэрбум төгрөгөөр улсын төсөв батлагдсан ба одоогоор барилгын 1 ба 2 давхрын ханын цутгалтын ажлыг гүйцэтгэж байгаа ба энэ оны 9 сард ашиглалтад оруулахаар “Алтан булаг трейд” ХХК гэрээтэй ажиллаж байна гэсэн мэдээллийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас ирүүлсэн байна.

Тогтоолын 1.6 дахь заалт

Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүднээс Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн холбогдох заалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэх;

Улсын хэмжээнд 2018–2019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд төрийн өмчийн 889, хувийн өмчийн 546, нийт 1,435 цэцэрлэгт 261,354 хүүхэд хамрагдаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 1,087 хүүхэд байна. Цаашид сургуулийн өмнөх боловсролд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургахдаа хүүхдийн ялгаатай хэрэгцээг хүндэтгэсэн, хөгжих, сурах онцлогийг дэмжсэн сургалтын орчин, тохируулгат хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, багшийн арга зүйг сайжруулах, бүлэг дүүргэлтийн нормативт тоог баримтлан ажиллана¹⁹⁹ гэсэн мэдээллийг ирүүлсэн байна.

Энэхүү мэдээллээс харахад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны холбогдох албан тушаалтнууд Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 02 тоот тогтоолын 1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна. Учир нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд “...Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэгт “...хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно” гэж ердийн цэцэрлэгт зөвхөн хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цөөн тоотойгоор суралцах боломжтой байхаар тогтоосон нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 7 дугаар зүйлийн 1–д “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний

¹⁹⁹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 2 дугаар сарын 15–ны өдрийн 2/1087 дугаар албан бичиг.

бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.”, 24 дүгээр зүйлийн 1–д “Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө.” гэсэн заалттай зөрчилдөж байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхаж, бусад хүүхэдтэй адил тэгш сурах болон харилцах нөхцөл боломжийг хязгаарлаж байгаа тул сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүднээс дээрх хуулийн холбогдох заалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэх нь зүйтэйг энд дахин дурдаж байна.

Тогтоолын 1.7 дахь заалт

Төрийн болон хувийн өмчийн тусгай хэв шинжтэй цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, ажилтанд ажлын байрных нь чиг үүргээс хамаарч албан тушаалын үндсэн цалингийнх нь 10–30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгох асуудлыг шийдвэрлэх;

Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар “Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу албан тушаал (үндсэн)-ын цалингаас дор дурдсан хувиар бодож нэмэгдэл хөлс олгож байна. Үүнд:

- тусгай цэцэрлэгийн арга зүйч, багш, согог зүйч, туслах багш, сэргээн засалч, эмч, сувилагч, жолооч, асрагчид албан тушаал (үндсэн)-ын цалингийн 30 хүртэл хувиар;
- цэцэрлэгийн эрхлэгч, үйлчилгээний алба хаагчдад албан тушаал (үндсэн)-ын цалингийн 20 хүртэл хувиар захиргааны гүйцэтгэх албан тушаалын болон үйлчилгээний бусад албан хаагч (үндсэн)-

дад цалингийн 10 хүртэл хувиар тус тус олгохоор журамлан хэрэгжиж байна” гэжээ²⁰⁰

Тогтоолын 1.8 дахь заалт

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилалд байнга асруулж, сувилуулж байгаа хүнд хэлбэрийн болон давхар хөгжлийн бэрхшээлтэй нийт 34 хүүхдийг Өнөр бүл хүүхдийн төвийн харьяанд шилжүүлэх, тухайн байгууллагыг мэргэжлийн хүний нөөцөөр бүрэн хангах, бүтэц, орон тоог нь нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 11,453 хүүхэд бүртгэгдэж, өмнөх оноос 729-өөр өссөн үзүүлэлттэй байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон асрамж, халамжийн төвүүдэд байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хагас, бүтэн өнчин, асран хамгаалагчгүй 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй 80 хүүхэд амьдарч байна.

“Өнөр бүл” хүүхдийн төв болон бусад асрамж, халамжийн төвд 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 76 хүүхэд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн асрамжийн клиникт байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, сэтгэцийн өвчтэй асран хамгаалагчгүй 8-17 насны 1 эмэгтэй, 3 эрэгтэй нийт 4 хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Хүүхдийн төв сувиллын Сэргээн засах амбулаторийн тасагт эмчлүүлж байсан 12 настай Т.С-ыг 2017 оны 4 дүгээр сард “Өнөр бүл” хүүхдийн төвд, 16 настай Б.Б-г Төв аймгийн Батсүмбэрийн ахмадын асрамжийн төвд шилжүүлснээр²⁰¹ Хүүхдийн төв

²⁰⁰ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 2/1087 дугаар албан бичиг.

²⁰¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн №1/417 дугаартай албан бичиг

сувилалд хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байх шаардлагатай 6 хүүхэд сувицуулж байна²⁰²

Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах хүрээнд улсын болон хувийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 6 цэцэрлэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Цаашид эдгээр хүүхэд, залууст байнгын асрамж, халамж, дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх нөөц боломжийг судалж, шийдвэрлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран ажиллаж байна²⁰³ гэжээ.

“Өнөр бүл” хүүхдийн хөгжлийн төвийн дэргэд сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрамж, халамжийн төвийн барилга барихад шаардагдах 3 тэрбум төгрөгийг шийдвэрлэх Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэл гарч, 2019 оны төсөвт тусгуулах саналаа хүргүүлсэн боловч Сангийн яамнаас хассан²⁰⁴ тухай Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн албан бичигт дурдсан байна.

“Өнөр бүл” хүүхдийн төв нь 2017 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хөдөлгөөн засалч нэмж ажиллуулсан, мөн хэл засалч шаардлагатай байгаа боловч мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байх тул боловсон хүчнийг бэлтгэхэд анхааран ажиллаж байна.

²⁰² Эрүүл мэндийн яамны 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2/544 дугаар албан бичиг

²⁰³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 3/375 дугаар албан бичиг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 01/71 тоот албан бичиг

²⁰⁴ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 01/71 тоот албан бичиг

Тогтоолын 2.1 дэх заалт

Хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, ажилтны үндсэн эрх, зарим нэр томъёог Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж, нийгэм, эдийн засгийн өнөөгийн чиг хандлагад нийцүүлэн Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Засгийн газраас 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуулийн хамт Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн байна.

Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг өргөтгөн хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинж бий болсон үеэс хөдөлмөрийн харилцаа үүссэнд тооцож, хөдөлмөрийн хууль тогтоомж үйлчлэхээр төсөлд тусгасан.
2. Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөр эрхлэлтийн харилцааны суурь хэм хэмжээг тогтоож, хууль тогтоомжид заасан стандарт зохицуулалтыг дээшлүүлэх, бусад хөдөлмөр, нийгмийн асуудлыг аж ахуйн нэгж, байгууллага дотроо буюу ажил олгогч ажилтан, түүний төлөөлөгчид харилцан зөвшилцөхөөр зохицуулсан.
3. Ажил олгогч болон ажилтны хуулиар хамгаалагдах эрх, хүлээх үүргийг тэнцвэржүүлэх зорилгоор хуулийн төсөлд ажилтны хөдөлмөрийн харилцаан дахь суурь эрхийг заахаас гадна ажил олгогчийн өмнө зайлшгүй хүлээх үүргийг заасан.
4. Олон улсын хөдөлмөрийн суурь эрх болох эвлэлдэн нэгдэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хүүхдийн

хөдөлмөрийг хязгаарлах, хөдөлмөрийн харилцаанд дарамтыг хориглох, албадан хөдөлмөрийг хориглохтой холбоотой зохицуулалтуудыг нарийвчлан тусгасан.

5. Цалин хөлсний зохицуулалтын хувьд ажилтны цалин хөлсийг ажлын байр, ажилтны ур чадвар, мэргэшлийн зэрэгтэй нь уялдуулан олгох, мэргэшлийн зэргийг улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх тогтолцоог бий болгох, түүнчлэн бүтэн бус цагаар ажиллах ажилтны цалин хөлс, ээлжийн амралт зэрэг зохицуулалтыг тусгасан.
6. Уул уурхай, ашигт малтмал олборлолтын салбарт гэрээсээ алслагдмал газар тогтмол хугацаанд ажил, үүрэг гүйцэтгэх ажилтны ажил, амралтын цагийг тусгайлан зохицуулсан байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 138, 182 дугаар конвенцод нийцүүлэн хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тодорхойлж, 15 нас хүрээгүй хүүхдийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч буюу эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр гаргасан зөвшөөрлөөс гадна ажлын цаг, хөдөлмөр эрхлэлтийн талаар хүүхдийн эрхийн байцаагчаас зөвшөөрөл авахаар тусгасан. Түүнчлэн суурь боловсрол эзэмших настай нийцүүлж хүүхдийн хөдөлмөр эрхлэх насыг 15 нас болгон өөрчилсөн. Хуулийн төсөлд хүүхдээр хөнгөн ажил эрхлүүлэх насыг тодорхойлж, 13 нас хүрсэн хүүхдийн эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар шинэ зохицуулалт нэмжээ.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 100, 111 дүгээр конвенцтэй нийцүүлэн дараах асуудлыг тусгажээ.

1. Ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглохтой холбоотой

зохицуулалтыг сайжруулж, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, жирэмсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, улс төрийн үзэл бодол зэрэг шинжээр ялгаварлан гадуурхахыг хориглох;

2. Ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцаанд дарамтыг хориглох;
3. Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 29, 105 дугаар конвенцод нийцүүлэн албадан хөдөлмөрийн тодорхойлолтыг шинэчилжээ.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан тул уг заалтын хэрэгжилт хангагдсан байна.

Тогтоолын 2.2 дахь заалт

БНМАУ-ын 1991 онд баталсан Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Комисст ирүүлсэн албан бичигт Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг 2019–2020 онд хийхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна гэжээ.

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг одоог хүртэл байгуулаагүй, хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулаагүй байна.

Тогтоолын 3.1 дэх заалт

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг нэн даруй бий болгож, төсөв, орон тоог шийдвэрлэх;

Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Уг төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж буй төсөлд Комиссын бүтцэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий хараат бус гишүүн, бие даасан нэгжийг ажиллуулахаар тусгажээ.

Тогтоолын 3.2 дахь заалт

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар, үр дүнтэй мөрдөн шалгах байгууллагыг байгуулах, бүтэц, орон тоог шийдвэрлэх;

Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харъяалал тогтоох тухай” журмаар “Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Авлигатай тэмцэх газарт”, “Цагдаа, Авлигатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Тагнуулын ерөнхий газарт”, “Шүүх, Прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөх хэлтэст”,

“Тагнуулын байгууллагын алба хаагчийн Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн алба” шалгах аар тус тус харьяалал тогтоосон байна.

Энэ нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар, үр дүнтэй мөрдөн шалгах оновчтой шийдвэр биш бөгөөд мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд буюу Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын мөрдөн шалгах хэлтсийн албан хаагчид харилцан бие биеэ шалгаж байгаа нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үр дүнтэй шалган шийдвэрлэх, эрүү шүүлтийн далд, нуугдмал хэлбэрүүдийг илрүүлж, хариуцлага тооцох боломжийг бүрдүүлж чадахгүй тул тогтоолын энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Тогтоолын 4.1 дэх заалт

Жендэрийн асуудал нь нийгмийн бүх салбарыг хамарсан цогц асуудал тул салбар дундын жендэрийн асуудлыг зохицуулах бие даасан үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх үүднээс Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг бие даасан бүтэцтэйгээр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;

Жендэрийн үндэсний хорооны 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит хуралдаанаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангахад тус хороо, түүний Ажлын албаны статус, бүтэц, зохион байгуулалтыг илүү оновчтойгоор өөрчлөх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байна. Улмаар Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн ам, хөгжлийн газарт харьяалагдаж байсныг өөрчилж, Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэсэн

байна.

Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 285 дугаар тогтоолоор тус хорооны Ажлын албаны орон тоо дөрөв байсныг найм болгон нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа бие даан явуулах боломж бүхий ажлын байр, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэжээ. Улсын Их Хурлаас Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2019 оны жилийн төсвийг 706.8 сая төгрөгөөр баталсан²⁰⁵ байна.

Засгийн газраас Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны үйл ажиллагааг зохих түвшинд дэмжиж, ажлын байр, хүний нөөц, үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн тул тогтоолын заалт хэрэгжсэн байна.

Тогтоолын 4.2 дахь заалт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний шинэ хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн А/132 тоот тушаалаар Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг (2017–2021) баталсан байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны улсын төсөвт 300 сая төгрөг, 2018 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад 127.5 сая төгрөгийг тус тус баталжээ. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Жендэрийн үндэсний хорооны²⁰⁵ Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын албаны 2018 оны үйл ажиллагааны хураангуй тайлан, 2019 он

Ажлын албаны санаачлага, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2018 онд Азийн хөгжлийн банкны 597.2 сая төгрөгийн санхүүжилт бүхий “Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” төсөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн 281.6 сая төгрөгийн санхүүжилт бүхий “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Тогтоолын 4.3 дахь заалт

Жендэрийн эрх тэгш байдал нь жендэрийн тэгш байдал гэсэн ойлголтын нэг хэсэг тул уг хуулийн нэрийг “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль” гэж өөрчлөх асуудлыг судалж, холбогдох журмын дагуу шийдвэрлэх;

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах асуудлыг судлах чиглэлээр холбогдох төрийн, төрийн бус байгууллагын төлөөлөл, судлаачдыг оролцуулсан ажлын хэсэг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна²⁰⁶ гэсэн мэдээллийг Жендэрийн үндэсний хорооноос ирүүлжээ. Иймд тогтоолын уг заалт хэрэгжээгүй байна.

Тогтоолын 4.4 дэх заалт

Төр, захиргааны байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл гаргадаг байх журмын зохицуулалтыг хуульд шинээр тусгах.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-д “Төрийн захиргааны төв болон

²⁰⁶ Жендэрийн үндэсний хорооны 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 3/017 тоот албан бичиг

нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх”, мөн зүйлийн 19.1.9-т “Төрийн захиргааны төв байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилтийн тайланг аймаг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дараа оны 02 дугаар сарын 20 ны дотор Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх”-ээр тус тус заасан байдаг. Үүний дагуу дээрх байгууллагуудаас Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанд тайланг ирүүлж байгаа боловч тайлагналтын явц жилээс жилд буурах хандлагатай байна. Тухайлбал, 2016 онд 11 салбар зөвлөл, 29 салбар хороо, 29 Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын алба тайлангаа ирүүлж, гүйцэтгэл 94.7 хувьтай байсан бол 2017 онд 13 салбар зөвлөл, 29 салбар хороо, 19 Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын алба тайлангаа ирүүлж, гүйцэтгэл 81.3 хувьтай, мөн 2018 онд 13 салбар зөвлөл, 30 салбар хороо, 12 Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын алба тус тус тайлангаа ирүүлж, гүйцэтгэл 73.3 хувьтай болж буурчээ²⁰⁷

Дээрх үзүүлэлт буурахад аймаг, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тайлангийн ирц голлон нөлөөлжээ. Иймд Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч, илүү хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай байна.

²⁰⁷ Жендэрийн үндэсний хорооны 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 3/017 тоот албан бичиг

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2017 оны 12/28 дугаар тогтоолоор байгуулагдсан хамтарсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Тогтоолын 1 дэх заалт

Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомж шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар уг хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын санаачлан боловсруулсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамтатган боловсруулахаар шийдвэрлэжээ. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөл бэлтгэж хүргүүлсэн байна.²⁰⁸

Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл багтсан байна.

²⁰⁸ Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 1-1/437 дугаар албан бичиг.

Тогтоолын 2 дахь заалт

Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх хүндрэлтэй байдал үүсэж байгаа тул дээрх хуулиудын зарим зүйл, заалт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэхийг судалж, шийдвэрлэх;

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/243 дугаар тушаалаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хүлээлгэх торгох ялын хэмжээг нэмэгдүүлэхээр тусгасан байна.²⁰⁹

Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2018 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 5–9 дүгээр зүйлд заасан хүүхэд хамгааллын асуудлууд, албан бус сектор дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх зөрчлийг шалган шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тодорхой болгох саналыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүргүүлсэн байна. Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулснаар гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал, албан бус салбар дахь хүүхдийн эрхийн нийт 84 зөрчлийг шалган шийдвэрлэх боломжтой болно²¹⁰ гэжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн мэдээлэлд

²⁰⁹ Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 1-1/437 дугаар албан бичиг.

²¹⁰ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн О1/71 дүгээр албан бичиг.

Эрүүгийн болон Зөрчлийн хуулиудад оруулж буй дээрх зүйл, заалтууд нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байгаа эсэх талаар дурдаагүй байна.

Тогтоолын 3 дахь заалт

Хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх асуудлыг зохицуулсан журмыг хүчингүй болгож уг асуудлыг Гэр бүлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг хуулийн төслийн хүрээнд хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх асуудлыг тусгах эсэх асуудлыг судалж байгаа талаар Комисст ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна.²¹¹

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/186 тушаалаар Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах салбар дундын ажлын хэсэг байгуулагдаж, хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэх асуудлыг журмаар зохицуулж байсныг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулахаар шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан байна. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтож, Засгийн газрын 51 дүгээр тэмдэглэл гарчээ.²¹²

²¹¹ Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 1-1/437 дугаар албан бичиг.

²¹² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 3/375 дугаар албан бичиг.

Тогтоолын 4 дэх заалт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14, 16 дугаар зүйлд заасан дүрэм, журмыг баталж, чиг үүргээ биелүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөж, ажиллах;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”²¹³, “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”²¹⁴, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”²¹⁵-ыг тус тус баталсан байна.

“Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”-д цэцэрлэг, сургууль, дотуур байрны сургалтын болон амьдрах орчны аюулгүй байдлыг хангахын тулд сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүү, хяналт шинжилгээ, үнэлгээнд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэхийг заажээ. “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”-д сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг

²¹³ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/239 дүгээр тушаал.

²¹⁴ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/476 дугаар тушаал.

²¹⁵ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/612 дугаар тушаал.

хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлэхээр тусгаж, тусгайлан мэдээлэл хүлээн авах журам боловсруулж, мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.²¹⁶

Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх агуулгыг Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт 4 цагаар (1 удаа) тусгаж, 2018 онд 125 сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны 73 багшид, 2019 оны 1 дүгээр улиралд 50 сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны 33 багшид тус тус сургалт зохион байгуулжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан чиг үүргийн хүрээнд монгол ахуй, монгол өв соёлыг өвлүүлэх, гэр бүлийн тэнцвэрт харилцааг харуулсан дөрвөн уран бүтээлд Соёл, урлагийг дэмжих сангаас 130 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Төрийн өмчийн соёл, урлагийн байгууллагын дарга нарын үр дүнгийн гэрээнд хүчирхийллийг сурталчилсан агуулга бүхий аливаа уран бүтээл туурвихгүй байх заалт тусгаж, хяналт тавин ажиллаж байна” гэжээ.

Тогтоолын 5 дахь заалт

Эрүүл мэндийн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар

²¹⁶ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 2/1087 дугаар албан бичиг.

зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2018 оны 480 дугаар тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, ажилтан бүр хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн бэртэл, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, цагдаа болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт мэдээлэх, нууцыг хадгалах тогтолцоог бүрдүүлсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/440 дугаар тушаалаар Хүүхдийн эрүүл мэнд, эрх, хөгжил хамгааллын асуудлаарх эрүүл мэндийн салбар дахь ажлын хэсэг байгуулжээ.

Түүнчлэн Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Нэг цэгийн үйлчилгээний төвд 20 сая, нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд 19.8 сая, Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг дэх Нэг цэгийн үйлчилгээний төвд 20 сая төгрөгийг хүчирхийллийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, чадавхыг бэхжүүлэхэд зарцуулахаар шийдвэрлэжээ.²¹⁷

Тогтоолын 6 дахь заалт

Олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллага Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах асуудлыг тусгах, хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхийг хориглосон заалтыг чанд мөрдөж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргээ биелүүлж ажиллах;

²¹⁷ Эрүүл мэндийн яамны 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2/544 дүгээр албан бичиг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн ХЭГ/421 дугаартай албан бичиг болон холбогдох яам, агентлагаас ирүүлсэн мэдээлэлд тогтоолын 6 дахь заалтыг хэрэгжүүлсэн эсэх тухай мэдээллийг Комисст ирүүлээгүй тул уг заалтын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

Тогтоолын 7 дахь заалт

Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагын эрүүл мэндийн ажилтнууд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах, мөн нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах үйл ажиллагаа зохион байгуулах;

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн мэдээллийг бүртгэх үндэсний сүлжээнд Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Нэг цэгийн үйлчилгээний бүртгэлийг нэгтгэж, мэдээллийн бүртгэлийн шинэчлэл хийжээ. Мөн эрүүл мэндийн салбарт хөтлөгдөж буй тайлангийн маягтыг нөхөх зааврын хамт шинэчлэн боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/198 тушаалаар батлуулсан нь хүчирхийллийн шалтгаан, үр дагавар, хүчирхийллийн хэлбэр, насны бүлгээр тайланг тодорхой гаргах боломж бүрдсэн байна.

2017–2018 онд зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” Үндэсний чуулганд эрүүл мэндийн байгууллагын дарга нар оролцож, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар уриалга гарган ажиллаж байгаа талаар Эрүүл мэндийн яамнаас²¹⁸ ирүүлсэн мэдээлэлд дурджээ.

²¹⁸ Эрүүл мэндийн яам 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2/544 дүгээр албан бичиг.

Тогтоолын 8 дахь заалт

Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах;

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2017, 2018 онд бүх шатны Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, ялангуяа Хүүхэд хамгааллын хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, хүүхдийн ордон, хөгжлийн төвгүй аймгуудад орон нутгийн төсөв хөрөнгөөр хүүхдийн ордон барьж байгуулах, хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах боломж, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах чиглэлээр санал, зөвлөмж өгч ажиллажээ. 2018 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, 336 сум, 152 хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгууллаа. Мөн 609 хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлыг 2017–2018 онуудад зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна гэжээ.

“Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 01 дүгээр албан даалгавар гарч, хэрэгжилтийг хангах чиглэлээр арга зүйн зөвлөмж, чиглэл өгч, 2018 оны 4 дүгээр улиралд тайланг нэгтгэн боловсруулж Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 оны 12 дугаар сард аймаг, нийслэл дүүргийн засаг дарга нар, Эрүүл мэнд, Боловсрол, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтэс, Цагдаагийн байгууллагын удирдах ажилтан нийт 800 хүний бүрэлдэхүүнтэй “Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн” зохион байгуулж, 5 салбар хуралдаанаас гарсан зөвлөмжийг нэгтгэн салбар яамдад танилцуулж хэлэлцүүлсэн, улмаар 2019 оны төлөвлөлтөд зарим үйл ажиллагааг тусган ажиллаж байна гэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн мэдээлэлд дурджээ.

Тогтоолын 9 дэх заалт

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, гэмт хэргийн тоо улсын хэмжээнд нэгдсэн байдлаар гардаг мэдээллийн санг бий болгож системчлэх, гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаар нэгдсэн мэдээлэл, судалгаатай байх;

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, гэмт хэргийн тоог Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/145 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-ын дагуу мэдээлэл, судалгааг улсын хэмжээнд нэгтгэж байна.²¹⁹

²¹⁹ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 01/71 дүгээр албан бичиг.

Цагдаагийн ерөнхий газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэл” (EGBV) төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл, өргөдөл, гомдол, захиргааны зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийг нэгтгэж нэгдсэн судалгаа, лавлагаа хийх боломжтой мэдээллийн сан бүрдүүлсэн байна. Цагдаагийн байгууллагын дуудлага мэдээллийн E.C.S–Emergency Call System буюу Дуудлага мэдээллийн програм хангамж нь 102 тусгай дугаарт ирсэн дуудлага, мэдээллийг харьяа дүүрэг дэх Цагдаагийн газарт цахим хэлбэрээр шилжүүлэх, улсын хэмжээнд дуудлага, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зорилгоор боловсруулагдсан байна. ECS програм хангамж нь дуудлага, мэдээллийг 12 төрлөөр ангилан бүртгэж шийдвэрлэхдээ холбогдогчид авсан арга хэмжээ, зан байдал, үйлдсэн хэлбэр, овог, нэр, регистр, утасны дугаар, хаяг, хохирогчид авсан арга хэмжээ, зан байдал, аюулын зэргийн үнэлгээ, хохирогч хүүхдийн тухайд авсан арга хэмжээ, овог, нэр, регистр, утасны дугаар, хаяг зэргээр төрөлжүүлэн бүртгэдэг болжээ.

Нийслэлийн төвийн зургаан дүүргийн эргүүлийн 62 чиглэлд хөдөлгөөнт төхөөрөмж байршуулж дуудлага, мэдээллийг хүлээн авч, газар дээрээс нь шийдвэрлэлтийг мэдээллийн санд оруулдаг болсноор тухайн дуудлага өгсөн утаснаас өмнө өгч байсан дуудлага, мэдээллийн түүх, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг цагдаагийн алба хаагчид шууд харах боломжтой болжээ.

Тогтоолын 10 дахь заалт

Бага насны хохирогч хүүхдийн эрхийг хамгаалахад мэргэшсэн өмгөөлөгч, нарийн мэргэшсэн шүүхийн шинжилгээний шинжээч, хүүхдийн асуудал хариуцсан мөрдөгч ажиллуулах;

Гэмт хэрэгт өртөж хохирсон бага насны хүүхдийн асуудал хариуцсан мөрдөгч гэсэн орон тоо одоогийн байдлаар цагдаагийн байгууллагын бүтцэд байхгүй байна. Гэхдээ бага насны хүүхэд өртөж хохирсон, холбогдсон гэмт хэргийг нэг мөрдөгчөөр дагнан шалгуулж байна. Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс бага насны хүүхдэд үзлэг, шинжилгээ хийх шинжээч эмчийг 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс томилон ажиллуулж байгаа бол²²⁰ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2019 оноос эхлэн бага насны хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 15 өмгөөлөгчийг мэргэшүүлэн ажиллуулж байна.

Тогтоолын 11 дэх заалт

Төлбөрийн чадваргүй хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар байгуулагдсан байна. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төлбөрийн чадваргүй хохирогчид өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх талаар тодорхой зохицуулалтуудыг оруулсан бөгөөд хуулийн төсөлд холбогдох байгууллагаас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна гэж Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна. Гэвч дараах тоон мэдээллээс үзэхэд төлбөрийн чадваргүй хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлээгүй байна.

²²⁰ Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 1-1/437 дугаар албан бичиг

Хүснэгт 22.

	2014	2015	2016	2017	2018
	ОН	ОН	ОН	ОН	ОН
Зөвлөгөө өгсөн иргэдийн тоо	7351	8363	6631	6659	12770
Хүлээн авсан хэргийн тоо	1891	2888	2482	2687	2749
Холбогдогчийн тоо	2102	3145	2749	2904	3003
Сэжигтний тоо	1057	1936	1682	1720	1896
Яллагдагчийн тоо	201	254	170	130	131
Шүүгдэгчийн тоо	844	955	897	1054	971
Ялтны тоо	-	-	-	-	5

Тогтоолын 12 дахь заалт

Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил залгаа аймаг болох Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумдын Цагдаагийн хэлтсийн бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөх, орон тоог нэмэгдүүлэх, дээрх сумдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр бүрэн камержуулах;

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/197 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 8 албан хаагчийн орон тоотой Цагдаагийн хэсэг шинээр байгуулж, мөн даргын А/37 дугаар тушаалаар Дорноговь аймаг дахь Цагдаагийн газраас Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, зохицуулагчийн орон тоог тус тус нэгээр нэмэгдүүлсэн байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр Замын-Үүд суманд 38.9 сая төгрөгийн 41 ширхэг, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2.3 сая орчим төгрөгийн үнэтэй нэг ширхэг камерыг тус тус суурилуулжээ.

Тогтоолын 13 дахь заалт

Хүний эрх, хүүхдийн эрхийн боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх;

Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангид 2017–2018 оны хичээлийн жилд “Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох” сургалтыг дараах хөтөлбөрөөр зохион байгуулжээ. Үүнд:

- Бага ангид “Хүн ба нийгэм”, “Хүн ба орчин”, “Иргэний боловсрол” хичээл, мөн амьдрах чадварт суралцах болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг;
- Дунд, ахлах ангид “Түүх”, “Нийгмийн ухаан”, “Иргэний боловсрол” хичээл, мөн амьдрах чадварт суралцах болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг.

Дунд, ахлах ангийн сурагчид нийгмийн ухааны хичээлээр “Хувь хүн ба нийгэм”, “Нийгмийн харилцаа, хувь хүн” “Хувь хүн ба соёл”, “Хүний эрх ба хууль” бүлэг сэдвийн хүрээнд зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох, хууль, эрх зүйн мэдлэг, чадвартай болж, гэмт хэрэг, хүчирхийлэл, тэдгээрийн хор уршгийг танин мэдэж, түүнээс урьдчилан сэргийлэх дадал, хэвшлийг эзэмшдэг²²¹ гэжээ. Бага, дунд, ахлах ангийн амьдрах чадварт суралцах болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар орон нутгийн амьдрал, үйл ажиллагаанд гарсан хүний гэм буруутай үйлдэл, хүчирхийлэл, тэдгээрт хариуцлага хүлээлгэсэн тохиолдлуудад ажиглалт, шинжилгээ хийж, нотлон тайлбарлах дадлага ажил хийлгэдэг байна.

²²¹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 2/1087 дугаар албан бичиг.

Мөн ерөнхий боловсролын сургуулиуд суралцагчдыг хараа хяналтгүй орхихгүй байх нөхцөлийг хангаж ажиллах, хүчирхийлэл, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд хүүхэд өртөхөөс сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагч, орон нутгийн иргэдтэй хамтарч ажиллах талаар жилийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Сурагчдыг хууль, эрх зүйн мэдлэг, чадвартай болгох, гэмт хэрэг, хүчирхийлэл, тэдгээрийн хор уршгийг таньж мэдэх, хүчирхийллээс өөрсдийгөө урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сайн дурын клубууд ажиллуулж байна гэсэн мэдээллийг ирүүлсэн байна.

Гэтэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2018 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн А/453 тушаалын 3 дугаар хавсралтаас харахад ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг хасагдсан байна.

Тогтоолын 14 дэх заалт

Төрийн бүх шатны байгууллага болон аж ахуйн нэгжид хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн зэрэг арга, гэр бүлийн харилцаа зэрэг сэдвүүдээр мэдээлэл, сургалтыг тогтмол зохион байгуулах;

Гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн ОЗ дугаар тогтоолоор Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг батлах, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмжийг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр батлуулсан байна.

Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бие махбодын болон сэтгэл санааны шийтгэлийг бууруулахад эцэг эх, олон нийтийн эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе” сэдэвт лекцийг 1,748 удаа зохион байгуулж, түүнд 205,444 хүн, хүмүүжлийн эерэг аргын сургалтад 18,078 багш сурган хүмүүжүүлэгч, 114,583 эцэг эх хамрагджээ. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсээс хүмүүжлийн чанартай ганцаарчилсан зөвлөгөөг 12,086 хүнд өгч, бүлгийн зөвлөгөөнд 5,162 гэр бүл хамрагдсан байна. Мөн “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтын модуль, сургагч багшийн гарын авлага боловсруулж, 350 үндэсний сургагч багш, 1,177 чиглүүлэгч багш, 50 лектор бэлтгэгджээ.

Тогтоолын энэ заалтын хэрэгжилтийг хангахад салбар дундын уялдааг ханган үр дүнтэй арга хэмжээг авч ажилласан байна.

Тогтоолын 15 дахь заалт

Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хамтарсан багийн бүрэлдэхүүнд ерөнхий боловсролын сургуулийн захирлыг нэмж оруулах;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/328 дугаар тушаалаар “Хамтарсан багийн ажиллах журам”-ыг баталсан байна. Гэвч хамтарсан багийн бүрэлдэхүүнд ерөнхий боловсролын сургуулийн захирлыг нэмж оруулах эсэх талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл ирүүлээгүй байна.

Тогтоолын 16 дахь заалт

Хүүхдийн аюулгүй, халдашгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхдийн асрамж, халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн байр, мөрдөн байцаалтын өрөө, саатуулах болон цагдан хорих байр, хорих ангид хууль тогтоомжид нийцүүлэн камерын хяналтын системийг бүрэн нэвтрүүлэх;

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд хүүхдийн аюулгүй, халдашгүй байдалд хяналт шалгалт хийхэд дараах нөхцөл байдал илэрчээ. Үүнд:

- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, “СОС” хүүхдийн хотхон, Эрдэнэт хот дахь Энэрэл төв, Манаа төв, Арцат модон өргөө, Цөлийн сарнай гэсэн хүүхдийн асрамж, халамжийн байгууллага 100 хувийн камержуулалттай;
- Есөн төв нь 60–80 хувийн камержуулалттай;
- Өнөр бүл төв нэг камертай;
- Бадамлянхуа төв, Монголын хүүхдийн сан, Манай гэр бүл, Эрдэм хүүхдийн төв, Дорнод аймаг дахь Анна хоме зэрэг байгууллагууд огт камержуулалтгүй.²²²

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2017–2018 онд хүүхдийн аюулгүй, халдашгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн байранд хууль тогтоомжид нийцүүлэн камерын хяналтын системийг бүрэн нэвтрүүлэх зөвлөмжийг 31 халамж, асрамжийн төвд, 21 аймгийн

²²² Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 1/71 дүгээр албан бичиг.

Нийгмийн бодлогын хэлтсүүдэд хүргүүлж, 31 асрамж, халамжийн төвд хяналт тавьж ажилласан байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 874 цэцэрлэгийн гадна, дотор талд 7,046 камер байршуулсан, нийт 7,808 бүлгийн 5,500 гаруй бүлэгт камер суурилуулснаар нийт бүлгийн 71.5 хувь нь камерын хяналтад хамрагдсан байна. 2018–2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн 656 ерөнхий боловсролын сургуулийн 50 орчим хувь нь гадна орчиндоо, 80 орчим хувь нь дотоод орчиндоо камер суурилуулжээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас ерөнхий боловсролын сургуулийн гадна болон дотоод орчинд шаардлага хангасан хяналтын камер байрлуулах асуудлыг Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандартын төсөлд тусгайлан оруулж, батлуулахаар Стандарт, хэмжилзүйн газарт хүргүүлсэн байна.²²³

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд 2018–2019 оны хичээлийн жилд 74 их, дээд сургууль, 516 ерөнхий боловсролын сургуулийн гадна талд байрлуулсан 456, дотор талд байрлуулсан 1,260, нийт 1,716 хяналтын камерт үзлэг шалгалт хийж, 89 камерын чиглэлийг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй байрлал руу харуулан өөрчлүүлж, 516 хяналтын камерыг стандартад нийцсэн камераар солих талаар зөвлөмж өгч ажиллажээ.²²⁴

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 17 дахь хэсэгт, Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 оны А/57 тушаалаар батлагдсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн

²²³ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 2/1087 дугаар албан бичиг.

²²⁴ Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 1-1/437 дугаар албан бичиг.

яамнаас 166 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, цагдаагийн ЗО байгууллагад “Хүүхдээс мэдүүлэг авах өрөө”-г камержуулж тогтоолын заалтыг хэрэгжүүлсэн байна.

Тогтоолын 17 дахь заалт

Баар, зочид буудал, саун, цахим тоглоомын газар, интернэт төвүүдэд тавигдах стандарт, шаардлагыг шинэчлэх, хууль, хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагатай хамтран тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулах, хууль тогтоомж зөрчигчид хариуцлага хүлээлгэх ажлыг эрчимжүүлэх;

Цагдаагийн байгууллагаас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан “Хуулиа мөрдье-21”, “Хуулийн хэрэгжилт”, “Эмзэг цэг-хяналт шалгалт” зэрэг ерөнхий арга хэмжээний хүрээнд нийт 2,103 алба хаагч үүрэг гүйцэтгэж үүнээс офицер 710, цагдаа 1,025, олон нийтийн цагдаа 253, бусад төрийн байгууллагын 115 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр нэгдсэн үзлэг, шалгалтыг 83 удаа зохион байгуулж ажиллажээ.

Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг болон цахим тоглоом, интернэтийн үйлчилгээ эрхэлдэг газруудыг давхардсан тоогоор 24,070 аж ахуйн нэгж, 12,060 иргэнийг шалгажээ. Шалгалтад 3,155 баар, 3,734 караоке, 1,997 ресторан, 2,312 зочид буудал, 1,208 цахим тоглоомын газрыг хамруулсан бөгөөд хяналт шалгалтаар илэрсэн 1,412 зөрчилд 118.7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Үүнд Зөрчлийн тухай хуулийн 6.3 дахь хэсэгт зааснаар 271 хүн, хуулийн

этгээдийг 30.4 сая төгрөгөөр, мөн хуулийн 10.4 дэх хэсэгт зааснаар 1,011 хүн, хуулийн этгээдийг 68 сая төгрөгөөр, 6.5 дахь хэсэгт зааснаар 130 хүн, хуулийн этгээдийг 20.3 сая төгрөгөөр тус тус торгожээ.

Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 1,480 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд эрх зүйн мэдлэг олгох, холбогдох хууль тогтоомж, журмын талаар 25 удаагийн 46 цагийн сургалт зохион байгуулжээ. Мөн 685 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 475 шаардлага өгч, биелэлт үр дүнг тооцон ажиллажээ.

Зохион байгуулалттай бүлэг, мөрийтэй тоглоом, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2018 онд “Нийслэл”, “Хяналт-Сүлжээ”, “Хяналт”, “Шалгалт”, “Массаж”, “Цохилт”, “Тоглоом”, “Үргээлэг”, “Давалгаа”, “Хяналт-2” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, бусдыг зохион байгуулалттай биеийг нь үнэлүүлж байсан 79 саун, караоке бааранд Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” 18, 13 дугаар зүйлд заасан “Хүн худалдаалах” 62 хэрэг, нийт 80 хэрэг бүртгэлийн хэрэг үүсгэн шалгаснаас 11 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн, мөрдөн байцаалт явуулж, 4 хэргийг нь шүүхэд шилжүүлж, 40 хэрэг хэрэгсэхгүй болгож, 29 хэрэг ажиллагаанд байна. Уг арга хэмжээний хүрээнд 435 массажны газрыг шалгаж, 1,412 зөрчил илрүүлжээ. Массажист нэрээр биеийг нь үнэлүүлж байсан 428 охид, эмэгтэйчүүдийг тогтоосны 16 нь насанд хүрээгүй хүүхэд байв. Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнтэй хамтран 155 эмэгтэйг эрүүл мэндийн үзлэгт

хамруулахад 67.7 хувь нь бэлгийн замын халдварт өвчтэй, үүнээс 67.6 хувь нь тэмбүү, 12.3 хувь нь заг хүйтэн, 10.4 хувь нь трихомонази, 9.5 хувь нь мөөгөнцөр өвчтэй байх тул эрүүл мэндийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчилгээ хийлгүүлж, бүртгэл судалгаанд хамруулжээ. Зөрчлийн тухай хуулийн 6.18 дахь хэсэг “Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчсөн” заалтыг зөрчсөн 192 иргэнд 9.6 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Иймд баар, зочид буудал, саун, цахим тоглоомын газар, интернэт төвүүдэд тавигдах стандарт шаардлагыг шинэчлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулан, хууль тогтоомж зөрчигчид хариуцлага хүлээлгэх ажлыг эрчимжүүлж тодорхой үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Тогтоолын 18 дахь заалт

Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газруудыг илрүүлэх, зөрчлийг арилгуулах, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хүүхдийн эрхийг хангах, хараа хяналтгүй, цахим тоглоомд донтсон хүүхдийг илрүүлэх зорилгоор “Цахим тоглоом” хэсэгчилсэн

арга хэмжээг 2018 оны 2 дугаар сард зохион байгуулсан байна. Үүний хүрээнд цахим тоглоомын үйл ажиллагаа явуулдаг 60 газарт үзлэг шалгалт хийж, зөвшөөрөлгүй, стандартын шаардлага хангаагүй 33 газрын үйл ажиллагааг зогсоож, гурван газрын зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлж, 60 аж ахуйн нэгжид шаардлага, 76 аж ахуйн нэгжид зөвлөмж өгч, 12 хүүхдийг бүртгэлжүүлж хяналт тавин ажилласан байна.

Хүүхдийг осол гэмтэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх аян, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”, “Ухаалаг утасны хор нөлөө”, “Хүүхэд хамгаалал” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд Сонгинохайрхан, Багахангай, Багануур, Налайх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн 24 сургуулийн 3,038 хүүхдүүдийн дунд АХА тэмцээн, гар зургийн уралдаан зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр шторкийг цацан, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, брошурыг 10,000 хүнд хүргэж ажилласан талаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн мэдээлэлд дурджээ.²²⁵

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл Цагдаагийн ерөнхий газартай хамтран цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон интернэт орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, өсвөр насны хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил бусад эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хяналт тавих, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “Unfriend хөдөлгөөн”-ийг 2018 оны 9 дүгээр сард зохион байгуулжээ.

²²⁵ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 1/71 дүгээр албан бичиг.

Unfriend хөдөлгөөний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олны танил 150 хүнээр фэйсбүүк дэх ковер, фрэйм зураг солиулж, цахим гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд уриалсан пост нийтлүүлэх зэргээр цахим давалгааг өрнүүлжээ. Тус хөдөлгөөний хүрээнд 2018 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Төрийн ордны их танхимд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, оюутан, сурагчид зэрэг 800 хүн оролцуулсан “Таны хүүхдийг танихгүй хүмүүс хүмүүжүүлж байна” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг Улсын их хурлын дарга, Ерөнхий сайдад гардуулан өгсөн байна. .

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамаар дамжуулан оюутан, сурагчдад зориулж “Цахим орчны талаар таны мэдэхгүй үнэн” сэдэвт сургалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын 65 сургуулийн 72,751 сурагч, 15 их, дээд сургууль, коллежийн 2,385 оюутан хамруулжээ. Мөн оюутан, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор их, дээд сургуулиудын дунд аян өрнүүлж 16 сургууль бүтээл ирүүлснийг олон нийтийн хэрэгсэл буюу фэйсбүүк, инстаграм, твиттер хуудсаар сурталчлах ажлыг зохион байгуулж, урамшуулсан байна.

Фэйсбүүк дэх садар самуун сурталчилсан болон зохисгүй контент агуулсан групп, хуудсуудыг фэйсбүүк компанид мэдээлснээр (Report) уг контентыг хэсэгчлэн болон группийг бүхэлд нь устгуулах зорилготой “Хар жагсаалт” (Black list) групп үүсгэсэн бөгөөд 19,630 гишүүн идэвхтэй хандалт хийн дэмжин ажиллажээ.

Иргэд, олон нийтэд мэдээлэл олгох, хөдөлгөөнийг сурталчлах, өрнүүлэх ажлын хүрээнд 192,603 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тарааж олон нийтийн газар байршсан 220 LED дэлгэц, томоохон кино театруудаар видео контент түгээж 88

хулдаасан самбар байршуулсан байна. Үүрэн телефоны 4 оператороор дамжуулан хоёр удаагийн зорилтот мессэжийг хүргэн Univision, Skymedia, DDISH телевизэд хөдөлгөөнийг сурталчилсан баннер байршуулах ажлыг зохион байгуулжээ.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах хүрээнд 41 телевиз, 9 радиогоор 374 удаагийн нэвтрүүлэг, зочны цаг, хэлэлцүүлэгт алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдыг оролцуулж, мэдээ, мэдээлэл өгснийг 318,720 хүн үзэж, 8 сонинд 24, мөн 76 сайтад 45 мэдээ, мэдээлэл, сурвалжлага нийтлүүлсэн байна.

Тогтоолын 19 дэх заалт

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжийг байгуулан ажиллуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх ажилд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтныг оролцуулах;

Шинэчлэн найруулсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан цагдаагийн байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор цагдаагийн төв байгууллагын бүтцэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийг бий болгож, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын хариуцах ажлын чиг үүрэгт оруулсан байна. Тус нэгж нь Замын цагдаагийн албанд хэлтэс, Нийслэлийн цагдаагийн газарт 2 хэлтэс, Түр хамгаалах байранд 1,

Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Хэрэг бүртгэх албадад ажил хариуцсан албан хаагч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст ажил хариуцсан тус бүр 1–2 алба хаагчийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг батлан, тэдэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст 2016 оноос эхлэн 2 сэтгэл зүйчийг ажиллуулж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эрсдэлт нөхцөлд байгаа иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч хэвшжээ.

Түүнчлэн Нийслэлийн цагдаагийн газрын Түр хамгаалах байранд 2014 оноос эхлэн гурван нийгмийн ажилтныг тогтмол ажиллуулж, хамгаалах байранд ирж үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, нийгмийн үйлчилгээ шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж, сургалт зохион байгуулж, мэдээлэл өгч ажиллаж байна.

Тогтоолын 20 дахь заалт

Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран 2018 онд хүүхдийг тэвчишгүй хөдөлмөрөөс хөндийрүүлэх зорилгоор тандалт судалгааг хийсэн байна. Тандалтаар албан бус секторт нийт 495 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаагаас

бичил уурхайд 20, худалдаа үйлчилгээний захад 82, барилга угсралтын үйл ажиллагаанд 8, хөдөө аж ахуй, газар тариаланд 367, зам тээврийн салбарт 6, хог хаягдлын цэг болон гудамжинд худалдаа эрхэлж байгаа 12 хүүхэд байна. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг насаар нь авч үзвэл 5–9 настай 9, 10–14 настай 81, 15–17 настай 405 хүүхэд байгаагаас 83 эмэгтэй, 412 эрэгтэй хүүхэд ажиллаж байна. Эдгээр хүүхдийн 259 нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж, 236 хүүхэд нь сургууль завсардсан байна.

Дээрх мэдээллийн хүрээнд уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай ч иргэдийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд илтгэлд дурдсан санал, зөвлөмжийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Засгийн газарт холбогдох арга хэмжээ авахуулахаар чиглэл өгсөн билээ.

Энэхүү тогтоолоор хүүхдийн эрх, хөдөлмөрлөх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар Засгийн газарт өгсөн 36 заалт бүхий чиглэлийн хэрэгжилтийн байдлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон холбогдох яам, агентлагаас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан дүгнэхэд 15 заалт буюу 41.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 9 заалт буюу 25 хувь нь хэрэгжих шатандаа, 12 заалт буюу 33.4 хувь нь хэрэгжээгүй байна.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААР ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР ӨГЧ БУЙ САНАЛ

Нэг. Хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжих чиглэлээр

1. Боловсролын салбарын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр болон “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн уялдуулдаг байх;
2. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, үнэлэх, тайлагнах чиг үүргийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулах, тодорхой бүтэц, нэгж байгуулах зэргээр хүний эрхийн боловсрол, сургалтын үндэсний тогтолцоог бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьдаг болгох;
3. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх зорилго бүхий бие даасан хичээлийг бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын шатанд бий болгож, бусад сургалтын хөтөлбөрийн агуулгыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинэчлэн боловсруулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгох;
4. Хүний эрхийн боловсрол, сургалтын үндэсний тогтолцоог бүрдүүлэх зорилгоор дараах асуудлыг тусгасан шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах; Үүнд:

- Дээд боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, стандарт шаардлагад Хүний эрхийн боловсролын асуудлыг тусган, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хууль зүйн их, дээд сургуулиудад “Хүний эрх” хичээлийг заавал үзэх мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтад оруулах, эрх зүйн бакалавр, магистр, докторантурын сургалтын хөтөлбөрийн агуулгыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинэчлэн боловсруулах;
- Дээд боловсролын сургалтын байгууллагууд нь хүний эрхийн багш, судлаачдыг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах зорилгоор хүний эрхийн чиглэлээр магистр, докторын сургалтын хөтөлбөр, салбар дундын судалгаа, сургалтын хөтөлбөр бий болгож, хэрэгжүүлэх.
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн багшийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан захиалгаар багш бэлтгүүлэх, тэтгэлэг олгож болохоор заасныг үндэслэн бүх шатны боловсролын тогтолцоонд “Хүний эрх” хичээл заах багш нарыг бэлтгэж, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулахыг дэмжих;

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар

5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан бий болгох,

мэдээлэл тогтмол цуглуулах тогтолцоог ажиллуулах, судалгаа, мэдээллийг шийдвэр гаргахад ашиглах;

6. Эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, нийгмийн загварын тухай сургалтыг оруулж, үе шаттай зохион байгуулах;
7. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;
8. Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийн зохицуулалттай нийцүүлэх;

Гурав. Ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар

9. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Ажил мэргэжил, хөдөлмөрийн харилцаанд дарамтыг хориглох” заалтын хүрээнд ажлын байран дахь бэлгийн дарамтыг хориглох, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох зохицуулалтыг тусгах;
10. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчсөн (хүнд хохирол учруулсан, ажиллах боломж нөхцөлөөр барьцаалан дарамтлах, байгууллага, ажил олгогч ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх хэм хэмжээг дотоод журамдаа тусгах, хэрэгжүүлээгүй, эсвэл журмаа зөрчсөн тохиолдолд) этгээдэд болон ажлын байран дахь бэлгийн дарамт

үйлдэгчид хариуцлага тооцох арга хэмжээг Зөрчлийн тухай хуульд тусгах;

11. Ажлын байран дахь бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
12. Ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчдод сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх, ажлын байрны баталгааг хангах, хохирогчийг хамгаалах зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах;
13. Төрийн албаны тухай тухай хуулийн шинэчилсэн найруулгын 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх хэсгийн болон 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсгийн заалт зөвхөн төрийн захиргааны болон тусгай албан хаагчид хамаарахаар ялгамжтай тусгасныг өөрчилж төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагчийг мөн адил хамааруулж хуульчлах, хэрэгжилтийг хангах;

Дөрөв. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар

14. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцын Нэмэлт Протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагыг нэн даруй байгуулах;
15. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан байгууллагыг нэн даруй байгуулах;
16. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц болон бусад олон улсын гэрээнд заасан эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллагын ажилтан, алба хаагчдад олгож, үйл ажиллагааны нэг үндсэн зарчим болгож, дадал эзэмшүүлэх.

Тав. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлаар

17. Алба хаагчдын ажиллах орчин нөхцөл, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийн хэрэгжилтийг сайжруулах, тэдний амь насыг болзошгүй эрсдлээс хамгаалах үүднээс аврах ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангахад шаардагдах төсвийг нэн даруй шийдвэрлэх;
18. Албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирсон алба хаагчид нэг удаагийн тусламж олгоод орхилгүй эрүүл мэндээ нөхөн сэргээхэд нь шаардлагатай эмчилгээ, оношлогооны зардлыг төрөөс бүрэн хариуцдаг болох;
19. Хуульд зааснаас илүү цагаар ажиллаж байгаа алба хаагчдын илүү цагийн болон нийтээр амрах баярын өдөр, амралтын өдрүүдэд ажилласны нэмэгдэл хөлсийг 2019 оноос мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуульд заасны дагуу тухай бүр олгож хэвших;
20. Алба хаагчдын дүрэмт хувцсыг заасан хугацаанд олгох, дүрэмт хувцасны чанар, хүртээмжийг сайжруулахад шаардагдах төсвийг батлах;
21. Алба хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүний эрхийн сургалтыг тусгах, алба хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг үр дүнтэй, тогтмол хэрэгжүүлэх.

Зургаа. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны асуудлаар

22. Жендэрийн салбар зөвлөл, салбар хороодын жендэрийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах, гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлох;
23. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад жендэрийн асуудал хариуцсан ажилтантай болох;
24. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байх;
25. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4.б–д “жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал” гэснийг хасах.

“Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэнэ.”

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн заалт

